

Лиэxorнa



**Манай түүхийн
эгэл даруухан
баатрууд, х. 16,
62, 65**

**Жинхэнэ эрх чөлөөг
хэрхэн эдлэх вэ? х. 32**

**Бидний зарчимч байдал
үйл ажиллагаанд, х. 40, 48**

**Гэр бүлийнхээ эрх чөлөөний
тугийг хий, х. 60**



“Өнөө үеийн
Сүмийн
анхдагчид
улс үндэстэн
бүрт амьдар-
даг бөгөөд
тэдний итгэл
бишрэл, тэс-
вэр хатуужил,
золиослолын
түүхүүд Бур-
ханы хаант ул-
сын хожмын
үеийн түү-
хэнд ихээхэн
хувь нэмэр
оруулж бай-
гаа билээ.”

Тэргүүн Зөвлөлийн хоёр-
дугаар зөвлөх, Ерөнхий-
лөгч Диетер Ф.Угдорф,
“Бидний өвөг дээдсийн
итгэл,” *Лиахона*, 2008
оны 5-р сар, 70.

Зүүн талд: Тайрей Ма-
дера Расоаммпианина
Мадагаскарын Сүмийн
анхны гишүүдийн дунд.



ЗАХИАСУУД

- 4 Тэргүүн Зөвлөлийн захиас бичиг: Дэлхийд өнөөдөр анхдагчид хэрэгтэй байна**
Ерөнхийлөгч Томас С.Монсон
- 7 Айлчлагч багшийн захиас бичиг: Сайн мэдээнээс суралцах ба заах нь**

ОНЦЛОХ ӨГҮҮЛЛҮҮД


- 14 Бурханд боломжгүй юм гэж нэг ч байхгүй**
Санг-Ик Хан
Би 53 настай байхдаа хуулийн сургуульд ороод, Их Эзэнд төгс найдвар тавьсан үед л амжилт олж чадна гэдгийг ойлгосон юм.
- 16 Анхдагчдын итгэл ба төсвэр хатуужил тэр үед болон өнөөдөр**
Ахлагч М.Рассел Баллард
Өнгөрсөн үеийн анхдагчид дааж давшгүй хүнд сорилт бэрхшээлүүдийг даван туулсан тухай гэрчлэл бидний зүрх сэтгэлд тэднийхтэй адилаар шатах гал лугаа адил төөнөдөг билээ.
- 22 Гайхамшгуудын Бурхан: Словакийн Гэгээнтнүүд Шеффилдэд**
Ахлагч Эрик В.Копишкэ
Английн Шеффилд дэх эдгээр гэгээнтнүүдийн итгэл өнөө цагийн гайхамшигийг авчирч байна.

ХЭСГҮҮД

- 8 Дөрөвдүгээр сарын Чуулганы тэмдэглэлээс**
- 10 Бид юунд итгэдэг вэ? Их Эзэн дуудсан хүнээ тэнцэхээр болгодог**
- 12 Сүмд үйлчилсэн нь: Телевиз ба сүнслэг байдал**
Кейси Кронин
- 13 Залуучуудын бат бөх байдлын төлөө товхимлоос заах нь: Үнэнч шударга байдал**
- 28 Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн дуу хоолой**
- 74 Сүмийн мэдээ**
- 80 Биднийг дахин уулзтал: Итгэл найдварын замаар хамтдаа алхсан минь**
ЛаРин Портер Гаунт

ХАВТСАН ДЭЭР

Нүүрэн талд: *Дуртай түүхүүд*, Майкл Т.Малм.
Ар талд: Гэрэл зургийг Крейг Даймонд © IRI.
Нүүрэн талын хавтасны дотор талд: Гэрэл зургийг Ричард М.Ромни.



32 Үүрд мөнхийн төлөө амьдрах нь

Ахлагч Кейт К.Хилбиг

Гэр бүлтэйгээ селестииел дэлхийд үүрд хамт амьдрах ирээдүйгээ ой ухаандаа төсөөлөн бодохыг би та бүхнээс хичээнгүйлэн гуйж байна. Бид тэрхүү хязгааргүй алдар суу хийгээд давуу байдлыг бүрэн ухааран ойлгож чадахгүй.

36 Агуу итгэлийн туршлага

Мэллиса Зентено

Залуучууд хоорондоо холбоотой байхад зарим бэрхшээл учирч байгаа ч гэсэн итгэлээ хэрхэн бэхжүүлж байгаа тухайгаа хуваалцдаг.



Энэхүү дугаарт нуусан Лиахонаг олоорой. Сануулга: Эрика мэддэг

40 Итгэл үнэмшил ба өрөвч сэтгэл

Ахлагч Жеффри Р.Холланд

Бусдыг шүүх нь хэзээ зөв байдаг вэ? Бид бусдын сонгох эрхийг хүндэтгэхийн сацуу жишгүүдээ хэрхэн хамгаалдаг вэ?

44 Өөрийгөө уучлахуй

Давид Диксон

Зарим хүмүүс өөрийгөө уучлагдахгүй гэж боддог байж болох юм. Гэвч Аврагчийн Цагаатгал хязгааргүй бөгөөд бүх хүмүүст боломжтой юм.

47 Хар тэмдгийг ч арилгаж болно

Дани Дунавей Рован

Би гараа өвдтөл үрсэн ч хар зураасууд нь арилаагүй үлдсэн байв.

48 Залуучуудын бат бөх байдлын төлөө: Үнэнч шударга байдал

Ахлагч Бага Кристоффел Голден

50 Шударгаар буцааж өгсөн нь

Валерий Бест

Миний цүнхэнд хаанаас ч юм бүү мэд орчихсон бугуйвчийг би харлаа. Хэрэв үүнийг буцааж өгөхийг хойшлуулбал эндээ хэр зэрэг удаан байх бол?

52 Гэрээнүүд дэх хүч

Гэрээ бол хоёр талын амлалтаас илүү чухал зүйл. Энэ бол хүч чадал, аюулгүй байдал, амар амгаланг агуулдаг амлалт юм.

54 Хамгийн сайхан гэр бүлийн үдшүүд

56 Ариун сүмийн дэргэд өнгөрүүлсэн хэдэн зун

Дэвид Исаксен



57 Гэр бүлийн үдшийн дугуй

58 Охиныг авраарай!

Хейди С.Свинтон

Ерөнхийлөгч Томас С.Монсон бусад тусалсан үедээ санаа сэтгэл нь хамгийн сайхан байдгийг мэдсэн ажээ.

60 Хүүхдийн Хэсгийг гэртээ авчрах нь: Гэр бүл бол Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний нэг хэсэг

62 Бошиглогчийн мөрөөр: Миссурид тохиолдсон хүнд сорилтууд

Женнифер Мадди

64 Бидний хуудас

65 Онцгой гэрч: Гэр бүлийн түүхийн ажил яагаад маш чухал байдаг вэ?

Ахлагч Давид А.Беднар

66 Хивсний түүх

Кей Тимпсон

Кати, Нана хоёр хамт ажиллах үедээ түүхүүд хуваалцанаар жижиг хивс нэхэхээс илүү чухал үйлсийг бүтээжээ.

68 Гэр бүлийн түүхээсээ хуваалц

Гэр бүлтэйгээ түүхүүд хуваалцаж, ярилцахад энэ үйл ажиллагааг ашигла.

69 Сайн байна уу? Би Эл Салвадорын Эрика байна

70 Бага насны хүүхдүүдэд зориулав

81 Бошиглогчийн хөрөг: Иосеф Ф.Смит

2013 ОНЫ ДОЛДУГААР САРЫН ДУГААР 14 НО. 4 ЛИАХОНА 10787 363

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн
Сүмийн олон улсын сэтгүүл

Тэргүүн Зөвлөл: Томас С.Монсон, Хенри Б.Айринг,
Дийтер Ф.Угдорф

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга: Бойд К.Пакер,
Л.Том Перри, Рассел М.Нелсон, Даллин Х.Өхүс,
М.Рассел Баллард, Ричард Г.Скотт, Роберт Д.Хейлс,
Жеффри Р.Холланд, Давид А.Беднар, Квинтин Л.Кук, Д.Тодд
Кристоферсон, Нийл Л.Андерсен

Эрхлэгч: Крейг А.Кардон

Зөвлөхүүд: Шэйн М.Боуэн, Брэдли Д.Фостер,
Бага Кристоффел Гоулдэн, Энтони Д.Пэркинс

Удирдах захирал: Дэвид Т.Варнэр

Гэр бүл болон гишүүдийн тусламжийн захирал:
Винсент А.Ваун

Сүмийн сэтгүүлийн захирал: Алан Р.Лоиборг

Бизнесийн менежер: Гарфф Каннон

Гүйцэтгэх редактор: Р.Вал Жонсон

Гүйцэтгэх захирлын туслах: Раян Карр,
ЛаРин Портер Гаунт

Хэвлэлийн туслах: Мэлисса Зентено

Редакцийн баг: Сюзан Барретт, Дэвид Диксон,
Давид А.Эдвардс, Маттью Д.Флиттон, Минди Рая Фриедман,
Лори Фүллер, Гарри Х.Гарфф, Женифер Грейс Жөүнс,
Хайкари Лофтус, Майкл Р.Моррис, Ричард М.Ромни, Пол
ВанденБерг, Жюлия Вудбери

Зураглал чимэглэлийн удирдагч менежер:

Ж.Скотт Кнудсен

Зураглал чимэглэлийн удирдагч: Тэдд Р.Петрсон

Уран бүтээлийн ажилтнууд: Жанетт Эндрюс,
Фэй П.Андрус, С.Кимбол Ботт, Томас Чарлд, Керри Линн
С.Херрин, Коллийн Хинкли, Эрик П.Хонсен, Скотт М.Моои,
Брэд Тиаре

Оюуны өмчийн зохицуулагч: Жэйн Анн Петрс

Хэвлэлийн захирал: Жэйн Анн Петерс

Хэвлэх баг: Кевин К.Банкс, Конни Бөүторп Бриж, Жүүли
Бурдетт, Браян У.Гиги, Дэнис Көрби, Жинни Ж.Нилсон, Гэйл
Тэйт Рафферти

Хэвлэлийн захирал: Крейг К.Седвик

Хуваарилалт хариуцсан захирал: Эван Ларсен, Нэгдсэн
Улс, Канадаас бусад орнууд дахь захиалга болон үнийн
талаар орон нутгийн Сүмийн хангамжийн төв болон тойрог,
салбарынхаа удирдагчтай холбоо барина уу.

Гар бичмэл болон асуултаа интернет вэбсайт
liahona.lds.org yyy; шуудангаар Liahona, Rm. 2420,
50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150-0024, USA
хаягаар; эсвэл э-мэйлийн: liahona@ldschurch
.org хаягаар ирүүлнэ үү.

Лиахона нь (Мормоны Номон дахь утгаараа бол "луужин"
буюу "заллагч") албани, англи, армен, бислам, болгар,
вьетнам, гаити, герман, грек, дани, индонез, ирланд, испани,
итали, камбож, кирибати, латви, литва, малагаш, маршалл,
монгол, нидерланд, норвеги, орос, польш, португали, румын,
свахили, самоа, себуано, солонгос, тагалог, тай, тахити,
тонга, украин, унгар, урду, фижи, фин, франц, хорват,
хятад, хятад (хялбаршуулсан), чех, швед, эстони, япон хэлээр
нийтлэгддэг. (Жилд нийтлэгдэх дугаарын тоо улс бүрд өөр
байна.)

© 2013 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан.
Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

Лиахона дахь сэдэв, үзүүлэн, материалуудыг онцгой
тохиолдолд арилжааны бус зорилгоор сүм болон гэрт
ашиглахын тулд хувилж болно. Урлагийн бүтээлийг
хуулбарлахыг хориглосон бол үзүүлэнг хувиан олшруулж
болохгүй. Зохиогчийн эрхийн талаарх асуултаа Intellectual
Property Office, 50 E. North Temple St., Salt Lake City,
UT 84150, USA хаягаар; эсвэл электрон шуудангийн:
cor-intellectualproperty@ldschurch.org хаягаар ирүүлнэ үү.

For Readers in the United States and Canada:

July 2013 Vol. 14 No. 4. LIAHONA (USPS 311-480) Mongolian
(ISSN 1525-7584) is published six times a year (January, April,
June, July, October, and December) by The Church of Jesus
Christ of Latter-day Saints, 50 E. North Temple St., Salt Lake City,
UT 84150. USA subscription price is \$5.00 per year; Canada,
\$6.00 plus applicable taxes. Periodicals Postage Paid at Salt Lake
City, Utah. Sixty days' notice required for change of address.
Include address label from a recent issue; old and new address
must be included. Send USA and Canadian subscriptions to Salt
Lake Distribution Center at address below. Subscription help
line: 1-800-537-5971. Credit card orders (Visa, MasterCard,
American Express) may be taken by phone. (Canada Poste
Information: Publication Agreement #40017431)

POSTMASTER: Send all UAA to CFS (see DMM 707.4.12.5).
NONPOSTAL AND MILITARY FACILITIES: Send address changes
to Distribution Services, Church Magazines, P.O. Box 26368,
Salt Lake City, UT 84126-0368, USA.

Гэр бүлийн үдшийн санаанууд

Энэхүү дугаарт гэр бүлийн үдэшт ашиглах өгүүлэл, үйл ажиллагаануудыг бичсэн байгаа.
Зарим жишээг дор харуулав.



ГЭРЛ ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ КРЕЙГ ДАЙМОНД © IN

“Шударгаар буцааж өгсөн нь” хуудас 50:

Та гэр бүлийнхээ хамт энэ түүхийг уншсаны дараа youth.lds.org-аас “Honesty: You Better Believe It!” (англи, испани, португаль хэл дээр байгаа) дүрс бичлэгийг татаж аван үзэж болно. Гэр бүлийн гишүүд энэ түүхээс эсвэл дүрс бичлэгээс сурч мэдсэн зүйлээ хуваалцаж болно. Та бас *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимлоос үнэнч шударга байдлын тухай уншиж болно (хуудас 19). Шударга зан чанар нь соригдож болох нөхцөл байдлуудын тухай үйл ажиллагааг гэр бүлийн гишүүд бодож олж болно. Эдгээр нөхцөл байдлуудыг зурвас цаасан дээр бичиж, аяган дотор хийгээд, хүн бүрээр ээлжлэн сугалуул. Хүн бүрээр цаасан дээр бичсэн нөхцөл байдлыг уншуулж, эдгээр нөхцөлд шударга байхын тулд юу хийх ёстойг яриул.

“Хивсний түүх,” хуудас 66: Энэ түүхэнд Кати эмээ Нанагаасаа залуу байхдаа гэр

бүлийнхээ хамт юу хийх дуртай байсныг нь асууж байна. Тэд юу хийх дуртай байсан гэж Нана эмээ хэлсэн бэ? Нана эмээ дараа нь Катид хивс нэхэхийг зааж, хоёул нийлэн сайхан дурсамжуудыг бий болгожээ. “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг”-ийн долдугаар догол мөрийг уншихыг бод. Аз жаргалтай гэрлэлт болон гэр бүлүүд хэрхэн бий болж, төлөвшдөг гэж энд өгүүлсэн байна вэ? Эдгээр санаануудын нэг болох өрөвч сэтгэл сэдвийг сонгож, гэр бүлээрээ ярилц. Энэ сэдвээр ярилцахын тулд та гэр бүлийн гишүүдээсээ бие биедээ болон бусдад хэрхэн өрөвч энэрэнгүй хандах арга замуудыг жагсаан бичихийг хүсэж болно. Та энэ долоо хоногт илүү өрөвч энэрэнгүй байх зорилгыг тавьж, энэ зорилгоо хэрхэн хэрэгжүүлснийг дараагийн гэр бүлийн үдшээр ярилц. Та “Families Can Be Together Forever (Гэр бүлүүд үүрд хамт байж чадна)” дууллыг дуулж хичээлээ төгсгөж болно (*Hymns*, no. 300).

ТӨРӨЛХ ХЭЛЭЭРЭЭ

Лиахона болон Сүмийн бусад материалуудыг олон хэлээр www.languages.lds.org -аас үзэж болно


ЭНЭХҮҮ ДУГААРЫН СЭДВҮҮД

Тоонууд нь өгүүллийн эхний хуудсыг зааж байгаа.

Авралын төлөвлөгөө, 30
Анхдагчид, 4, 16, 62, 80
Ариун сүм, 29, 56
Бишопууд, 12
Бэрхшээл, 4, 16, 80
Гэр бүл, 16, 29, 30, 60, 66
Гэр бүлийн түүх, 65, 69
Гэр бүлийн үдэш, 3, 54, 57
Гэрлэлт, 32, 36
Гэрээнүүд, 52

Дуулгавартай байдал, 40
Ерөнхий чуулган, 8
Есүс Христ, 70
Ёслолууд, 29
Жишгүүд, 4
Заасан зүйл, 7, 13
Зарлигууд, 40
Зорилго, 14
Итгэл, 14, 36
Наманчлал, 47
Номлолын ажил, 22
Смит, Иосеф Ф., 81

Сүмийн дуудлагууд, 10
Сүмийн түүх, 4, 16, 62, 80, 81
Уучлал, 44
Үйлчлэл, 12
Үлгэр дууриал, 16
Хэтийн төлөв, 32
Хүндэтгэлийн өдөр, 28
Шударга байдал, 13, 31, 48, 50
Шүүх нь, 40
Эцэг эх болох нь, 13, 32



Ерөнхийлөгч Томас С.Монсон

ДЭЛХИЙД ӨНӨӨДӨР анхдагчид хэрэгтэй байна

Олон хүний хувьд анхдагчдын хүнд бэрх аян 1847 онд Науву, Көртланд, Фар Вест юм уу Нью-Йоркоос биш харин алс холын Англи, Шотланд, Скандинави эсвэл Германаас эхэлсэн юм. Эцэг эхчүүдийг нь гэр бүл, найз нөхөд, ая тухтай амьдрал, аюулгүй байдлаа орхиход өдөөн түлхсэн тэрхүү эрч хүчтэй итгэлийг балчирхан үрс нь яахан бүрэн ойлгох билээ.

Тийнхүү балчирхан үр нь, “Яагаад бид гэр орноо орхиж байгаа юм бэ? Хаашаа явж байгаа юм бэ?” хэмээн асууж байсан биз ээ.

“Хонгорхон үр минь, хурдлаарай, бид Бурханыхаа хот Сион руу явж байна шүү дээ.”

Ая тухтай, аюулгүй гэр орон, амлагдсан Сионы хооронд хүрхрэн давалгаалах Атлантын догшин далай хөндөлсөнө. Тэрхүү их далайг гатлах үе дэх хүмүүний зүрхэнд шар ус хуруулсан айдсыг хэн дүрсэлж чадах билээ? Сүнсний намуухан шивнээгээр өдөөгдөж, энгийн атлаа зүрх сэтгэлд шингэсэн итгэлээр жигүүрлэсэн анхдагч Гэгээнтнүүд Бурханд итгэн, алс холын аяндаа далайгаар хөвсөн юм.

Тэд эцэстээ Наувуд хүрсэн ч дахиад хүнд хүчир аян хийх хэрэгтэй болсон билээ. Наувугаас Солт Лейк хот хүртэлх замын дагуу булшны цайвар ногоон чулуу хааяагүй харагдана. Энэ бол анхдагчдын төлсөн төлөөс. Тэдний бие амар амгаланд оршуулагдсан ч нэр нь үүрд мөнхөд оршсоор байх болно.

Холын аянд ядарсан шарууд удаахан алхалж, тэрэгний дугуй чихрана. Хүдэр чийрэг эрсийн хүч тамир шавхагдаж ядарчээ. Бөмбөрийн дуу нижигнэн, цөөвөр чоно улина. Гэвч итгэлээр жигүүрлэж, шуурганд хөөгдсөн анхдагчууд аянаа үргэлжлүүлсээр.

*Учрах бүхнээс эс халиран ирцгээгээч,
Урамтай аялацгаая, аялах зам тань*

Бартаатай санагдавч,

Амьдрал тань ивээгдэнэ . . .

Зүгээр бүгд сайхан байна! Бүгд сайхан байна! ¹

Анхдагчид Их Эзэний дараах үгсийг үргэлж санадаг байлаа: “Миний хүмүүс тэдэнд миний бэлтгэсэн алдар суу, бүр Сионы алдар сууг хүлээн авахад бэлтгэгдэхийн тулд бүх зүйлээр соригдох ёстой.”²

Цаг хугацаа улиран одох тусам бид юмсыг мартаж, хүнд хүчир аян замдаа нэргүй олон булшийг нулимс асгаруулан үлдээж, гай зовлон туулсан хүмүүст талархах бидний талархал бүдгэрч мэднэ. Харин өнөөгийн сорилт бэрхшээлүүдийн тухайд гэвэл? Бид хад чулуут бартаат зам, уулын эгц цавчим хяраар аялах шаардлагатай юу? Гүн хавцлуудыг гаталж, шинээр зам гарган, гүнзгий уст гол мөрнүүдийг гатлах хэрэгтэй юу? Эсвээс биднийг залгихаар заналхийлж буй аюулаас холуур биднийг амар амгалан Сион руу удирдах анхдагчдын сүнс бидэнд амин чухал хэрэгтэй юу?

Дэлхийн II дайн дууссанаас хойших хэдэн арван жилийн дотор ёс суртахууны жишгүүд улам доошилсоор байлаа. Гэмт хэрэг байнга өсч, нийгэмд хүмүүс бие биетэйгээ улам бүр ичгүүр сонжуургүй харьцдаг болж байна. Олон хүмүүс сүйрэлд аваачих түр зуурын жаргалтай агшны төлөө мөнхийн баяр баясгалангаа золиосолж байна. Тийнхүү амар амгалан биднээс холддог.

Грек, ромчууд иргэншээгүй дэлхийд үлэмж давамгайлах үүрэгтэй байсан ч тэрхүү агуу ялалт хэрхэн төгссөнийг мөн тэдний залхуу хойрго, сул дорой байдал эцэстээ тэднийг хэрхэн сүйрэлд хүргэснийг бид мартдаг. Эцэстээ тэд эрх чөлөөнөөс илүүтэйгээр аюулгүй байдал, ая тухтай амьдралыг эгээрэн хүсдэг болсон ч ая тухтай амьдрал, аюулгүй байдал, эрх чөлөө бүгдийг нь алдсан билээ.



Сатаны уруу татаалтуудад бүү авт, харин үнэний төлөө бат зогс. Хэзээ ч төгсөшгүй баяр баясгалангийн төлөөх эрэл хайгуулаар сэтгэл хөөрөл хийгээд нүгэл хилэнц дотроос бод-галийн хүслийг хангана гэж байдаггүй. Нүгэл хилэнц хэзээ ч ариун журам руу хөтөлдөггүй. Үзэн ядалт хэзээ ч хайрыг хөхиүлэн дэмждэггүй. Аймхай хулчгар зангаас хэзээ ч зориг гардаггүй. Эргэлзээ хэзээ ч итгэлд дэм болдоггүй.

Ариун явдал, шударга зан чанар, Бурханы зарлигуудад дуулгавартай байх явдлыг доог тохуу болгодог мунхаг хүмүүсийн доромжлон, тохуурхсан үгсийг хүлээн тэвчих нь зарим хүмүүст хэцүү байдаг. Харин дэлхий аль нэг зарчимд дуулгавартай байх явдлыг үргэлж ач холбогдолгүй зүйл гэж үздэг. Ноаг хөвөгч авдар барих заавар авсан үед мунхаг хүмүүс цэлмэг тэнгэрийг хараад шоолон инээлдэж, бороо орж эхлэх хүртэл итгэлтэй хүмүүсийн талаар хүндэтгэлгүй үг ярьж байсан шүү дээ.

Бид энэхүү чухал сургамжаас дахин дахин суралцах ёстой бус уу? Цаг үе өөрчлөгддөг харин үнэн өөрчлөгддөггүй. Бид өнгөрсөн үеийн туршлагуудаас суралцахгүй

бол тэр үеийн хүмүүст тохиолдсон гай зовлон, сэтгэлийн шаналал бидэн дээр давтагдах нь зайлшгүй. Авралын төлөвлөгөөний эрхэм зорилгыг үзэн ядагч хорт могойг биш, харин эхлэлийг төгсгөлөөс хойш мэддэг бөгөөд тэрхүү агуу төлөвлөгөөг зохион бүтээгч Их Эзэнээ дуулгавартай дагах мэргэн ухаан бидэнд байхгүй гэж үү?

Нэгэн толь бичигт анхдагч гэдэг үгийг “бусад хүмүүсийн дагах замыг бэлтгэхээр өмнө нь явдаг хүн” гэж тодорхойлсон байдаг.³ Бид өмнөх үеийн анхдагчдын зан төлвийг

тодорхойлдог байсан эрэлхэг зориг, зорилгоо хэрэгжүүлэхийн төлөө тууштай тэмцдэг чанарыг өөртөө бий болгон хөгжүүлж чадах уу? Та нар бас би жинхэнэ ёсоор анхдагчид байж чадах уу?

Бид анхдагчид байж чадна гэдгийг би мэднэ. Ай, дэлхийд өнөөдөр анхдагчид хэчнээн их хэрэгтэй байна вэ! ■

ЭШЛЭЛ

1. “Ирцгээ, ирцгээ, Гэгээнтнүүд ээ,” *Сүмийн дуулал болон хүүхдийн дуу*, х. 30.
2. Сургаал ба Гэрээ 136:31.
3. *Oxford English Dictionary*, 2nd ed. (1989), “pioneer.”

ЭНЭХҮҮ ЗАХИАСААС ЗААХ НЬ

Гэрийн багш нар “сануулж, тайлбарлаж, ухуулж, мөн зааж, мөн Христэд ирэхэд бүхнийг урьдаг байх ёстой”-г (С ба Г 20:59) судруудад тайлбарладаг билээ. Ерөнхийлөгч Монсоны захиаст агуулагдсан сэрэмжлүүлэг ба урилгыг айлчилж очдог хүмүүстээ онцлон хэлэх талаар эргэцүүлэн бодоорой. Зөв шударга үлгэр жишээг танин мэдэж дагах, мэхлэгдэхээс зайлсхийх, бусдын алдаанаас суралцах арга замуудын тухай та нар ярилцаж болно. Тэд хэрхэн өнөө үеийн анхдагчид байж болохыг заадаг хүмүүсээсээ асуу.

Хүүхдүүд энэ дугаарын 62-р хуудсан дээрх “Тэдний замаар” цувралыг уншиж, анхдагчдын талаар илүү их зүйлийг мэдэж болно.

Итгэлээр жигүүрлэн

Магги Өөрл

Анхдагчдын олон жилийн тэртээ амьдарч байсан АНУ-ын Небраскийн Винтер Квотерсын газар дээр алхалж явснаа би хэзээ ч мартахгүй.

Нүдэнд минь нулимс дүүрч, нүд бүрэлзлээ. Нэг хөшөө харагдсан ч чухам ямар хүмүүсийнх болохыг таньсангүй. Нулимсаа арчаад хартал, үлэмж их уй гашуу нүүрэнд нь тодрох эрэгтэй, эмэгтэй хоёр хүн харагдав. Бүр тулж очоод харвал, тэдний хөлд нэгэн нялх хүүхдийн булш байлаа.

Нялх хүүхдийн булш уйтгар гуниг, уур хилэн, талархал, баяр хөөр гээд сэтгэлийн олон хөдөлгөөнийг надад нэгэн зэрэг төрүүлэв. Би Гэгээнтнүүдийн мэдэрч байсан сэтгэлийн эмзэглэлийг өөрөөсөө холдуулахыг хичээхийн хамт сайн мэдээний төлөө тэдний золиосолсон зүйлд талархалтай байлаа.

Тэнгэрлэг Эцэг хүүхдүүддээ сайн мэдээг

өгсөн бөгөөд тэд хүслийнхээ дагуу үүнийг хүлээн авах эсэхээ шийдэхэд сонгох эрхээ ашиглах боломжийг тэдэнд олгосныг ойлгоход Винтер Квотерс дахь туршлага маань надад тусалсан юм. Сайхь нялх хүүхдийн эцэг эх хоёр илүү амар хялбар замыг сонгож болох байсан. Бошиглогчийг дагаж, сайн мэдээгээр амьдрах нь хорвоог орхисон өөдсийн чинээхэн үрээ оршуулаад, аян замаа цааш хөөхийг эдгээр анхдагчдаас шаардсан юм. Тэд сайн мэдээг амьдралдаа хүлээн авч, тулгарах сорилт бэрхшээлүүдийг даван туулахаар сонгосон юм. Гэгээнтнүүд сайн мэдээнд чин үнэнч байж, хүнд хүчир аянаа үргэлжлүүлэх шийдвэр төгс байсан нь гэрэлт ирээдүйнхээ төлөөх итгэл, найдвараар жигүүрлэн урагш тэмүүлж байсных, Их Эзэн өөрсдийг нь мэдэж байгаа бөгөөд зовлон зүдгүүрийг нь нимгэлэх болно гэдэгт итгэлтэй байсных юм.

Энэхүү өгүүллийн зохиогч АНУ-ын Хойд Каролинд амьдардаг.



ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ

Анхдагч бай

Анхдагч гэдэг бол бусад хүмүүст дагах ёстой замыг нь харуулж өгдөг хүн юм гэж Ерөнхийлөгч Монсон хэлжээ. Энэ зураг дээрх хүүхдүүд зөв зүйлийн төлөө зогсож, бусад хүмүүст анхдагч байхын тулд юу хийж болох вэ? Зургуудын доорх зайд хариултаа бич.



Энэ материалыг залбирч судлан гэрт нь очиж заадаг эгч нартайгаа аль болох ойлгомжтойгоор ярилц. Эгч нарыг хүчирхэгжүүлэх болон Нийгмийн Халамжийн Бүлэг амьдралд тань идэвхтэй үүрэг гүйцэтгэхэд туслах асуултуудыг асуу. Нэмэлт мэдээллийг reliefsociety.lds.org-аас үзнэ үү.

Сайн мэдээнээс суралцах ба заах нь

Есүс Христ өндөр үр чадвартай багш байсан юм. Тэрээр “хуран цугларагсдын дундах эмэгтэйчүүдэд, мөн тэдэнд тус бүрт нь, гудамжинд болон далайн эрэг дээр бас гэр оронд нь заадаг байлаа. Тэр тэдэнд хайрын нинжин сэтгэлээр хандаж, тэднийг болон гэр бүлийн гишүүдийг нь эдгээдэг байсан.”¹

Тэрээр Марта, Мариа хоёрт зааж, “тэднийг Өөрийнхөө шавь болж, авралыг хүртэх, тэднээс хэзээ ч зайлуулагдашгүй ‘сайныг сонгон авахад’ [Лук 10:42] урьсан билээ.”²

Их Эзэн хожмын үеийн судруудад “хаант улсын сургаалыг та нар бие биендээ заа” (С ба Г 88:77) хэмээн бидэнд зарлиг болгосон юм. Хүүхдийн Хэсгийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлийн хоёрдугаар зөвлөх Черил А.Эсплин сургаалаас суралцах болон заах тухай ийн хэлжээ, “Сайн мэдээний сургаалуудыг бүрэн ойлгож сурах нь насан туршийн үйл явц бөгөөд ‘шат шатаар, дүрэм дүрмээр, энд бяцхан мөн тэнд бяцханаар’ (2 Нифай 28:30) ирдэг.”³



Бид судалж, суралцан, залбирснаар бидний захиасыг “хүмүүний үрсийн [мөн эмэгтэйчүүдийн] зүрх сэтгэлд хүргэх” (2 Нифай 33:1) Ариун Сүнсний хүчээр зааж чадна.

Судруудаас

Алма 17:2–3; 31:5;

Сургаал ба Гэрээ 42:12–13; 84:85

ЭШЛЭЛ

1. *Daughters in My Kingdom: The History and Work of Relief Society* (2011), 3.
2. *Daughters in My Kingdom*, 4.
3. Черил А.Эсплин, “Хүүхдүүдээ ойлгохыг заах нь” *Лиахона*, 2012 оны 5-р сар, 12.
4. Спенсер В.Кимбалл, *Daughters in My Kingdom*, 50.

Итгэл, Гэр бүл,
Халамж



Бидний түүхээс

Эмэгтэйчүүд бид гэр орондоо болон Сүм дээр багш нар байх онцгой чухал үүрэгтэйг манай өнгөрсөн үеийн бошиглогчид бидэнд сануулсаар ирсэн юм. 1979 оны 9-р сард Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл (1895–1985) биднээс “судрын гарамгай мэдлэгтэй эгч” байхыг хүсч, ийнхүү хэлсэн билээ: “[Бид] судрын-гарамгай мэдлэгтэн болсноор бусдыг дорд үзэх биш харин тэднийг өргөх хэрэгтэй! Эцсийн эцэст, заах, хүмүүжүүлэх өдий их ажил хийдэг эмэгтэйчүүд, эхчүүдээс өөр хэнд сайн мэдээний үнэнийг (зөвхөн хэрэгцээ гарсан үед л хүмүүс сайн мэдээнд найдвар тавьж болох юм) ‘эрхэмлэн дээдлэх’ агуу хэрэгцээ байх юм бэ?”⁴

Бид бүгд багш нар бас суралцагчид юм. Бид судруудаас болон манай амьд бошиглогчдын үгсээс зааснаар Христэд ирэхэд нь бусдад тусалж чадна. Бид оновчтой асуултууд асууж, анхааралтай сонссоноор суралцах үйл явцад идэвхтэй үүрэг гүйцэтгэж, бидний хувийн хэрэгцээг шийдвэрлэж чадах хариултуудыг олж чадна.

БИ ЮУ ХИЙЖ ЧАДАХ ВЭ?

1. Би сайн багш болохын тулд хэрхэн бэлтгэх вэ?

2. Би харж ханддаг эгч нартайгаа гэрчлэлээ хуваалцдаг бил үү?

ДӨРӨВДҮГЭЭР САРЫН ЧУУЛГАНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

“Их Эзэн миний бие ярьснаа би ярилаа, . . . харин миний өөрийн дуу хоолой байна уу, эсвэл миний үйлчлэгчдийн дуу хоолой байна уу, энэ нь яг адил” (С ба Г 1:38).

2013 оны 4-р сарын ерөнхий чуулганы талаар эргэн харахдаа та амьд бошиглогч, төлөөлөгчдийн сүүлийн үед заасан зүйлсээс сурч, амьдралдаа хэрэгжүүлэхийн тулд та нар эдгээр хуудсуудыг (мөн дараагийн дугаарууд дахь Чуулганы тэмдэглэлүүдийг) ашиглаж болно.

ЧУУЛГАНЫ ТҮҮХҮҮД



Дуулгавартай байж суралцахуй

Ерөнхийлөгч Томас С.Монсон

Намайг бага байхад гэрийнхэн маань зун болгон, долоон сарын эхнээс есөн сарын эхэн хүртэл Ютагийн Прово Хавцалын Вивиан Парк дахь байшиндаа зусдаг байж билээ.

Бодох санах зүйлгүй, цагийг хамтдаа өнгөрөөдөг байсан сайн найзуудын маань нэгийг Данни Ларсен гэдэг байсан ба тэднийх ч мөн адил Вивиан Паркт байшинтай байсан юм. Өдөр бүр бид хоёр хөвгүүний хувьд диважин болох тэр

газруудаар хэрэн хэсч, гол горхиноос загас барин, чулуу болон элдэв янзын зүйлс цуглуулж, уул хадаар мацан, цаг мөч бүрийг сайхан өнгөрөөдөг байж билээ.

Нэгэн өглөө Данни бид хоёр ярилцан орой түүдэг асааж зуслангийн бүх найзуудаа урихаар шийдлээ. Тэгээд бидэнд хажуухандаа байсан хөндийд хүүхдүүд цуглаж болох газрыг цэвэрлэх шаардлага гарсан юм. Харин тэр талбай дахь 6-р сарын хуурай хатсан өвс л биднийг санасан зүйлээ хийхэд маань саад болж байв. Хангалттай томоохон газрыг цэвэрлэхийн тулд бид өндөр ургасан өвсийг зулгааж эхэллээ. Хамаг чадлаараа угзарч, татаж байсан ч бид хоёр тэр зөрүүд зэрлэг ургамлаас атгын чинээг л

зулгаан авч байсан юм. Энэ чигээрээ үргэлжилбэл тэр талбайг цэвэрлэхэд бүтэн өдөр шаардагдах бөгөөд бид хоёр ядарч мөн цуцаж эхлээд байлаа.

Гэтэл 8 настай миний ухаанд гэнэт нэгэн сайхан санаа орж ирэв. Би Даннид хандан: “Энэ зэрлэг ургамлыг ерөөсөө шатаачихъя. Яг тэр хэсэгхэн дугуй газрын өвсийг л шатаачихъя!” гэж хэллээ. Тэр ч дуртайяа зөвшөөрөхөд би шүдэнз авахаар гэр рүүгээ гүйв.

Наймхан настай балчир бидэнд шүдэнз ашиглахыг зөвшөөрсөн байж гэж бүү бодоцгоогоорой. Данни бид хоёрт том хүнгүйгээр шүдэнз ашиглахыг хатуу хориглосон байсан юм гэдгийг хэлэх хэрэгтэй байх. Галын аюулын талаар Данни бид хоёрт зөндөө анхааруулж байсан. Гэсэн ч шүдэнз хаана байгааг би мэдэж байсан бөгөөд бид тэр талбайг цэвэрлэх шаардлагатай байв. Ямар ч эргэлзээгүйгээр би гэр рүүгээ гүйн ороод хэдэн шүдэнзний модыг хэнд ч харагдалгүйгээр халаасандаа нуун авч гарлаа.

Асуудлаа шийдэх зүйл маань халаасанд буй болохоор би Данни руу эргэн их л баяртай гүйж билээ. Бидний тавьсан гал хэрэгтэй газрыг маань цэвэрлэхийн тулд л илбийн юм шиг өөрөө унтарчих байх гэж бодсоноо би санадаг юм.

Шүдэнзээ чулуунд зурж асаагаад хатсан хуурай өвсөнд аваачиж

тавилаа. Бензин асгачихсан юм шиг тэр дороо л гал дүрэлзэн асав. Зэрлэг ургамал шатаж алга болж байхыг хараад Данни бид хоёр эхэндээ их л баяссан, гэвч тэр гал өөрөө унтрах ямар ч шинжгүй ассаар байлаа. Бид яагаад ч тэр галыг унтрааж чадахгүйгээ мэдээд сандарч эхлэв. Дүрэлзэн шатах гал уулын хормойг даган цаашилж юу юугүй хуш моддыг болон замдаа дайралдсан бүхнийг устгах аюул нүүрлэлээ.

Эцэст нь бид яалт ч үгүй тусламж хүсэхээс өөр аргагүй болсон юм. Тун удалгүй Вивиан Паркт байсан бүх л эрэгтэй, эмэгтэй хүмүүс нийлэн, усанд норгосон шуудайгаар галыг цохиж түймрийг унтраахын тулд нааш цааш гүйлдэж эхлэв. Нилээн хэдэн цагийн дараа сүүлийн ноцож буй цогийг унтраасан юм. Ингэж өндөр настай хуш моднууд



болон түймэрт автах байсан гэр орноо авч үлдсэн билээ.

Тэр өдөр Данни бид хоёр хэцүүхэн боловч чухал хэдэн зүйлийг сурсны нэг нь дуулгавартай байхын ач холбогдол байсан юм.

Бидний бие махбодын аюулгүй байдлыг баталгаажуулж байдаг хууль, дүрэм журмууд байдаг. Үүнтэй адил бидний сүнсэлэг байдлыг хамгаалах заавар болон тушаалуудыг Их Эзэн бэлдэж өгсөн. Эдгээр нь бидэнд энэхүү хувирамтгай, мөнх бус оршихуйд төөрчилгүй Тэнгэрлэг Эцэгтээ эргэн очих боломжийг олгодог юм. ■

“Дуулгавартай байдал адислалуудыг авчирдаг” хэлсэн үгнээс *Лиахона*, 2013 оны 5-р сар, 89–90.

ТУНГААН БОДОХ АСУУЛТУУД:

- Бидэнд яагаад дүрмүүд байдаг вэ?
- Бид Бурханы зарлигуудыг дуулгавартай дагахаар сонгох нь яагаад чухал вэ?
- Есүс Христ ямар байдлаар бидэнд дуулгавартай байдлын үлгэр жишээ болдог вэ?

Бодол санаагаа тэмдэглэлийн дэвтэртээ бичиж, энэ талаар бусадтай ярилц.

Энэ сэдвийн нэмэлт эх сурвалжууд: *Сайн мэдээний зарчмууд* (2009), “Obedience,” 200–206; “Obedience,” in *Gospel Topics on LDS.org*; Д. Тодд Кристоферсон “Гэрээнүүдийн хүч” *Лиахона*, 2009 оны 5-р сар, 19–23.

Гишүүн номлогчдод хандаж хэлсэн бошиглолын үгс

“Та хэнтэй ярих ёстойгоо мэдэхийн тулд залбирвал тэдгээр хүмүүсийн нэрс, нүүр царай санаанд тань орж ирэх болно гэдгийг би амлаж байна. Хэлэх үгс яг хэрэгтэй үедээ өгөгдөх болно. Танд боломжууд нээгдэх болно. Итгэл эргэлзээг ялж, Их Эзэн таныг өөрийн тань үйлдэх гайхамшгуудаар адислах болно.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Нийл Л.Андэрсэн “Энэ бол гайхамшиг,” *Лиахона*, 2013 оны 5-р сар, 79.



ДӨРӨВДҮГЭЭР САРЫН ЕРӨНХИЙ ЧУУЛГАНЫ ҮЕЭРХ НОМЛОГЧДЫН ТАЛААРХ ТОО БАРИМТ

Одоо номлолд үйлчилж байгаа номлогчдын тоо	65,634
Номлолын дуудлагаа хүлээн авсан ч номлогчийг бэлтгэх төвд хараахан очоогүй байгаа залуу эрэгтэйчүүд, залуу эмэгтэйчүүдийн тоо	20,000 гаруй
Бишоп болон гадасны ерөнхийлөгчтэй ярилцлага хийх явцдаа байгаа залуу эрэгтэйчүүд, залуу эмэгтэйчүүдийн тоо	6,000 гаруй
Байгуулагдсан шинэ номлолын тоо	58

Ерөнхийлөгч Томас С.Монсоны “Чуулганд тавтай морилно уу” хэлсэн үгнээс *Лиахона*, 2013 оны 5-р сар, 5.

ИХ ЭЗЭН ДУУДСАН ХҮНЭЭ ТЭНЦЭХЭЭР БОЛГОДОГ

Сүмийн ихэнх гишүүд “дуудлага” буюу үйлчлэх үүрэг хүлээн авах олон боломжтой байх болно. “Бусад хүмүүс бидний авьяас чадвар, нөлөөгөөр адислагдахын тулд Их Эзэн Түүний Сүмд дуудлагатай байхыг бид бүгдээс хүсэн хүлээдэг” гэж Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон (1899–1994) хэлжээ.¹

Өөрсдөө үйлчлэхээр дуудагдсан Сүмийн удирдагчид санал болгосон дуудлагуудыг нь бусад гишүүд хүлээн авч биелүүлэхэд итгэлтэй байдаг. Шинэ дуудлага бүр нь үйлчлэх ба өсөн хөгжих боломж бөгөөд уг дуудлагад даруухнаар залбиралтайгаар хандах ёстой. Сүмд үйлчлэх дуудлагыг санваартны удирдагчид Их Эзэнээс сүнсний удирдамж эрэлхийлсний үндсэн дээр өгдөг. Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх, Ерөнхийлөгч Хенри Б.Айринг,

“Таныг Бурханаас дууддаг. Их Эзэн таныг мэддэг. Өөрийн Сүм дэх албан тушаал бүрт хэнийг дуудахаа Тэрээр мэддэг. Тэрээр таныг сонгосон юм” гэж хэлжээ.²

Бид дуудлагадаа Аврагчийг төлөөлдөг бөгөөд бидний хийдэг ажил хэчнээн өчүүхэн ч байлаа гэсэн мөнхийн үр дагавартай байдаг. Жишээ нь, дуудлагаа эрхэмлэн биелүүлдэг Хүүхдийн Хэсгийн багш хүүхдэд нэгэн цагт номлолд үйлчлэхэд нь сүнслэг нөлөө үзүүлж чадна. Цутлааны байрны хаалган дээр нөхөрсгөөр мэндлэх нь итгэлийнхээ төлөө тэмцэж байгаа гишүүнд сүм дээр санаа сэтгэл сайхан байхад нь тусалж болно.

Их Эзэн бидэнд ялангуяа, ажил үүрэг хэт их байгаа юм шиг санагдсан үед туслах болно. Биднийг Тэнгэрлэг Эцэгт хандан удирдамж

хүсч залбирахад Тэрээр сүнсний нөлөөгөөр дамжуулан биднийг удирдахын хамт үйлчлэлийн төлөө биднийг адислах болно. Их Эзэн Өөрт нь үйлчилдэг хүмүүст тусалж, Өөрийн хүчийг тэдний хүчин чармайлт дээр нэмэх болно (С ба Г 84:88-ыг үзнэ үү). Ерөнхийлөгч Томас С.Монсон, “Бид Их Эзэний зараалд байгаа үед Түүний тусламжийг авах эрхтэй юм. Их Эзэн дуудсан хүнээ дуудлагадаа тэнцэхээр болгодгийг санагтун” гэжээ.³

Бид Их Эзэний үйлчлэлийн үлгэр жишээг дагаж, дуудлага болон Сүмийн ажил үүргээ хичээнгүйлэн биелүүлбэл бидний амьдрал адислагдаж, бид Бурхантай илүү адилхан байх болно (Моронай 7:48; С ба Г 106:3-ыг үзнэ үү). ■

Дэлгэрэнгүй мэдээллийг *Teachings of Presidents of the Church: Lorenzo Snow* (2012), 14-р бүлгээс үзнэ үү.

БҮХИЙ Л ХҮЧИН ЧАРМАЙЛТАА ДАЙЧИЛ

“Их Эзэн чиний хүчийг олон дахин ихэсгэх болно. Чамаас Түүний хүсэх бүх зүйл бол бүхий л хүчин чармайлтаа дайчилж, зүрх сэтгэлээ зориулах явдал юм. Үүнийг зоригтой бөгөөд итгэлийн залбирлаар хийгтүн. Өөрийг тань удирдаж, хамтрагч тань байх Ариун Сүнснийг Эцэг, Түүний Хайрт Хүү хоёр илгээх болно. Таны хүч чармайлтууд үйлчилдэг хүмүүсийн тань амьдралыг адислах болно.”

Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх Ерөнхийлөгч Хенри Б.Айринг, “Дуудлагаа өндөрт өргөгтүн,” *Лиахона*, 2002 оны 11-р сар, 76.


ЭШЛЭЛ

1. Эзра Тафт Бенсон, Диетер Ф.Угдорф, “Зогсож байгаа газраасаа өргө,” *Лиахона*, 2008 оны 11-р сар, 54.
2. Хенри Б.Айринг, “Дуудлагаа өндөрт өргөгтүн,” *Лиахона*, 2002 оны 11-р сар, 76.
3. Томас С.Монсон, “Duty Calls,” *Лиахона*, 1996 оны 7-р сар, 42.

Бид ажил үүрэгтээ суралцаж, асуултууддаа хариу авахын тулд гарын авлагууд, Сүмийн удирдагчдын зөвлөгөө болон бусад эх сурвалжуудыг үзэж болно.

Бид Их Эзэний ажлыг хийхэд тусалж байгаа үедээ, Түүний тусламжийн төлөө залбирч мөн хүлээн авч чадна (С ба Г 84:88-ыг үзнэ үү).

Бид дуудлагыг өөрсдөө хүсч авдаггүй бас санваарын зохих эрх мэдлээр дамжин ирж байгаа дуудлагаас татгалзах ёсгүй. (Моисе 6:31–32-ыг үзнэ үү).



Дуудлагаа биелүүлэх нь бидний амьдралд олон адислал болон баяр баясгаланг авчирдаг (Матай 25:23-ыг үзнэ үү).

Бүх дуудлага адилхан чухал юм. Сүмд хүүхэд асрах удирдагчид Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчидтэй адилхан хэрэгтэй байдаг (1 Коринт 12:14–18-ыг үзнэ үү). Бидний хэрхэн үйлчилж байгаа нь хаана үйлчилж байгаагаас маань илүү чухал юм.

АСУУЛТУУДАД ХАРИУЛАХ НЬ

Танай Сүм яагаад цалингүй шашны ажилтантай байдаг вэ?

Их Эзэн эхлэлээс Өөрийн шавь нарыг амьдралын янз бүрийн түвшний эгэл жирийн хүмүүсийн дундаас дуудсаар ирсэн юм. Тэд Их Эзэнийг болон бусдыг хайрлах хайраар үйлчилдэг байлаа. Жишээ нь, Мормоны Номонд бошиглогч Алма санваартны удирдагчдыг сонгож, “өөрсдийн гараар хөдөлмөрлөж, . . . өөрсдийгөө тэжээх ёстой хэмээн тэдэнд зарлиг болгосон байдаг. . . .

“Мөн санваартнууд өөрсдийгөө тэтгэхийн тулд хүмүүс дээр түшиглэх биш; харин хөдөлмөрийнхөө хариуд Бурханы ач ивээлийг авах байсан,” (Мозая 18:24, 26; мөн 2 Нифай 26:29–31; Итгэлийн Тунхаг 1:5-ыг үзнэ үү).

Үүнтэй адил өнөө үед үйлчлэх дуудлага нь бусдад туслах, авьяас чадвар ба сүнсний бэлгүүдээ хөгжүүлэх мөн хуваалцах боломжийг бидэнд олгодог билээ. Бид үйлчлэлийнхээ хариуд Их Эзэний адислалуудаар элбэг дэлбэгээр адислагдаж байна.

ТЕЛЕВИЗ БА СҮНСЛЭГ БАЙДАЛ

Кейси Кронин

Миний нөхөр таг дүлий ч гэсэн сайн мэдээнд үнэнч сэтгэлээр ханддаг хүн. Гэвч долоо хоног тутам болдог Сүмийн цуглаануудыг ойлгох гэж олон жил зүдэрсэн нь санваартнуудын бусад хурал цуглаан болон телевизийн шууд нэвтрүүлгүүдийг үзэхэд түүнийг дургүй болгосон юм. Манай тойргийн гишүүд түүнд нөхөрсгөөр хандаж, урам хайрладаг байсан ч, цуглаануудад оролцоход нь түүнд хэрэгтэй арга техникийн тусалцааг ойлгодоггүй байсан нь нөхрийг минь ганцаардаж, сэтгэл санаагаар уруу байхад хүргэсэн юм.

Бид тэр тойрогт ирээд удаагүй байсан бөгөөд энэ үед ерөнхий чуулган болж байв. Нөхөр маань телевизийн шууд нэвтрүүлэг үзэхэд ямар асуудалтай тулгарах бол хэмээн бодон, санваартны ерөнхий хуралд их л идэвхтэй бэлтгэж байлаа. Түүнийг хүрч ирэхэд проекцийн том аппаратыг хэрхэн ажиллуулахыг хэн ч мэдэхгүй байсан учир нэг телевизор оруулж ирэн буланд байрлуулсан байлаа. Гэтэл нэг яльгүй асуудал гарав. Телевизорыг цахилгаанд холбох залгуур утсыг өмнө нь санамсаргүйгээр проекцийн аппаратыг ажиллуулахад ашиглаж харин телевизорт ашигладаггүй байсан ажээ. Нөхөр маань цахилгаан хэрэгслүүдийг ажиллуулах талаар туршлагатай байсан учраас номын сан руу очиж, проекцийн аппаратын залгуурыг хайжээ. Нэлээд хэдэн хайрцаг, шүүгээнд хайсны эцэст проекцийн аппаратын залгуурыг олж.

Нэвтрүүлэг эхлэх цаг бараг болоод байхад телевизор, проекцийн аппаратын аль нь ч залгуургүй, тохируулга хийгдээгүй байгаад бүгд сэтгэл түгшингүй байлаа. Нөхрийн маань олж ирсэн залгуур дугуйтай тэргэнцэр дээрх телевизорт хүрэхээргүй богинохон байсан учир телевизорыг намхан ширээн дээр шилжүүлэн тавилаа. Тэр дугуйтай тэргэнцрийг цуглааны танхимаас гаргаж ойролцоох өрөө рүү аваачаад, эргэж ирэн телевизорыг хайрцагнаас нь задалж өргөн ширээн дээр тавихад хэн ч туслахаар ирсэнгүйд гайхжээ. Тэр үед өрөөнд нэг хүн орж ирэхийг тэр мэдэрсэн аж. Энэ бол бишоп байлаа. Нөхөр маань маш их баярлан, бишоптой хамт телевизорыг ширээн дээр тавьжээ. Манай нөхөр телевизорыг ажиллахад бэлэн болгох зуур бишоп сандал авчран дэлгэц рүү харуулан тавилаа.

Нөхөр маань тусалсанд нь бишопт талархал илэрхийлээд, гарыг нь барихад бишоп эргэж, хаалга руу явлаа. Бишоп хаалгаар гарч, хананд тулган тавьсан сандлууд руу яваад өгөхөд

манай нөхөр их гайхсан аж. Тэр нэг сандал аваад нөхрийн минь дэргэд суулаа. Тэр хоёр нэвтрүүлэг дуустал зэрэгцэн суусан.

Одоо миний нөхөр цуглаануудад идэвхтэй оролцдог болсон. Бишопын нинжин сэтгэлийн энгийн үйлдэл нөхрийн минь санаа сэтгэлийг өргөж, илэрхийлсэн талархал нь түүний зүрх сэтгэлд шингэсэн юм. Зарим асуудал гарч ирдэг хэвээр байгаа ч, нөхөр минь ганцаардаж, сэтгэл санаа нь тавгүй байхаа больсон. Христийн хоньчдын нэгнийх нь сүнслэг нөлөө тийнхүү нөхрийн минь байдлыг өөрчилсөн юм. ■

Энэхүү өгүүллийн зохиогч АНУ-ын Миссиссипид амьдардаг.

Хөгжлийн янз бүрийн бэрхшээлийн тухай нэмэлт мэдээллийг disabilities.lds.org-аас үзнэ үү.





ҮНЭНЧ ШУДАРГА БАЙДАЛ

Үнэнч шударга байдал нь “ямар ч нөхцөлд эсвээс бусад хүмүүс юу гэж бодох бол гэдгийг үл харгалзан үргэлж зөв зүйл хийх буюу хэлэхийг хүнээс шаарддаг” хэмээн энэ сарын дугаарын хуудас 48-49 дээрх өгүүлэлдээ Далын Ахлагч Бага Кристоффел Годден өгүүлжээ.

Энэхүү өгүүлэл Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Жозеф Б.Вертлинний (1917–2008) амьдралд тохиолдсон нэг үйл явдлын тухай юм. Ахлагч Вертлин оюутан байхдаа Америк хөл бөмбөгийн аварга шалгаруулах нэг тэмцээнд оролцжээ. Бөмбөг түүн рүү ирэхэд тэр урагш ухасхийсэн ч гоолын шугамаас 5 см зайд зогсчээ. Тэр бөмбөгийг урагш нь шидэхийн оронд үргэлж зөвийг хийж байх ёстой гэсэн ээжийнхээ үгийг санан бөмбөгийг тэнд нь орхисон ажээ.

Дараах зөвлөмжүүд нь таны өөрийн үлгэр жишээний хамт сайн мэдээний эдгээр зарчмуудын тухай хүүхдүүдэд заахад тань танд тусалж болно.

Өсвөр үеийнхэнд заах зөвлөмжүүд

- *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимол дахь үнэнч шударга байдлын тухай хэсгийг хүүхэдтэйгээ хамт унш. Үнэнч шударга байдлаас ирдэг адислалуудын тухай ярилц.
- Гэр бүлийн үдэштээ зориулан “Чи яах ёстой вэ?” гэсэн үйл ажиллагааг бэлтгэхэд туслахыг өсвөр насны хүүхдээсээ хүс. Үнэнч шударга байдлыг

харуулах боломжийг хүнд олгох нөхцөл байдлуудыг жагсаахад *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимлыг удирдамж болгон ашигла.

- Ерөнхийлөгч Томас С.Монсон шударга зан чанарын тухай олон удаа ярьсан билээ. Түүний захиасуудаас нэгийг олж, гэр бүлтэйгээ хуваалц. Зарим эх сурвалжийг дор дурдав:

“Бошиглогч Иосеф Смит: Үлгэр жишээгээр заадаг багш,” *Лиакхона*, 2005 оны 11-р сар, 67.

“Happiness—the Universal Quest,” *Лиакхона*, 1996 оны 3-р сар, 2.

“In Search of an Abundant Life,” *Tambuli*, 1988 оны 8-р сар, 2.

Хүүхдүүдэд заах зөвлөмж

- Зарчимч байдалд өөртөө шударгаар хандах нь ордог. Үүнийг харуулахын тулд гэр бүлийн үдшийн үеэр хүүхдүүдийнхээ өмнө амттан тавь. Амтаныг идэж болно гэж таныг хэлэхээс өмнө идэж болохгүйг тэдэнд хэл. Тэгээд та нүдээ аних эсвэл нүдээ боогоод, “Би харж чадахгүй байгаа учраас одоо амттаныг идэх нь зөв үү?” гэж асуу. Бусдыг хараагүй байхад тэдний хийж болох зөв зүйлсийн тухай, жишээ нь хувийн залбирлын тухай ярилц. Тэнгэрлэг Эцэг тэднийг үргэлж харж байдгийг тэдэнд сануул.
- Хүүхдүүдтэй хамт бэлтгэсэн “Чи яах ёстой вэ?” үйл

ҮНЭНЧ ШУДАРГА БАЙДЛЫН ТАЛААРХ СУДРУУД

Иов 27:4–5

Сургаалт Үгс 20:7

1 Петр 2:12

Алма 53:20

Сургаал ба Гэрээ 124:15

Итгэлийн Тунхаг 1:13

ажиллагааг ашиглах эсвэл шударга байх, шударга бус байх гэж юу болохыг ойлгоход нь тэдэнд туслах, бага насны хүүхдүүдэд тохирсон үйл ажиллагааг зохиож ашиглахыг бод. Хариултыг нь тэднээр ярилцуул. Хэрэв танайд өсвөр болон бага насны хүүхэд аль аль нь байдаг бол өсвөр насны хүүхдүүдээр бага насны хүүхдүүдэд туслуул. ■



БУРХАНД БОЛОМЖГҮЙ ЮМ ГЭЖ НЭГ Ч БАЙХГҮЙ

Санг-Ик Хан

Би 12 жил орчмын өмнө эхнэр, дөрвөн хөвгүүнийхээ хамт Бүгд Найрамдах Солонгос Улсаас Шинэ Зеландад цагаачилж ирсэн юм. Шинэ Зеланд дахь Солонгос сургуулийн орлогч захирлаар ажиллаж байхдаа шинэ соёл, ёс заншил, шинэ улс төр, шинэ дэг журамд дасан зохицох гэж зүдэрч байгаа олон солонгосчуудтай танилцлаа. Би тэдэнд туслахын сацуу Шинэ Зеландын хөгжилд хувь нэмрээ оруулахыг хүсч байлаа. Иймээс хуульч болох нь хоёр ард түмэн, хоёр орныг хооронд нь холбох гүүр болох нэг арга зам гэж үзээд энэхүү шийдвэрээ батлахын тулд залбирсны дараа 53 настайдаа хуулийн сургуульд орохоор шийдсэн.

Энэ нь амаргүй байх болно гэдгийг би мэдэж байлаа. Гэтэл би цуврал гарын авлагууд хүлээж аваад хуулийн мэргэжлээр суралцах нь миний бодож байснаас хавьгүй хэцүү болохыг мэдсэн. Хичээлийн гарын авлага бүр нь их зузаанаас гадна агуулгыг ойлгох нь миний хувьд ахадсан юм шиг санагдлаа. Би ерөнхий чуулган дээр хэлсэн үгсийг англиас солонгос хэлэнд хөрвүүлэх ажилд бараг 10 жил тусалснаас гадна Шинэ Зеландад хэл шинжлэлээр магистрын зэрэг хамгаалсан ч англи



Их Эзэн Санг-Ик Хан ахыг адисалж, 55 настайдаа хуулийн сургуулийг төгсөхөд нь олон талаар түүнд тусалжээ.

хэлний хууль зүйн нэр томъёонууд нь огт өөр юм шиг санагдаж билээ.

Би эхний өдөр сургуулиасаа гэртээ ирээд суралцахдаа цаашид үргэлжлүүлэх үү эсвэл хичээл эхлэхээс өмнө болих уу гэдгийг нухацтай авч үзэх шаардлагатай болов. Тийнхүү яахаа тодорхой мэдэхгүй байсан үед хэрэв би Их Эзэнд бүрэн найдах юм бол амжилттай суралцаж чадна гэсэн бодол толгойд орж ирлээ.

Бурхан амьд бөгөөд бидний залбиралд хариулдгийг би мэдэх учраас Түүнээс тусламж гуйлаа. “Учир нь Бурханд боломжгүй юм гэж нэг ч байхгүй” (Лук 1:37) гэсэн Библи дэх нэг судрыг саналаа. Энэ судар надад маш их тусалсан бөгөөд урагш тэмүүлэх хүчийг надад өгсөн юм.

Суралцах явцад надад хүндрэл тохиолдсон үед Бурхан үргэлж замыг бэлтгэх буюу газар дээрх тэнгэр элчүүд болсон хүмүүсийг илгээж, бэрхшээл дундуур намайг удирддаг байлаа.

Нэг өдөр би даалгавраа хийх гэж зүдэрч байлаа. Чадах бүхнээ хийсэн ч лекц уншигч биднээр чухам юу хийлгэхийг хүссэнийг би ойлгосонгүй. Ням гараг болоход хичээлээ хойш тавьж бүх анхаарлаа Сүмийн ажил үүрэг дээрээ төвлөрүүлээ. Би гадасны дээд зөвлөхийн

хуваарийн дагуу хариуцсан тойрогтоо ариун ёслолын цуглаан дээр үт хэлэхээр очлоо. Цуглааны дараа нэг ах над руу хүрч ирэн, намайг сургууль дээр хичээлийн танхимд харснаа хэллээ. Тэр бас хуулийн ангийн оюутан байсныг би мэдээгүй байжээ. Тэр надаас хичээлийн даалгавар ямар байна даа гэж асуухад би үнэхээр хүнд байна гэж үнэнээ хэллээ. Тэгэхэд тэр танайд очиж танд тусалж болох уу гэж асуув. Хэрэв би тэр тойрогт очоогүй бол түүнтэй уулзахгүй, бас даалгавраа хугацаанд нь өгч чадахгүй байх байсан. Тэр оюутан бол миний залбиралд хариулахаар Бурханы илгээсэн тэнгэр элч байлаа.

Миний хувьд хамгийн хүнд нэг хичээлээр лекц уншигч хоёр удаа бүтэн хоёр цагаар заасан. Надад зөвхөн хичээлийн агуулгыг ойлгох нь хэцүү байсан төдийгүй бас лекц уншигчийн аялгыг ойлгох нь бүр хэцүү байсан учраас би зөвшөөрөл авч түүний лекцүүдийг дараа нь анхааралтай судлахын тулд бичлэг хийж авсан юм. Нэг өдөр би танихгүй нэг эмэгтэйдээс э-мэйл хүлээж авлаа. Тэр өөрийгөө нэг ангийн оюутан гэдгээ танилцуулаад бичлэгээ хувиж хуваалцаж болох уу гэж хүссэн байлаа. Учир нь тэр ажлынхаа хуваарийн улмаас зарим үед хичээлд сууж чаддаггүй байжээ.

Мэдээж хэрэг, би түүнд бичлэгийнхээ нэг хувийг өгөхдөө баяртай байлаа. Би түүнд тусаллаа гэж бодсон чинь, харин тэр эмэгтэй бол надад туслах ажлыг зохион байгуулахаар Бурханы илгээсэн

өөр нэг тэнгэр элч болохыг би ойлгосон юм. Тэр хичээлийг амжилттай хийхийн тулд бид хоёр даалгавруудаа хийж, гурван цагийн шалгалт өгөх хэрэгтэй байв. Тэр эмэгтэй надад даалгавруудыг хийж, шалгалтанд бэлтгэхэд тусалсан. Тэр надад туслаагүй байсан бол би шалгалтаа амжилттай өгч чадахгүй байх байсан.

Миний хувьд англи хэл төрөлх хэл биш бөгөөд миний нас ахимаг байсантай холбоотой бэрхшээлээс гадна өөр үүрэгт ажилтай байсан болохоор энэ бүхэн хичээл сурлагад маань хүндрэл учруулдаг байлаа. Миний ажил, нийгэмд хүлээх үүргүүд, Сүмийн дуудлагууд ихэнх цагийг маань авдаг байсан бөгөөд би бас нөхөр, эцэг, өвөг эцгийн маш чухал үүрэг хариуцлагадаа анхаарал тавихыг хичээдэг байлаа. Надтай хамт ажиллагсдын нэг нь намайг энэ бүх ажлаасаа гадна хуулийн сургуульд сурдгийг дуулаад ёстой галзуурмаар юм байна даа гэж билээ. Гэвч би, “хүмүүст боломжгүй зүйлс Бурханд боломжтой” (Лук 18:27) гэдэгт итгэдэг байлаа.

Би 55 настайдаа хуульч болж, Шинэ Зеландын Дээд Шүүхэд өмгөөлөгчөөр ажиллах болов. Надад хэлний саад бэрхшээл байсан ч, зөвхөн хуульч болсныхоо төлөө төдийгүй бас Бурхан амьд бөгөөд бидний зөв залбирлуудад хариулдаг тухай бат бөх гэрчлэлтэй болсондоо би талархалтай байдаг билээ. Түүний тусламжтай бол боломжгүй юм гэж нэг ч байхгүйг би мэднэ. ■

Энэ өгүүллийн зохиогч Шинэ Зеландад амьдардаг.



ТЭМЦЛИЙН ҮР ДҮНД ӨСӨЛТ БИЙ БОЛНО

Бид зорилгодоо хүрэхийн төлөө тэмцэх ёстой. Тэмцэл гэдэг нь сурч мэдэх үйл хэрэг бөгөөд үүний ачаар бид өсч хөгжинө. Сорилтуудыг даван туулахын тулд бидний хөгжүүлдэг хүч чадал үүрд мөнхөд бидэнтэй хамт байх болно.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Даллин Х. Өүкс, Кристен М.Өүкс нар, “Learning and Latter-day Saints,” *Лиакхона*, 2009 оны 4-р сар, 31.



Арванхоёр
Төлөөлөгчийн Чуулгын
Ахлагч М. Рассел Баллард

Анхдагчдын итгэл ба тэсвэр хатуужил тэр үед болон өнөөдөр

Нийгэм, гэр бүлүүд болон гэр оронд сайн зорилгуудыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн Христийнхтэй адил амьдралаар амьдарч буй өнөө үеийн анхдагчидтай хамт бид алхах хэрэгтэй.

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн түүхийн эхний жилүүд нь агуу сорилтын жилүүд байлаа. Бригам Янг, Хебер К.Кимбалл, Жон Тейлор, Вилфорд Вудрафф, Лорензо Снөү, Иосеф Ф.Смит зэрэг удирдагчид эдгээр жилүүдэд уудам хээр талыг гатлан, Хадат Уулсад Сүмийг үндэслэн байгуулахын төлөө төсөөлөхийн аргагүй хүнд сорилт, гай зовлонг даван туулсан учраас шалгаран тодорсон юм.

Өмнөх үеүдийн анхдагчид эдүгээ Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн хэрэгжүүлж буй ажлыг хараад баяртай байх байсан. Бид анхдагчдад асар их өртэй бөгөөд өнөөгийн бидний амжилт өнгөрсөн үеийн тэрхүү даруухан, агуу хүмүүсийн



“Бид анхдагчдад асар их өртэй бөгөөд өнөөгийн бидний амжилт өнгөрсөн үеийн тэрхүү даруухан, агуу хүмүүсийн бий болгосон суурин дээр, тэдний эрэлхэг зоригийн ачаар бий болсныг бид хэзээ ч мартаж өсгүй” хэмээн Ахлагч Баллард энэхүү үйл явдлын мөрөөр замнагч залуу анхдагчдад хандан хэлжээ.

бий болгосон суурин дээр, тэдний эрэлхэг зоригийн ачаар бий болсныг бид хэзээ ч мартаж өсгүй.

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли (1910–2008) манай итгэлтэй анхдагчдын тухай: “Өнөө үе болон ирээдүйн төлвийн төлөө тархалтай байхын тулд өнгөрсөн үеийг эргэн харах нь ашиг тустай юм. Ирээдүйд тулгарах зүйлсэд хүч чадлыг олохын тулд өнгөрсөн үед амьдарч байсан хүмүүсийн хүч чадлыг эргэж харах нь ашиг тустай юм. Энэ дэлхийд

шаргуу хөдөлмөрлөөд өчүүхнийг олж авсан ч, агуу зүйлсийг мөрөөдөж, төлөвлөн хэрэгжүүлэхэд агуу үр дүнд хүрсэн эдгээр хүмүүсийн ажил үйлсийг эргэцүүлэн бодох нь ашиг тустай билээ. Тэдний ажлын үр шимийг хүртэгчид нь бид юм.



Stagecoach and covered wagon in a desert landscape.

Тэдний агуу үлгэр жишээ нь бидний хүн нэг бүхэнд урам зориг болж чадна, бид бүгдээрээ өөр өөрсдийн амьдралдаа анхдагчид нь юм”¹ хэмээн хэлжээ.

Дагах ёстой итгэл

Бригам Янгийг үржил шимгүй цөл рүү дагах итгэлтэй байсан хүмүүс нь зөвхөн удирдагчид байгаагүй юм. Сүмийн эгэл жирийн олон гишүүд бас тэднийг дагахаар ирсэн билээ. 1836 онд Нью-Йоркийн Уотертаун дахь чинээлэг амьдралаа, түүний дотор 93 га эдлэн газар, чанар сайтай чулуун байшин, зузаан банзаар барьсан хоёр саравчаа орхин, гэр бүлээрээ Огайогийн Көртландад Гэгээнтнүүдтэй нэгдэхээр аянд гарсан Оливер Хантингтоны эцэг эхийн тухай бид Сүмийн түүхээс мэддэг билээ.

Оливер бүх зүйлээ орхисны дараа, “Бусад хүмүүс юм юмаар гачигдаж, хүүхдүүд нь идэх юм нэхэж уйлахад тэдэнд өгөх юм хэнд ч байсангүй нь бас тэдэнд дараагийн хоолонд юу өгөхийг хэн ч мэдэхгүй байсан нь аав, ээж хоёрын минь сэтгэлийг бүр ч их шаналгадаг байлаа” хэмээн бичжээ. Тэд ямар ч нөхцөлд Сүмийн удирдагчдад дургүйцэн үглэх буюу тэдний талаар гомдоллохыг эсвээс Их Эзний ажил үнэн болох талаар эргэлзэхийг хэзээ ч сонсож байгаагүй гэж хэлснээрээ Оливер энэ гэр бүлийн итгэлийг гэрчилжээ.²

Энэ эрин үе дэх Сүмийн анхны бишопын охин Эмили Партриж, дөнгөж долоон настай байхдаа 1831 онд Миссурийн Жаксон дүүрэг рүү нүүхийн тулд Огайогийн Пейнсвилл дэх тохилог гэр орноо орхисон тухай санажээ.³ Түүнээс хойш удалгүй түүний гэр бүлийг танхайрагчид гэр орноос нь албадан хөөж, тэд Клей дүүрэг рүү нүүхээс аргагүйд хүрчээ. Тэд эцэстээ малын саравч байсан нэг хуучин, жижигхэн дүнзэн байшин олж суусан тухай өгүүлсэн байдаг. . . . Тэр байшин нэг том өрөөтэй, хажуу талд нь залган барьсан болхидуухан нэг жижиг саравч байлаа. Энэ жижиг саравчийг төдийлөн ашигладаггүй учраас шал нь бараг нэлдээ ховхорч хөндийрсөн, харх, хоржигнуурт могой үүрээ засан тухалсан байлаа. Хүн сууж болмоор нэг өрөө нь том пийшинтэй, пийшингээс хэдэн алхмын зайд хэдэн хөнжил өлгөөтэй байсан бөгөөд хоёр айлын бүгд арван тав, зургаан хүн хавирга нэвтлэм хүйтэн жавраас хамгаалхын тулд шахцалдан хэвтэж, хөнжлөөрөө хучдаг байлаа. Аав пийшинд ойрхон суугаад юм бичихэд үзэгнийх нь бэх хөлдчихдөг тийм их хүйтэн байж билээ.”⁴



Фоеб Картер өөрийнх нь итгэлийн алхаа Мейний Скарборо дахь гэрээс нь Огайогийн Көртланд хүртэл 1,200 км-ээс бүр цааш илүү хол аялахад хүргэх юм гэж санасангүй.

Энэ гэр бүл хожим нь Иллиной руу шилжсэн. Эмили тэр үеийн байдлыг: “Хүнд бэрх үе байлаа, бид өмч хөрөнгөө олон удаа дээрэмдүүлж, орон гэрээсээ олон удаа хөөгдөж, өвчин эмгэгт нэрвэгдэн, туйлын ядуу зүдүү амьдарч байлаа” хэмээн дүгнэж бичжээ.⁵

Фоеб Картер мөн л ийм байдлаар 1835 онд Мейний Скарборогоос Огайогийн Көртланд руу 1200 км замыг туулахаар хөтлөгджээ. Фоеб Сүмийн гишүүдтэй нэгдэхээр, тэр ч байтугай хэцүү аяныг ганцаараа туулахаар шийдсэн үедээ 28-тай байжээ. Тэр эмэгтэй хожим нь:

“Найз нар маань миний гаргасан шийдвэрт гайхаж байлаа, гэвч миний дотор сэтгэлд нэг зүйл намайг албадан шахаж байлаа. Намайг гэр орноо орхин

явахаар болсонд ээж минь уй гашуу болон санаагаар унасныг хүлцэн тэвчихэд надад

үнэхээр хэцүү байлаа. Гэвч энэ нь миний дотор сүнсэнд биш байсан бол эцэст нь би шантрах байсан. Ээж минь намайг

өршөөлгүй хахир хатуу ертөнц рүү ганцаараа явахын оронд оршуулагдахыг нь харсан бол дээр байхсан хэмээн надад

хэллээ. . . . ‘Фоеб, чи Мормоны шашин худал гэдгийг мэдвэл над руу эргэж ирэх үү?’ гэж ээжийг асуухад би, ‘Тийм ээ, ээж ээ, тэгэлгүй яахав’ хэмээн гурвантаа хариулж билээ.

. . . Явах цаг болоход би гэрийнхэнтэйгээ салах ёс гүйцэтгэн баяртай гэж хэлж зүрхэлсэнгүй, хүн бүрт баяртай хэмээн зурвас бичиж ширээн дээрээ үлдээгээд шатаар уруудан гүйж, сүйх тэргэнд харайн орж билээ. Ийнхүү би хүүхэд ахуй үеэсээ хайртай байсан гэр орноо орхиж, амьдралаа Бурханы Гэгээнтнүүдтэй холбосон юм”⁶ хэмээн дурсан ярьжээ.

Тэр мөчид түүний итгэлийн алхаа түүнийг Көртланд хүрэх Фоеб 1,200 километрээс бүр илүү хол аянд удирдан хөтлөх юм гэж санасангүй. Тэр Миссурийг дамжин Наувуд хүрч тэндээсээ 2,170 км замыг зэлүүд нутгуудаар туулан, Их Солт Лейкийн Хөндий хүрэх аяныхаа замд Вилфорд Вудраффтэй нэгдэж, түүнтэй гэрлэжээ.

Миний элэнц өвөг эцэг Хенри Баллард Английн Тачамд 17 настайдаа 1849 оны хоёрдугаар сард Сүмд нэгджээ. Хенри Америк руу далайгаар хөвөх аяныхаа зардлыг төлөхийн тулд Лорензо Снөү, Эрастус Снөү нар нэг хэсгийг нь өмчилдөг байсан компанид хоёр ажил хийж ажиллахаар гэрээ байгуулсан ажээ. Түүнийг Солт Лейкийн Хөндийн баруунтаа хонь хариулах ажилд хөлсөлсөн гэнэ. Хенри энэ хөндийд хэрхэн орж ирснээ дараах үгсээр дүрсэлжээ:

Тэр мөчид түүний итгэлийн алхаа түүнийг Көртланд хүрэх Фоеб 1,200 километрээс

бүр илүү хол аянд удирдан хөтлөх юм гэж санасангүй. Тэр Миссурийг дамжин Наувуд хүрч тэндээсээ 2,170 км замыг зэлүүд нутгуудаар туулан, Их Солт Лейкийн Хөндий хүрэх аяныхаа замд Вилфорд Вудраффтэй нэгдэж, түүнтэй гэрлэжээ.

Миний элэнц өвөг эцэг Хенри Баллард Английн Тачамд 17 настайдаа 1849 оны хоёрдугаар сард Сүмд нэгджээ. Хенри Америк руу далайгаар хөвөх аяныхаа зардлыг төлөхийн тулд Лорензо Снөү, Эрастус Снөү нар нэг хэсгийг нь өмчилдөг байсан компанид хоёр ажил хийж ажиллахаар гэрээ байгуулсан ажээ. Түүнийг Солт Лейкийн Хөндийн баруунтаа хонь хариулах ажилд хөлсөлсөн гэнэ. Хенри энэ хөндийд хэрхэн орж ирснээ дараах үгсээр дүрсэлжээ:



“Би 10-р сард намхан уулсыг уруудан Эмигрейшен Хавцлын амаар хонио тууж өнгөрөх үед Их Солт Лейкийн Хөндийг анх удаа харж билээ. ‘Амлагдсан нутаг руу’ хараа бэлчээн баясахын хамт хүн намайг харчихвий дээ хэмээн айна. Би ноорхой хувцастай болохоор харанхуй болж, уранхай хувцасны цаадах нүцгэн биеэсээ ичих шаардлагагүй болтол өдөржингөө бутны ард нуугдлаа. Харанхуй болсны дараа талбайг гаталж, гэрэл гялалзах нэг байшин руу очиж . . . хаалгыг нь зүрхшээсээр тогшив. Аз болоход хаалга онгойлгож өгсөн хүн болон лааны гэрэл намайг тэдний гэр бүлийн бусад гишүүдэд харагдуулсангүй. Би аянаа цааш үргэлжлүүлж, эцэг эхээ олж очихын тулд тэр хүнээс нүцгэн биеэ халхлах хувцас гуйлаа. Надад хэдэн хувцас өгсөн болохоор маргааш нь би аянаа үргэлжлүүлж, ирээдүйн гэр орон минь болох Солт Лейк хотод 1852 оны аравдугаар сарын 16-нд эсэн мэнд хүрч ирсэндээ Бурханд талархал өргөж билээ.”⁷

Элбэг дэлбэгээр адислагдсан өнөө үед зүрх сэтгэл минь сайхь уужуу сэтгэлт,

эрэлхэг зоригт өвөг эцгээ хайрлах хайр, хүндэтгэл бишрэлээр дүүрэн байна.

Миний элэнц эмэг эх бол 13 настайдаа эцэг эхтэйгээ хамт Ютад ирсэн, Маргарет МкНейл гэгч шотланд бүсгүй байжээ. Тэргэнц үнээгээ тууж, эрэгтэй дүү Жеймсийгээ аян замын ихэнхэд үүрэн, хээр талыг явган туулсан ажээ. Эмээ минь гэр бүлийнхээ хамт Огдены захад буусан. Тэр энэ тухайгаа хожим нь намтартаа ийн тэмдэглэжээ:

“Бидний буудалласан талбайн нөгөө талд, гаднах хашаандаа баахан хурган гуа овоолсон, нэг жижигхэн байшин байлаа. Бид бүгдээрээ үхтэлээ өлссөн байлаа. Ээж намайг тэр айлаас ганц хурган гуа гуйгаад ирээч гэж явуулав. Учир нь бидэнд ганц цент ч байсангүй, хоолгүйгээс болж хүүхдүүд сульдэн тамирдсан байв. Намайг хаалга тогшиход настай эмэгтэй хүрч ирэн, ‘Ор, ор, би та нарыг энд дөнгөж ирээд байгааг мэднэ. Та нарт идэх юм өгөөрэй гэж надад хэлсэн’ гэв. Тэгээд тэр надад шинэхэн том талх өгөөд ээжийгээ даруйхан хүрээд ирэхгүй юү гэж хэлээрэй гэв. Удалгүй тэр бидэнд сайхан

Хенри Баллард Солт Лейкийн Хөндийд ноорхой хувцастай хүрч очжээ. Харанхуй болоход, “би аянаа цааш үргэлжлүүлж, эцэг эхээ олж очихын тулд тэр хүнээс нүцгэн биеэ халхлах хувцас гуйлаа.”

амттай хоол хийж авчирч өглөө. Бид ийм хоол идээгүй их уджээ.”⁸

Биеийн ба сүнсний аврал

165 жилийн тэртээ хээр талыг туулахад ямар агуу итгэл, ямар агуу зориг шаардагдсаныг бид анхдагчдын туршлагаас мэднэ. Гар тэрэгтэй анхдагчид 1847-гоос 1868 оныг хүртэл Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн ердөө 10 хүрэхгүй хувийг эзэлж байсан ч тэд ХҮГ-ийн соёлд чухал бэлгэдэл болж, анхдагчдын нэгэн бүхэл үеийнхний итгэл бишрэл, золиослолыг төлөөлөн харуулдаг билээ.

Вилли, Мартин нарын бүлгүүд Вайомингэд өвлийн эхний хунгар цасанд боогдож, Гэгээнтнүүдээс олон нь хөлдөж үхсэнийг та нар санаж байгаа. Миний бие гэр бүлтэйгээ хамт хэдэн жилийн өмнө тэдний замаар хийсэн аяллын үеэр Виллийн бүлэг цасанд боогдон, хүйтэн жаварт хайруулж, өлсөж, үхэж үрэгдэж байсан Свитуотерын бүс нутгийн дээрээс харан, зогсож билээ. Тэдэнд тохиолдсон өгүүлшгүй хүнд сорилт бэрхшээлийн тухай бас тэд хэрхэн аврагдсан тухай бид тэдний тэмдэглэлээс уншъя. Жон Числетт ийн бичжээ:

“Алс тэртээх толгодын цаагуур нар улаан туяа цацруулан жаргах үеэр, . . . хэдэн морин тэрэг . . . биднийг чиглэн гарч ирэв. Энэ мэдээ тэр дороо буудал даяар түймрийн гал лугаа адил түргэн тархлаа. . . . Баярлан уухайлах дуун агаарт хадаж, хүчирхэг ханхар эрчүүдийн наранд борлож, гүн үрчлээ суусан хацрыг даган нүлимс аяндаа урсаж гарлаа. . . .

“ . . . Тэр үдэш буудалд анх удаа нэлээд удаан хутацаанд Сионы дуун сонсогдож билээ. . . . Бидний өлссөн гэдэс цадаж, зүрх сэтгэл Бурханд болон ачлаал ах нартаа талархах талархлаар бялхан, бид бүгд залбиралд нэгдэж, дараа нь амрахаар унтав.”⁹

Биднийг “Эминенс (Алдар суугийн өндөрлөг)” хэмээн эдүгээ нэрлэгддэг толгод дээр зогсож байх үед би гэр бүлдээ болон бидэнтэй хамт байсан бусад хүмүүст гэрчлэлээ хэлье гэж санагдлаа. Ингээд би, “Эдгээр итгэлтэй анхдагчид аврах багийнхныг хараад баяртай байсан бол Их Эзэн Есүс Христийн Цагаатгалаар дамжин ирдэг аврал бүр ч илүү агуу баяр баясгалан байж таарна.” Бид өөр өөр сүмд явдаг ч гэсэн дэлхийн Аврагч Их Эзэн Есүс Христ бол бүх Христэд итгэгчдийн итгэлийн цөм бөгөөд бүх хүн төрөлхтнийг аварсныг би хамт яваа

хүмүүстээ сануулав. Тэрбээр Цагаатгалаараа дамжуулан өнөөдрийн болон өнө мөнхийн төлөөх найдварыг бидэнд, та бидэнд бүгдэд нь өгсөн билээ.

Өнөөгийн цөлийг байлдан дагуулах нь

Анхдагчдын биеэр туулсан зовлон зүдгүүр тэдний амьдралд хүч чадал бий болгосон бөгөөд энэ хүч чадал бидэнд дамжин ирсэн юм. Итгэл, зоригоо харуулахын тулд тоотой хэдхэн юмаа тэргэнд ачаад тэргүүдээ гараар түрж 2,090 км газрыг явган туулахыг бидний ихэнхээс нь хүсэхгүй шүү дээ. Өнөөдөр бидэнд тулгарч байгаа сорилтууд өөр, бидний авирах уулс өөр, “замар цэцэг дэлгэрүүлэх” (Исаиа 35:1) хөндий ч өөр юм.

Гэвч байлдан дагуул хэмээн бидэнд өгөгдсөн цөл нь манай анхдагчдын Юта руу хийсэн бартаатай, хад чулуу, шороотой аяны замаас тэс ондоо ч гэсэн бидэнд тулгарч байгаа сорилт бэрхшээлүүд тэдэнд тулгарч байснаас амар хялбар биш юм.

Бидэнд тулгарч байгаа нэг хүндрэл бэрхшээл бол бид нүгэл хилэнцээр дүүрэн бөгөөд сүнслэг байдалд хайхрамжгүй хандаг, аминч үзэл, шударга бус явдал, шунал тачаалд живсэн дэлхийд амьдарч байгаа явдал мөн. Өнөөгийн цөл төөрөгдүүлсэн, зөрчилтэй мэдээллээр дүүрэн байна. Анхдагчид хадат уулсын хяр, цаст уулсын чулуу шороотой бартаат замыг Сионд төвлөрсөн итгэлээрээ ялан дийлж, Солт Лейкийн Хөндийд Сүмийг үндэслэн байгуулсан билээ.

Бид анхдагчдын тэрхүү хичээл зүтгэл, итгэлээр Их Эзэнд болон нийгэм, хамт олондоо үйлчлэхэд шийдвэр төгс байж, Бурханы зарлигуудыг биелүүлж, Түүний хуулиудаар амьдрах, хийдэг бүх зүйлдээ бусдын итгэл хүлээхээр шударга байхад хайхрамжгүй хандах ёсгүй, энэ талаар бид өөртөө өндөр шаардлага тавьдаг байх ёстой. Бид компьютер, таблет, гар утсаараа дамжуулан интернетээс амархан олж үзэж болох нүгэл хилэнцэт зүйлсээс зайлсхийх ёстой. Хэрэв бид эдгээр зүйлсэд хөнгөн хуумгай хандвал Люсифер бидний шийдвэр төгс байдлыг сулруулж, Их Эзэнд итгэх бидний итгэлийг бусниулж, Түүнийг болон бие биеэ хайрлах бидний хайрыг үгүй хийх болно. Ингэвэл бид дэлхийн цөлд төөрөн алга болно.

Хилэнцэт дэлхийн уруу таталтуудаас зайлсхийхэд өнөө үеийн жинхэнэ анхдагчаас итгэл, тэвчээр хатуужил шаардагдана. Өнөө үеийн анхдагчид бид Христийнхтэй адил амьдралаар амьдарч, нийгэм хамт олон



“Хүнд бэрх үе байлаа, бид өмч хөрөнгөө олон удаа дээрэмдүүлж, орон гэрээсээ олон удаа хөөгдөж, өвчин эмгэгт нэрвэгдэн, туйлын ядуу зүдүү амьдарч байлаа” хэмээн Эмили Партриж дурсчээ.



доторх сайн зүйлсийг дэмжин, гэр бүл, гэр орноо хүчирхэгжүүлэн, хамтдаа алхах хэрэгтэй байна.

Бид жинхэнэ ёсоор итгэдэг болсон үед “Би юу хийх ёстой вэ?” гэж асуудаггүй харин “Би улам илүү их юуг хийж болох вэ?” гэж асуудаг. Бидний итгэл Бурханы Сүнсээр бидний бодгалд батлагдсан үед итгэл нь бидний амьдралд нөлөөлөгч хүчин зүйл болж, бидний бодол санаа, үг яриа, үйл хэрэг бүрийг удирдан, биднийг тэнгэр рүү чиглүүлдэг. Бид өвөг дээдсийн нэгэн адил хүч чадал, удирдамжийн төлөө итгэлээрээ залбирдаг билээ. Энэ бол алхам тутамдаа итгэлээр амьдарна гэсэн үг. Бидний анхдагч өвөг дээдэс ийм байсан, өнөөдөр бид ч гэсэн ийм байх ёстой. Анхдагчдын алхааг удирдан чиглүүлж байсан мөнхүү тэр сүнсийг бид хүүхдүүд, ач зээ нартаа бий болгон төлөвшүүлэх ёстой.

Өнөөдрийн анхдагчид бид гэр бүлийнхээ амьдралыг удирдахын тулд Бурханы тусламжийг үргэлж эрэлхийлэн, хамтдаа алхах хэрэгтэй. Эцэг эх, эмээ өвөө, өвөг дээдсээ хүндэлдэг байсан өнгөрсөн үеийн чухал уламжлалаас суралцаж, тэд ирээдүйнхээ төлөө тэмцдэг байсан тэрхүү хүч

чадал, зоригийг бид ирээдүйгээ угтахын төлөө олж авцгаая. Их Эзэн Есүс Христийн амьдрал, үйлчлэл бидний зүрх сэтгэл, оюун ухаанд гэрэлтэн бадрах болтугай. Хожмын Үеийн Гэгээнтэн анхдагчдын амьдралд тэдний гэрчлэл асар их нөлөө үзүүлсэн шиг бидний гэрчлэл тийм эрч хүчтэй байх болтугай. ■

2012 оны 7-р сарын 15-нд Ютагийн Огденд хэлсэн үгнээс.

ЭШЛЭЛ

1. Гордон Б.Хинкли, “The Faith of the Pioneers,” *Ensign*, July 1984 оны 7-р сар, 3.
2. Оливер Б.Хантингтон, *Oliver B. Huntington Diary and Reminiscences, 1843 оны 6-р сар–1900 оны 1-р сар*, 26–28-ыг үзнэ үү.
3. Эмили Д.П.Янг нар, “Autobiography,” *Woman's Exponent*, 1884 оны 12-р сарын 1, 102-г үзнэ үү.
4. Эмили Д.П.Янг нар, “Autobiography,” *Woman's Exponent*, 1885 оны 2-р сарын 15, 138.
5. Эмили Д.П.Янг нар, “Autobiography,” *Woman's Exponent*, 1885 оны 8-р сарын 1, 37.
6. Фоеб Картер Вудрафф, Augusta Joyce Crocheron, *Representative Women of Deseret* (1884), 35–36.
7. Хенри Баллард, Douglas O. Crookston, хянан тохиолдуулсан, *Henry Ballard: The Story of a Courageous Pioneer, 1832–1908* (1994), 14–15.
8. Мапрапет МкНейл Баллард, Susan Arrington Madsen, *I Walked to Zion: True Stories of Young Pioneers on the Mormon Trail* (1994), 127.
9. Жон Числетт, LeRoy R. Hafen and Ann W. Hafen, *Handcarts to Zion: The Story of a Unique Western Migration, 1856–1860* (1960), 106, 107.

“Бид бүгдээрээ үхтэлээ өлссөн байлаа. Ээж намайг тэр айлаас ганц хурган гуа гуйгаад ирээч гэж явуулав. Учир нь бидэнд ганц цент ч байсангүй, хоолгүйгээс болж хүүхдүүд сульдан тамирдсан байв” хэ-мээн Маргарет МкНейл гэр бүл нь Ютад ирсний дараа ярьжээ.





Далын Ахлагч
Эрик В.Копишкэ

Гайхамшгуудын Бурхан

СЛОВАКИЙН ГЭГЭЭНТНҮҮД ШЕФФИЛДЭД

*Английн Шеффилд дэх санваартны удирдагчид, тойргийн зөвлөл
болон гишүүд бодит өсөлтийг нэмэгдүүлэхэд хүч чармайлтаа
нэгтгэснээр гайхамшигтай байдлаар адислагдсан ажээ.*

Бошиглогч Мормон итгэгчдийн цуглалалт дээр хийсэн нэгэн онцгой хүч нөлөөтэй номлолын үеэр: “Гайхамшгууд байхаа больсон гэж үү?” гэсэн энгийн асуултыг асуугаад тэр дороо: “Болгоогтун, би та нарт хэлнэ, Үгүй” (Моронай 7:29) хэмээн хариулсан байдаг.

Мормон тэгээд эцсийн өдрүүдэд тохиох авралын агуу ажил нь Ариун Сүнс, тэнгэр элчүүдийн ажил, бидний итгэл ба залбирал түүнчлэн Их Эзэний гайхамшгуудын харилцан хамаарал, хамтын үйл ажиллагаан дээр төвлөрөх болно гэдгийг тайлбарлажээ (Моронай 7:33–37, 48-ыг үзнэ үү).

Зүүн талд: Ахлагч Николас Пасс, Иосеф Маккэй (оруулгын доод талд) нар Словакийн Гэгээнтнүүд болон сонирхогчдоод заасан гайхамшигтай үе Фаргэйтийн ойролцоо Шеффилдийн явган хүний зам дээр номлогчид Людовит Кандрактэй (оруулгын дээд талд эхнэрийн хамт) уулзсан тэр мөч.

Зургадугаар сард болсон номлолын ерөнхийлөгчдийн сургалт семинар дээр Тэргүүн Зөвлөл ба Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга Есүс Христийн шавь нар болох Сүмийн гишүүд сайн мэдээг хуваалцах үндсэн үүрэгтэйг ойлгоход нь номлолын ерөнхийлөгчдөд тусалжээ. Бүрэн цагийн номлогчид энэхүү үүрэгт нь гишүүдэд тусалдаг. Гадасны ба тойргийн зөвлөл номлогчид болон гишүүдэд ажлаа зохион байгуулахад нь тусалж, дэмжлэг үзүүлдэг.

Англи дахь нэгэн тойргийн тухай энэхүү өгүүлэлд харуулснаар удирдагч, гишүүд болон тойргийн зөвлөлүүд дээрх зарчмуудыг олж авч орон нутгийнхаа нөхцөл байдалд тохируулан хэрэглэснээр хөрвөлтийн гайхамшигийг тохиолгон авчирч чадна.

Бурхан өнөөдөр, өчигдөр мөн үүрд адил байх болно гэдгийг бошиглогчид бүх судруудад бидэнд сануулсан байдаг (3 Нифай 24:6; С ба Г 20:12). Бид “Эцэг, Хүү, мөн Ариун Сүнсний нэрээр баптисм хүртээн . . . бүх дэлхий уруу явах” (С ба Г 68:8) зарлигийг биелүүлэхийг хичээхдээ дараах зарчмуудыг судалж, санах нь чухал юм:

- Бурхан өөрчлөгддөггүй.
- Бурхан бол гайхамшгуудын Бурхан.
- Бурханы хамгийн агуу гайхамшиг бол хүүхдүүддээ мөнхийн авралыг тохиолгон авчрах явдал юм.
- Бурхан бидний итгэлийн дагуу гайхамшгуудыг үйлддэг бөгөөд бид энэхүү итгэлээ ажил үйлсээрээ харуулдаг билээ.
- Ариун Сүнс хөрвөлтөд гол үүргийг гүйцэтгэдэг.

Золиослол хийх хүсэлтэй байх нь

Европын бүсэд үйлчилж байхдаа эдгээр зарчмууд Английн Шеффилдэд үйлдлээр хэрхэн гайхамшиг болон илрэхийг харах аз завшаан надад тохиосон билээ. Шеффилдийн Нэгдүгээр тойргийн бишоп Марк Дандон тойрогтоо өсч хөгжихөд нь туслахын тулд юу хийж болох тухайгаа 2008 оны сүүлчээр ул суурьтай эргэцүүлэн бодсон ажээ. Гадасны ерөнхийлөгч нь удирдлагын сургалтын хурал дээр “Та бүхэн номлолын ажилдаа амжилт олохын тулд юуг золиослоход бэлэн байна вэ?” гэж асуусан гэнэ. Тойргийн номлолын удирдагч гол үүрэг гүйцэтгэдэг, байнгын үйл ажиллагаатай тойргийн зөвлөл онцгой чухал, Сүнсний өдөөлтийг сонсох хүсэлтэй байх нь шийдвэрлэх ач холбогдолтой гэдгийг бишоп Дандон удирдагчдынхаа заавар зөвлөгөөнөөс мэддэг байв.

Бишоп Дандон ул суурьтай тунгаан бодож, залбирсны дараа санваарын түлхүүрүүдийг ашиглаж, Сүнсний өдөөлтүүдийг даган өөрийн хоёр зөвлөх

Грегори Нэтташип, Робэрт Макювэн хоёрыг чөлөөлж, Нэтташип ахыг тойргийн номлолын шинэ удирдагчаар, Макювэн ахыг тойргийн номлолын удирдагчийн туслахаар дуудав. Бишопын зөвлөлийн гишүүд хоорондоо их ойр дотно байсан учир энэхүү өөрчлөлт нь тэдний хувьд амаргүй байлаа. Бишоп чухам энэ л нөхцөлд тэрхүү шийдвэр нь зөв гэдгийг мэдэж байсан бөгөөд зөвлөхүүд нь дуудлагаа дуулгавартай хүлээн авсан юм.

Бишоп тойргийн номлолын шинэ удирдагчид болон тойргийн зөвлөлтэйгөө хамт залбирч, тойргийн өсөлтийн зорилго дэвшүүлэн, төлөвлөгөө гаргасны үр дүнд тэд төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх явцад үлэмж амжилт олсон ажээ. Хөрвөгчдийн баптисм нэлээд нэмэгдэж, олон хүмүүс Сүмд эргэж ирэн идэвхтэй болсон гэнэ. Гэвч тойргийн удирдлага өөрсдийнх нь итгэл, ажил үйлс тэдний огт бодоогүй арга замуудаар шагнагдах юм гэдгийг тэр үед мэдээгүй ажээ.



Хайраар нөлөөлөгдөн

2011 оны гуравдугаар сард нэг залуу номлогч хамтрагчтайгаа Шеффилдийн гудамжаар явж байсан хүмүүстэй ярилцаж байлаа. Хажуугаар нь эхнэртэйгээ хамт өнгөрч явсан нэг эрэгтэйг хараад, тэдэнтэй ярилцах хэрэгтэй гэсэн хүчтэй мэдрэмж Ахлагч Пасст төржээ. Ахлагч Пасс хамтрагчтайгаа уг хоёр хүн рүү хүрч очив. Энэ хос словакчууд байсан бөгөөд англиар ярьдаггүй учир тэдэнтэй хэл нэвтрэлцэх нь хэцүү байсан ч хажуугаар нь явж байсан нэг хүн хэлмэрчилж тусалсан гэнэ. Номлогчид тэдэнтэй гудамжинд ярилцах үеэрээ Анхны Үзэгдлийн зургийг ашиглаж, Сэргээлтийн захиасыг товчхон танилцуулжээ. Гэр бүлийн хос тэдэнд заахаар цаг товллоход зөвшөөрсөн гэнэ.

Тэр гэр бүлийн эцэг Людовит Кандрак Мормоны Номыг уншиж эхэлжээ. Тэр удалгүй тамхи татахаа больсон аж. Номлогчид тэдэнд заах явцдаа олон хэлмэрчийн тусламж авах шаардлагатай болсноос гадна өөрсдөө словакаар бага сага ярьдаг болсон гэнэ. 2011 оны тавдугаар

сарын 14-нд тэдний охидын нэг Людовит бас садан төрлийн өөр хоёр хүн баптисм хүртжээ.

Кандрак ах өөрийнхөө баптисм дээр гэрчлэлээ хуваалцжээ. Тэр номлогчидтой хэрхэн уулзсан тухайгаа хэлмэрчээр дамжуулан ярьсан гэнэ. Тэр Шеффилд хотын төвд Ахлагч Пасс түүний хамтрагч хоёрын дэргэдүүр өнгөрөх үед түүнд нэг л сайхан дулаан мэдрэмж төрөхөд тэрээр уг мэдрэмжийг хайхралгүй цааш хэд алхсанаа номлогчдыг эргэн харжээ. Хүмүүстэй ярилцах үедээ тэдний харуулсан хайранд түүний сэтгэл их хөдөлсөн ажээ. Кандрак ах номлогчид руу очихсон гэж бодсон ч цаашаа алхав. Тэгтэл нэг минутын дараа номлогчид түүн рүү хүрч ирэхэд тэр цочсон гэнэ.

Сүмд жилийн өмнө нэгдсэн өөр нэг Словак гэр бүлийн хамт эдний баптисм Английн Шеффилд дэх словакчуудын дунд өнөө үеийн хөрвөлтийн гайхамшигийн эх суурийг тавьсан ажээ. Эдгээр шинэ гишүүд долоо хоног бүр сүмд ирэхдээ гэр бүлийн бусад гишүүд, найз нараа дагуулж ирдэг гэнэ. Тэд гэр орноо номлогчдод нээлттэй байлгаж, хөршүүдээ сайн мэдээг сонсохыг урьдаг ажээ.

Ахлагч Пасс болон түүний шинэ хамтрагч Ахлагч Иосеф Маккэй эдгээр гэр бүлүүдэд байнга айлчлан ирдэг байлаа. Тэд эдгээр гэр бүлүүдэд зааж, үйлчлэн, тэднийг тайтгаруулж, адисалдаг байв. Энэ бол заах, суралцах болон сонирхогчид, хөрвөгчид, номлогчид ба гадас, тойргийн удирдагчид, түүнчлэн гишүүдийн хувьд Сүнсний бэлэг хүлээн авах гайхамшигтай цаг мөч байсан юм.

“Тэдэнтэй хамт байж, тэднийг бэхжүүл”

2011 оны зун намрын турш өөр олон словакчууд Сүмд нэгджээ. Гишүүдийн тоо өссөн нь гишүүдийг цуглааны байранд ирэх, тэндээс буцах унаагаар хангахад бэрхшээл учруулсан гэнэ. Словакийн итгэлтэй Гэгээнтнүүд хэлийг нь ойлгодоггүй ням гарагийн цуглаануудад оролцохын тулд нэг талдаа найман км замыг хэдэн долоо хоногийн турш явган явахаас өөр аргагүй байжээ.

Бишоп Марк Дандон (оруулгын дээд талд), тойргийн номлолын удирдагчид, тойргийн зөвлөлийн номлолын хүч чармайлт нь хэдэн арван словакчууд Сүмд нэгдсэний дараа ням гарагийн цуглаануудад оролцохын тулд Дарнелл Рөүд зүүн талд нь байдаг газраас 8 км хол явган явдаг болсноор урьд нь хэзээ ч төсөөлж байгаагүй арга замаар шагнагдсан ажээ.



2011 оны есдүгээр сард Шеффилд гадасны ерөнхийлөгчийн зөвлөл зохион байгуулагдахад бишоп Дандон гадасны шинэ ерөнхийлөгчөөр дуудагдсан ажээ. Сарын дараа Англи, Словакийн Гэгээнтнүүдэд зориулсан галын дэргэдэх ярилцлага болсон бөгөөд тэнд хэлмэрчид орчуулга хийсэн ажээ.

Ерөнхийлөгч Дандон индэр дээр сууж байхдаа словачуудын амьдардаг газарт цуглааны тусдаа байранд цуглаж байх Словакийн бүлгийг Шеффилдийн нэгдүгээр тойргийн бүрэлдэхүүнд зохион байгуулах хэрэгтэй юм байна гэдгийг мэдэрчээ. Удалгүй тохирох цуглааны байрыг олж, өрөөнүүд түрээсэлсэн гэнэ. 2011 оны арванхоёрдугаар сарын 11-нд цуглааны шинэ байранд анхны цуглаан болов. Шеффилдийн Нэгдүгээр тойргийн удирдагчид 50 хүн ирэх байх хэмээн өөдрөгөөр төсөөлөн бодож байтал 84 хүн, түүний дотор 63 словачууд ирсэн ажээ.

Шеффилд гадсыг өөрчлөн зохион байгуулсны дараа Роберт Макювэн Шеффилдийн Нэгдүгээр гадасны бишопоор дуудагджээ. Нэтгалийг ах номлолын удирдагчаар үргэлжлүүлэн үйлчилсэн байна. Тойргийн номлолын удирдагч, тойргийн зөвлөл аль аль нь бишопын удирдлагаар Словакийн Гэгээнтнүүдтэй “хамт байж, тэднийг бэхжүүлэхэд” (С ба Г 20:53) хөтөлсөн гайхамшигтай ажил хийжээ.

Тойргийн зөвлөл шинэ гишүүдийн хэрэгцээг хэрхэн хангах, тойргийн үйл ажиллагаануудад бүрэн оролцоход нь тэдэнд хэрхэн туслах болон хэлний бэрхшээлийг хэрхэн даван туулах зэрэг асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэдэг байлаа. Тэд шинэ гишүүдийн гэрээр айлчилж, бүрэн цагийн номлогчдын заадаг хичээлүүдэд оролцсоноос гадна тэднийг унаагаар хангадаг байв. Тэд бас Сүмийн материалуудыг словак хэл дээр захиалжээ. Тэд бас шинээр баптисм хүртсэн гишүүдийг нас барагсдын өмнөөс баптисм хийлгэхээр ариун сүм рүү авч явсан ажээ.

Тойргийн удирдагчид мөн Христийн Мэндэлсний Баяраар үйлчлэлийн төсөл зохион байгуулсан байна. Тойргийн гишүүд мөнгө хандивлаж, тоглоом, хувцас, бусад бэлгүүдийг цуглуулжээ. Христийн Мэндэлсний Баярын зоог бэлтгэхэд зориулж, баярын бэлэгтэй том цүнхнүүдийг Христийн Мэндэлсний Баярын өмнөх орой Словакийн Гэгээнтнүүд болон тойргийн хил доторх бусад гэр бүлүүдэд хүргүүлжээ.

Сүмд олон жил болсон гишүүд болон шинэ гишүүд бие биенийхээ хэлийг бараг ойлгодоггүй ч жинхэнэ элэгсэг халуун хайрыг мэдэрдэг байлаа. Баяр баясгалан, аз жаргал, сэтгэл санааны энэхүү гайхамшигтай

Баруун талд: Шеффилд дэх Словакийн бүлгийн удирдагч Фаро Данка ариун ёслолын цуглаан дээр хүмүүсийг тавтай морилохыг урьж байна. Тус бүлэг 2013 оны гуравдугаар сард салбар болон зохион байгуулагджээ. Оруулгын дээд талд: Шеффилдийн Нэгдүгээр тойргийн удирдагчид тойргийн зөвлөлийн хурал дээр. Оруулгын доод талд: Нэг эгч ариун ёслолын цуглаан дээр үг хэлж байгаа нь.

мэдрэмж гишүүд болон сонирхогчдод гүнзгий нөлөө үзүүлсэн ажээ.

Дараа жилийнх нь эцсээр энэхүү жижигхэн бүлэг гэр бүлээрээ бүгд баптисм хүртэж, Сүмд нэгдсэн гэр бүлүүдтэй Сүмийн хүчирхэг нэгж болон хөгжжээ. Эцгүүд нь Аароны болон Мелкизедек санваарт, хөвгүүд нь Аароны санваарт томилогдож, 20 гаруй хүүхэдтэй Хүүхдийн хэсэг бий болж, долоо хоног бүр 25-аас дээш залуучууд оролцдог Залуу эрэгтэйчүүд, Залуу эмэгтэйчүүдийн хөтөлбөрүүд зохион байгуулагдсан ажээ. Их Эзэн энэ бүлгийн хэлээр ярьдаг бөгөөд уг бүлгийг дэмжин тэдэнд туслах бүрэн цагийн номлогчийг Бүгд Найрамдах Чех Улсаас ирүүлжээ. Мөн тэдгээр гэр бүлүүд сүмд нэгдэж болох хүмүүсийн нэрсийг эх орондоо илгээсэн байна.

Гайхамшгуудын Бурхан

Юуны учир ийм гайхамшиг тохиов? Учир нь Бурхан гайхамшгуудын Бурхан байхаа зогсоогүйнх юм. Учир нь итгэлтэй номлогчид сайн мэдээг хүлээн авахаар бэлтгэгдсэн хүмүүсийг хичээнгүйлэн эрж хайсных, гадасны ерөнхийлөгч болон бишопууд Ариун Сүнсний удирдамжийг даган итгэлээр үйлдсэнийх, тойргийн зөвлөл үүрэг хариуцлагыг гартаа авч, эв нэгдэлтэй ажилласных, гишүүд бусад хүмүүстэй хайрын үндсэн дээр харилцаж, удирдагчдынхаа урилгын дагуу үйлдэж сурсных юм. Энэ нь бас тэд “Би бол гайхамшгуудын Бурхан, мөн энэ дэлхийд би өчигдөр, өнөөдөр мөн үүрд адил гэдгийг би үзүүлэх болно” (2 Нифай 27:23) хэмээн хэлсэн Бурханы үгсэд итгэл найдвартай байсных юм.

Шеффилд дэх амжилт нь нэг удаагийн үйл явдал биш юм. Энэ нь бошиглогчдоор дамжуулан бидэнд өгсөн амлалтуудыг сануулдаг бөгөөд эргэн тойрныхоо хүмүүсийг Христэд ирэхийг урьснаар Бурханы мутарт зэмсэг нь байх бидний итгэл, хүсэл эрмэлзлийг хүчирхэгжүүлэх болно. Хэрэв бид ингэвэл бусдад заах, тэднийг идэвхжүүлж, урамшуулан дэмжих боломжуудаар Их Эзэн биднийг адисалж болох байр сууринд өөрсдийгөө авчрах болно. Мөн Тэрбээр гайхамшгуудын Бурхан хэвээр байгааг батлах нотолгоонуудыг бид харах болно. ■



ИХ ЭЗЭНИЙ ТӨЛӨӨ АЖИЛЛАСАН НЬ

Би нөхөр Сирустэйгээ 2006 оны 3-р сарын 23-нд Ариун сүмд гэрлэсэн. Биднийг гэрлэхээс өмнө Сирус ням гараг бүр ажиллах шаардлагатай лабораторт, ээлжээр ажилладаг байсан ч ихэвчлэн шөнө дундаас өглөөний 8:00 цаг хүртэл ажилладаг байв. Нөхөр маань ажлынхаа дараа гэртээ ирж, дүрэмт хувцсаа тайлж, ням гарагийн хувцсаа өмсөөд, 9:00 цагт эхэлдэг сүмийн цуглаандаа шууд явдаг байлаа. Биднийг гэрлэсний дараа ч тэр энэ хуваариа үргэлжлүүлэн мөрдсөн.

Заримдаа тэр ажил дээрээ саатдаг байсан учир би сүм рүү ганцаараа явдаг байв. Бид Хүндэтгэлийн өдөр ажиллахгүй байхыг үргэлж хүсдэг байлаа. Бид 2006 оны 6-р сарын эхний ням гарагт гэрлэснээсээ хойш анх удаа гэр бүлээрээ мацаг барьж, Сирус ням гарагт ажиллахыг шаардаггүй ажлаар адислагдахын төлөө итгэлтэйгээр залбирав.

Хэд хоногийн дараа, ихэвчлэн 8:00-аас 9:00-ийн хооронд гэртээ ирдэг Сирус 10:00 болчихоод байхад гэртээ ирдэггүй, хааччихдаг байна аа гэж би гайхлаа. “Түүнийг

ажилд дэвшүүлсэн юм болов уу” гэсэн бодол гэнэт санаанд орж ирлээ. Тэгтэл Сирус 11:00 цагийн үед ирлээ. Тэр гэртээ орж ирээд, сайн, муу хоёр мэдээг зэрэг дуулгав.

Эхлээд сайн мэдээгээ дуулгаач гэж би түүнээс хүсэв. Бид удахгүй Филиппиний Айлиганаас Паней руу шилжих боллоо гэж нөхөр маань хэлэв. Бид гадасныхаа хүмүүст хайртай учраас эхлээд тэр сайн мэдээ надад таалагдсангүй. Тэд бидэнд нөхөрсөг ханддаг учраас бид ч бас тэдэнд тийм байдлаар ханддаг байлаа. Манайхтай ойрхон айл байхгүйг Сирус бид хоёр мэдэж байлаа.

Бид яагаад Паней руу нүүх хэрэгтэй юм бэ? гэж намайг асуухад тэр энэ бол сайн мэдээ учраас тэр гэв. Дарга нь Панейд өөр ажилд шилжүүлэхээр түүнтэй ярилцлага хийсэн ажээ. Би тэр даруй түүнээс шинэ ажил нь ямар цалинтай юм, ням гарагт ажиллах уу, үгүй юү гэдгийг асуулаа. Түүнийг “Үгүй!” гэж хэлэхэд миний баярласныг яана. Би нөхрөө чанга тэвэрч, шинэ ажил чинь бидний залбирал, мацаг барилтын хариу байна шүү дээ гэж хэлж билээ. Сирус хоёр сарын дараа Панейд шинэ ажлаа эхэлсэн билээ.

Тэнгэрлэг Эцэг бидэнд анхаарал халамж тавьдаг бөгөөд бид итгэлээ ашиглан, Түүний зарлигуудыг дуулгавартай дагасан үед биднийг адисалдаг. Би залбирал ба мацгийн зарчимд талархалтай байдаг. Нөхрийн минь ажил бидэнд адислал болдог. Одоо тэр тойрогтоо дуудлаа эрхэмлэн биелүүлж байна. Ням гарагт түүний хийдэг цорын ганц ажил бол Их Эзэний ажил юм. ■
Мари Жейн Суя, Филиппин

Нөхөр маань ажил дээрээ саатдаг байсан учраас би заримдаа сүм рүү ганцаараа явдаг байв. Тэр Хүндэтгэлийн өдөр ажилладаггүй байгаасай гэж бид үргэлж хүсдэг байлаа.



МӨНХИЙН ГЭР БҮЛ

Би 19 настай байхдаа, Эквадор улс руу гурван сарын хугацаагаар хүмүүнлэгийн үйлчлэлийн ажлаар явахынхаа өмнө өвөө, эмээ хоёр дээрээ сүүлчийн удаа очсон. Өвөөгийн маань эрүүл мэнд улам муудаж байсан учир тэр асрах байранд шилжиж очоод байв. Тэр насны доройтлын улмаас бие бялдарын бусад зовиурын хамт оюун ухааны хомсдолын улмаас шаналж байлаа.

Би гэр бүлийнхээ хамт асрах байранд орж ирээд, өвөө дээрээ ирсэн миний энэ эргэлт сүүлчийнх байж болохыг мэдсэндээ дотор бачимдах шиг болов. Өвөө минь намайг явсны дараахан талийгаач болсныг мэдээд би түүнийг орхиж явсандаа буруутай юм шиг санагдаж билээ.

Биднийг өвөөгийн өрөөнд орохоос өмнөхөн асрах байрын ажилтан түүнийг тэргэнцэрт суулгаад байлаа. Бид түүнийг асрах байрны нийтийн талбайд тэргэнцэртэй нь түрж аваачлаа. Ээж асрах байрны ажилтнуудын нэгэнтэй нь, харин 16 настай миний эмэгтэй дүү өвөөтэй ярилцаж байв.

Бие нь ямар байгааг асуухад өвөө юу ч хэлсэнгүй, ухаан санаа нь улам муудаж, будлиу болсон нь илт харагдана. Та хэдэн ач, зээтэй билээ? гэж биднийг асуухад тэр буруу хариулав. Тэгэхэд нь бид түүнийг өрөвдөж, маш чухал энэ асуултад хариулж, яг хэчнээн ач зээтэйг нь түүнд хэлж өгөв.

Өвөөгийнхөө төлөө миний зүрх шархиран өвдөж байлаа. Гэтэл өвөө маань ухаан нь орон гаран, бидний асуултуудад буруу зөрүү хариулж байснаа, гэнэт “Мөнхийн гэр бүл” гэж хэлэх нь тэр.

Би бүр мэл гайхаж хоцров. Ойрхон зогсож байсан асрах байрны

ажилтан өвөөг юу гэж хэлснийг ойлгосонгүй, харин дүү бид хоёр гайхан өөд өөдөөсөө харав. Түүний юу гэж хэлснийг бид хоёр хоёул тодхон сонссон. Гэтэл дараа нь тэр хоёр дахь удаагаа, “Мөнхийн гэр бүл” хэмээн хэлэв. Энэ удаад ээж бас түүний хэлснийг сонссон ажээ.

Тэр өдөр өвөө дээрээ бидний очсон тухай би өөр зүйлийг санадаггүй. Миний мэдэж байгаа бүх зүйл гэвэл бид уй гашууд автан мэгшин уйлсаар асрах байрнаас гарч явснаа, бид тэнд орхисон хүнтэйгээ энэ амьдралд дахин уулзахгүй гэдэгтээ

харамсавч, түүний хэлсэн энгийн хоёрхон үг зүрх сэтгэлд минь нигүүлслийн амар амгаланг авчирсны төлөө баяртай байснаа санадаг.

Өвөөгийн минь ухаан санаа улам доройтож байсан ч гэр бүлүүд үүрд мөнх оршиж чадна гэдэг бат бөх итгэл үнэмшил хийгээд мэдлэгээ сүүлчийн удаа бидэнтэй хуваалцсаныг би мэднэ.

Би удалгүй хүмүүнлэгийн үйлчлэлийн ажилдаа явсан. Өвөө минь намайг буцаж ирэхээс долоо хоногийн өмнө нас барсан тухай мэдээ ирэхэд би амар амгаланг мэдэрсэн. Би өвөөтэйгөө нэгэн цагт дахин учран золгоно гэдгийг тэр үед ч мэдэж байсан, одоо ч мэдэж байна. Ариун сүмийн ёслолуудын ачаар гэр бүлүүд үүрд орших болно. ■

Келли Х.Мудрөү, Юта, АНУ



Өвөөгийн маань ухаан орон гаран байлаа. Ухаан санаа нь муудаж, будлиу болсон нь илт харагдана.

ТА ИЙШЭЭ ОРЖ БОЛОХГҮЙ

Миний нөхөр Жон том биетэй, 1 метр 90 см өндөр, бараг 91 кг жинтэй хүн байлаа. Түүний хувьд нисэх онгоцоор энгийн суудлаар аялна гэдэг зөөлнөөр хэлэхэд эвгүй, хатуугаар хэлэхэд зовлонтой зүйл байлаа.

Бид хоёр 2006 оны 8-р сард бид Хавай дахь Бригам Янгийн Их Сургуульд сүмийн боловсролын системийн үйлчлэлийн номлолд дуудагдав. Номлолоо дуусгаад гэртээ харих болсон үед эх газар руу нисэх аяллыг нөхөр минь хэрхэн давна даа гэдэг бодол бидний санааг зовоож байлаа. Тийз бичүүлэх үед нэгдүгээр зэрэглэлийн нэг

суудал олдсонд бид баярлаж, энгийн суудлын тийзэн дээр нэгдүгээр зэрэглэлийн тийзний үнийн зөрүүт нэмж төлөв. Тэр ийнхүү зай ихтэй тохилог суудалд тухлан нислэгийн үеэр урт хөлөө жийн явах боломжтой боллоо.

Нислэг замынхаа тал дунд ороход би нөхрөө ямархуу явааг очиж харья гэж бодоод нэгдүгээр зэрэглэлийн хэсэгт дөхөж очтол босгон дээр зогсож байсан онгоцны үйлчлэгч намайг зогсоож,

“Би танд тусалж болох уу?” гэлээ.

“Тэгээч, би нөхрөө ямархуу явааг нь харах гэсэн юм” гэж би хариуллаа.

Намайг нэгдүгээр зэрэглэлийн хэсэгт дөхөж очтол босгон дээр зогсож байсан онгоцны үйлчлэгч намайг зогсоов.

“Уучлаарай. Та ийшээ орж болохгүй” гэж тэр эелдэгхэн атлаа хатуухан хэллээ.

“Миний нөхөр энд яваа юм аа. Би ганцхан хором л түүнийг яаж явааг нь хармаар байна.”

Онгоцны үйлчлэгч хаалган дээр хөндлөн зогсоод, “Уучлаарай, та ийшээ орж болохгүй. Харин би нөхөрт чинь таны хэлэх үгийг дамжуулж болно. Хэрэв тэр хүсвэл гарч ирээд тантай уулзаж болно. Энэ хэсэгт зөвхөн нэгдүгээр зэрэглэлийн тийзтэй зорчигчид л явдаг” гэж дахин хэллээ.

Би хормын төдийд гайхаж, урам хугарсан ч, түүний хөдлөх янзгүй байгааг хараад, чимээгүйхэн энгийн суудал руугаа буцав.

Тэгээд би судруудад болон бошиглогчдын үгсэд дурдагдааг алдар суугийн гурван зэрэглэлийн тухай бодов. Христ терестриел хаант улс дахь хүмүүс дээр (С ба Г 76:77-г үзнэ үү), харин үйлчлэгч тэнгэр элчүүд телестриел хаант улс дахь хүмүүс дээр айлчлан очих боловч (С ба Г 76:88-ыг), доод зэрэглэлийн хаант улсууд дахь хүмүүс хэзээ ч селестриел хаант улсад орж чадахгүй гэдгийг бид уншдаг билээ (С ба Г 76:112-ыг үз; мөн С ба Г 88:22–24-ийг үзнэ үү). Би өөртөө тохиолдсон явдлыг тунгаан бодоод, доод хаант улсууд дахь хүмүүс ямаршуухан байдгийг зэрвэхсэн хараад авсан юм шиг санагдлаа. “Уучлаарай, та ийшээ орж болохгүй!” гэсэн үгсийг сонсоод тэд юу гэж бодох бол? Таван сар орчмын дараа миний нөхөр хорт хавдраар нас барлаа. Нисэх онгоцонд надад тохиолдсон явдал наанадаж л хөшигний нөгөө талд “Та ийшээ орж болохгүй” гэсэн үгсийг дахин хэзээ ч сонсохгүйгээр амьдрах нэмэлт эрч хүчийг надад өгсөн юм. ■

Бонни Маршалл, Юта, АНУ



БАЯР БАЯСГАЛАНГ МӨНГӨӨР ХЭМЖИЖ БОЛДОГГҮЙ

Би саяхан ажилчдынхаа цалин тавих мөнгө авах гэж банку руу очлоо. Теллер миний мөнгийг данснаас гаргаж өгөхийн өмнө би 200 солын хэдэн дэвсгэртийг 50 солын дэвсгэртүүдээр задалж өгөхийг хүсэв. Теллер надад мөнгийг задалж өгсөн ч дэвсгэртийг тоолохдоо алдаа гаргасныг би харлаа.

Тэр надад 50 солын дэвсгэртүүдийг өгөхөд би данснаас мөнгө гаргаж өгөхийг хүлээхээр арагшаа болж зогсоод мөнгийг тооллоо. Теллер надад 1200 солын оронд 2200 буюу мянган сол илүү өгсөн байв. Тэрхэн агшинд би уруу татагдлаа. Банк зөндөө их мөнгөтэй юм чинь гэж би дотроо бодсон ч энэ мөнгө минийх биш учраас

буцааж өгөх хэрэгтэй гэдгийг зүрх сэтгэлээрээ мэдэрч байлаа.

Хэдэн хормын дараа теллер намайг гүйлгээндээ гарын үсэг зурна уу гэж дуудлаа. Тэр мөнгийг тоолж, надад өгөөд, “Ямар нэг өөр хүсэлт байна уу?” гэж асуув.

“Тийм ээ, байна. Би танд 1200 сол задлуулахаар өгсөн. Гэтэл та надад 2200 сол өгсөн байна” гэж би түүнд хэллээ.

Тэгээд би түүнд 2200 солыг өглөө. Тэр гар нь чичрэн мөнгийг хоёр удаа тоолов. Тэр харсан зүйлдээ итгэж ядан байснаа над руу хараад ямар нэг юм хэлэх гэсэн боловч чадсангүй, харин “Танд маш их баярлалаа” гэж хоёр удаа хэллээ.

Би банкнаас баяртайгаар гарч явлаа. Тэр долоо хоногт би

тойргийнхоо залуу эрэгтэйчүүдэд уруу таталтыг даван туулах тухай хичээл заахаар бэлтгэж байсан юм. Тэр хичээлээр банкна дээр болсон явдлыг хуваалцах сайхан боломж олдсон юм.

“Та тоглож байгаа юм биш үү. Мянган сол буцаагаад өгчихлөө гэж үү дээ?” хэмээн тэдний зарим нь наргиан болгон хэлж билээ.

“Баяр баяслыг мөнгөөр хэмжиж болдоггүй шүү дээ” гэж би инээмсэглэн хариулсан.

Уруу таталтыг даван туулах нь хэчнээн чухал болох тухай миний болон тэдгээр залуу эрэгтэйчүүдийн аль алиных нь гэрчлэлийг бэхжүүлсэн энэхүү туршлагын төлөө би талархалтай байдаг билээ. ■
Абелино Грандес Кастро, Перу

Банкны теллер надад 2200 сол буюу мянган сол илүү өгсөн байлаа. Илүү өгсөн мөнгийг өөрөө авахаар тэрхэн агшинд уруу татагдаж билээ.





Ахлагч
Кейт К.Хилбиг
2001-2012 онд
Далын гишүүнээр
үйлчилжээ

Үүрд МӨНХИЙН ТӨЛӨӨ АМЬДРАХ НЬ

Би залуучууд та нарыг өөрийн селестииел оршихуй болон үүрд мөнхийн гэр бүлээ үе үе төсөөлөн бодож байхыг хичээнгүйлэн хүсч байна.

Өнөөгийн залуучуудын (гэрлэсэн болон ганц бие) амьдралыг хоёр, гурван үеийнхний өмнөх залуучуудын амьдралтай харьцуулахад маш их ялгаатай бас хүнд хэцүү. Намайг коллежид сурч байхад өнөөгийн олон сорилт байгаагүй эсвэл их сул байсан.

Гэтэл та нар энэ мөчид энд байна. Ахмад үеийнхэн тань мөнхийн амьдрал руу орж байхад харин та нар урагшилж байна. Та нар энэ үед дэлхий дээр тохиолдлоор байгаа бус харин дэлхий бүтээгдэхээс өмнө зохиогдож, хэрэгжсэн бөгөөд өөрсдийн тань зөвшөөрсөн мөнхийн төлөвлөгөөний хэсэг юм.


Сайн мэдээний Сэргээлтийг мэдсэн нь та нарын хувьд хэчнээн азтай хувь тохиол билээ! Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрын дэргэд мөнх бус амьдралын өмнөх оршихуй гэж байсныг та нар мэднэ. Та нар сурч боловсрон, соригдож байсан билээ. Та нарт өсч хөгжих боломжийг олгосон хуулиудад та бүгд суралцаж, тэдгээр хуулиудыг дагадаг байсан учраас дэлхийд ирэх эрхтэй болсон юм. Энэхүү эрх нь та нарыг өргөмжлөл, эзэмшил, бурханлаг байдлыг олох зам дээр гаргасан билээ.

Та нар дэлхий дээрх мөнх бус амьдралын зорилгыг ойлгодог мөн мөнх бус амьдралын дараах боломжуудын тухай заалгасан байгаа. Дүгнэж хэлбэл, та нар өнгөрсөн үеэ эргэж хараад ирээдүйгээ цэгнэн дүгнэх мөнхийн боломжтой юм.

Танай залуучуудын дийлэнх нь Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүд биш байна, мөн дэлхий даяар ч ийм байгаа бөгөөд эдгээр бодит байдлын



ГЭРЭЛ ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ДАВИД СТОКЕР



Та нар цаг зуурдын зорилгын төлөө биш, харин үүрд мөнхийн зорилгуудын төлөө амьдар. Хэрэв та бас таны нөхөр буюу эхнэр, хэрэв хараахан гэрлээгүй бол ирээдүйн нөхөр буюу эхнэр тань дуулгавартай байх юм бол та нарын "тэргүүн дээр тань алдар суу үүрд мөнх нэмэгдэх болно" гэдгийг санагтун.

тухай бага мэдэж байна. Тэд төрөлт ба үхэл гэсэн хоёр үйл явдлаар тодорхойлогдох хайрцагт байгаа юм шиг амьдардаг. Тэд шийдвэр гаргахдаа ирээдүйгээ боддоггүй бөгөөд зан байдал нь ч мөн ийм байдаг. Тэд үнэн хэрэгтээ төрөхөөс үхэхийн хооронд буюу үүрд мөнхийн үүднээс авч үзвэл маш богинохон хугацаанд амьдардаг. Тэд мөнх бус амьдралын өмнөх оршихуйн тухай юу ч мэддэггүй, мөнх амьдралын тухай бага мэддэг.

Та нарын мөнхийн боломж

Харин та нар үүрд мөнхийн өөрсдөдөө амлагдсан боломжийг мэднэ. Их Эзэн Ариун сүмүүдэд лацдан холбуулсан хосуудад дараах амалтуудыг өгсөн юм:

“Та нар эхний амилуулалтад урагш гарах болно; . . . мөн хаан ширээнүүд, хаант улсууд, вант улсууд, мөн хүчнүүд, эзэгнэлүүд, бүх өндөрлөгүүд хийгээд гүнүүдийг өвлөх болно хэмээн тэдэнд хэлэгдэх аваас, . . . мөн хэрэв та нар миний гэрээг дагах аваас, мөн үүгээр гэмгүй цусыг урсгахаар аллага үйлдэхгүй байх аваас, тэдэн дээр энэ амьдралд болон бүх үүрд мөнхөөр дамжуулан миний үйлчлэгч тэдэн дээр юуг ч тавилаа гэсэн бүх зүйлд энэ нь хийгдэх болно; мөн тэднийг дэлхийгээс гадна байхад бүрэн хүчтэй хэвээр байх болно; мөн, тэдний тэргүүн дээр лацдагдсан тэрхүү алдар суу нь бүрэн дүүрэн мөн үүрд хийгээд мөнхөд үр удмынх нь хувьд үргэлжлэл байх өөрсдийн өргөмжлөл хийгээд бүх зүйлд дэх алдар суу тийш тэнд буй тэнгэр элчүүд мөн бурхдын дэргэдүүр өнгөрөх болно.”

“Тэгээд тэд бурхад байх болно, учир нь тэдэнд төгсгөл гэж үгүй; тиймийн тул, тэд үүрдээс үүрдэд байх болно, учир нь тэд үргэлжилсээр байх болно; тийнхүү тэд бүхний дээр байх болно, учир нь бүх зүйл тэдэнд захирагддаг бөлгөө. Тийнхүү тэд бурхад байх болно, учир нь бүх зүйл тэдэнд буй, мөн тэнгэр элчүүд тэдэнд захирагддаг болой” (С ба Г 132:19–20).

Гэр бүлтэйгээ хамт үүрд амьдрах ирээдүйн селестиел оршихуйгаа үе үе эргэцүүлэн бодож байхыг би та бүхнээс хичээнгүйлэн хүсч байна. Энэхүү хэмжээлшгүй алдар суу болон давуу байдлыг бид бүрэн дүүрэн ойлгох боломжгүй юм. Гэвч бидний төгс ойлгож байгаа зүйл бол та бүгд өөрсдийн “анхны байдлыг” (Абрахам 3:26), хадгалж, мөнх бус амьдралын өмнөх бүх сорилтыг биеэр туулан, итгэлээ ашигласнаар мөнх бус биеийг хүлээн авч, энэ дэлхийд ирэх онцгой боломж та бүхэнд тохиосон билээ.

Тиймээс, та нар цаг зуурдын зорилгуудын төлөө биш, харин үүрд мөнхийн зорилгуудын төлөө амьдар. Хэрэв та бас таны нөхөр буюу эхнэр, хэрэв хараахан гэрлээгүй бол ирээдүйн нөхөр буюу эхнэр тань дуулгавартай байх юм бол та нарт “тэргүүн дээр тань алдар суу үүрд мөнх нэмэгдэж” (Абрахам 3:26) хүүхэд бүртгээ өгсөн Бурханы агуу амлаалт хэрэгжих болно.

Хэрэв та нар Бурханы зарлигуудад дуулгавартай байх юм бол Түүний амлаалтууд бүрэн биелэгдэх болно. Тохиолдох бэрхшээл зовлон гэвэл хүмүүний бодгалийн дайсан тэдний оюун ухааныг харалган болгохоор хичээнэ. Хэрэв хүмүүс зөв бурууг ялган таних чадвараа алдагдуулах боломжийг Сатанд олгох юм бол тэд дэлхийн зүйлсээр харалган болно.

Та нарыг мөнхийн зүйлсийн тухай юу мэддэгийг Христийн ертөнцийн шашны онолчид болон эрдэмтэд мэддэггүй, харин Сатан мэддэг! Тэр мөнх бус амьдрал дахь та нарын бэлтгэл, дэлхий дээрх та нарын зорилго, түүгээр ч барахгүй та нарын мөнхийн боломжийг мэддэг.

Чөтгөр гэдэг үгийн еврей хэлний орчуулга нь “хорлон сүйтгэгч” юм.¹ Үүрд мөнх рүү хийх бидний аяныг чөтгөр хорлон сүйтгэхийг хүсдэг. Тэр энэ амьдрал дахь, мөн



Бурхан та нарт муугаас сайныг сонгох эрхийг төдийгүй бас муугаас сайныг сонгох хүчийг өгсөн юм! ...мууг сайн нь дийлдэг! Эцсийн эцэст Сатан биш, та өөрөө шийдвэр гаргадаг шүү дээ.

энэ амьдралын дараах бидний боломжид саад учруулахыг хичээдэг. Тэр та нарыг сонгох эрхээ буруу ашиглаасай хэмээн хүсэн хүлээдэг. Зарим залуу хүмүүс сонгох эрхээ ашиглан буруу зүйл хийхээр сонгох нь бие даасан байдлаа нотлон харуулах хамгийн сайн арга гэж боддог. Мунхаг хүн ингэдэг, бүр бүлэг хүмүүс ч ийнхүү үйлдэж болно.

Хэрэг дээрээ, бие даасан байдал бол үнэн бодитой эрх чөлөө бөгөөд үргэлж зөвийг сонгосноор харагдаж, биеллээ олдог. Бурхан та нарт зөвхөн сайн, муу хоёрын дундаас сонгох *эрхийг* төдийгүй харин хэзээ ч муут биш *зөвхөн сайныг* сонгох *хүчийг* өгсөн юм! Бурхан үүгээр та нарт Сатан болон түүнийг дагалдагчдад байдаг хүчнээс илүү их хүчийг өгсөн юм. Эцсийн эцэст, Сатан биш, харин та өөрөө шийдвэр гаргадаг шүү дээ.

Тэнгэрлэг Эцэг энэхүү мөнх бус туршлагыг чухал зорилгын тулд бид соригдож, нүгэл хилэнцийг ялахын тулд бий болгосон юм. Тэрбээр гай зовлон, уруу таталтуудыг тусгайлан төлөвлөх нь ховор ч, мөнх бус амьдралд эдгээр нь

элбэг тохиолддогийг мэддэг. Биднийг дэлхий дээр байгаа үедээ “эгэл хүмүүнээ” (Мозая 3:19-ийг үзнэ үү), даван туулахад суралцаж, дэлхийн шинж чанараас татгалзан, зохистой байдлаа нотлон харуулахыг Тэрээр хүсдэг. Сатан үүнээс өөр бодолтой байдаг. Тэр бидний өсөлт хөгжилтийг тасалдуулахын тулд чадах бүхнээ хийх болно.

Дэлхийн уруу таталтууд

Энэ дэлхий Сатаны зальжин, ичгүүр сонжуургүй өөгшүүлэл хийгээд тусламжтайгаар бусад хүмүүсийн хүлээн зөвшөөрөх зүйлийг хийдэг байх, үе тэнгийнхнийхээ олонхийн хийдэг зүйлийг хийх, зохисгүй кино, видео тоглоомноос түр зуурын сэтгэл хөөрлийг олох, ёс суртахуунгүй явдал (түүний дотор порнограф), бүдүүлэг үг хэлэх, шударга бус байхад уруу татагдахыг танд санал болгодог. Гэрлэлтийг Бурхан эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд томилдог бөгөөд эцэг эх хоёр нь үр хүүхдээ өгсөн хүмүүжүүлэх үүргийн тухай гэр бүлийн бурханлаг төлөвлөгөөний талаарх ойлголтыг тань Сатан бусниулахыг хичээх болно.²

Хэрэв та санамсаргүйгээр ч гэсэн Люсиферийн урилгыг хүлээж авбал, тэр таны мөнхийн адислалуудыг дээрэмдэх болно. Сатанд үүрд мөнхийн аз жаргалын төлөө хөгжин цэцэглэх боломж байхгүй. Тэр тэнгэр дэх дайн гэрчлэлээр тулалддаг дайнд тэр *ялагдсаныг* санагтун (Илчлэлт 12:11-ийг үзнэ үү). Тэр дайнд Христийн итгэлтэй дагалдагчид түүнийг дагалдагчдынх нь хамт ялсан юм. Энэхүү сүйрлийн үр дагавар гашуун байлаа: Сатаны бүх дагалдагчид буюу тэнгэрийн түмний гуравны нэг нь тэнгэрээс хөөгдсөн билээ. Тэд хэзээ ч бие махбодтой болохгүй эсвээс мөнх амьдралын боломж тэдэнд байхгүй юм.

Лихай хүү Иаковтаа хандан ийн хэлжээ:

Мөн би, Лихай, уншсан зүйлүүдийнхээ дагуу, Бурханы нэгэн тэнгэр элч, бичигдсэний дагуу тэнгэрээс унасан хэмээн бодох ёстой болов; иймийн тул, тэрээр Бурханы өмнө хорт мууг эрэлхийлсний учир чөтгөр болсон бөлгөө.

“Мөн тэрээр тэнгэрээс унасан, мөн үүрд зовлонг болсны учир, тэрээр түүнчлэн бүх хүн төрөлхтний зовлонг эрэлхийлсэн болой” (2 Нифай 2:17–18).

Мөн Лихай ийн заасан юм: “Иймийн тул, хүмүүн нь бие махбодын дагуу чөлөөт болой; мөн хүнд шаардлагатай бүх зүйл тэдэнд өгөгдсөн билээ. Мөн тэд бүх хүмүүний агуу их Зуучаар дамжуулан, эрх чөлөө болон мөнх амьдралыг сонгох эсвэл чөтгөрийн хүч мөн боолчлолын дагуу, боолчлол болон үхлийг сонгох эрхтэй; учир нь тэрээр бүх хүмүүн өөрийн адил зовлонг байж болохыг эрэлхийлдэг бөлгөө” (2 Нифай 2:27).

Өнөө үед мансууруулах бодисын наймаачид, порнографыг дэлгэрүүлэгчид, хилэнцэт үзвэр цэнгүүнийг болон худал хуурмаг зүйлсийг хөхиүлэн дэмжигчид, даруу бус хувцаслахыг өөгшүүлэн зөвлөгчид, ёс

суртахуунгүй явдалд уруу татагчид, уламжлалт гэр бүлийг шүүмжлэгчид бүгд сүнслэг амьдралыг бууруулж, бүр Бурханы хөвгүүд, охидыг сүнсний үхэлд хүргэх буруу сонголтуудыг өөгшүүлж байна.

Эдгээр уруу таталтуудад урхидуулсан золгүй хүмүүсийг хараад Сатан инээд алдан хөхөрдгийг санагтун (Мосе 7:26-г үзнэ үү). Түүний арга олон янз боловч, зорилго нь адилхан: дуулгаваргүй байдал ба үүний улмаас адислалуудаа алдах явдал юм.

Дуулгавартай байснаас ирдэг адислалууд

Дуулгавартай байдал адислалуудад үүд хаалгаа нээж, амар амгаланг авчирдаг. Бурууг хийх уруу таталт хүчтэй байсан ч зөв зүйлийг хийхийн тулд ухамсартайгаар хийсэн сонголтынхоо тухай бод. Магадгүй энэ нь зохимжгүй санаа бодлыг зайлуулахад эсвээс худал хэлэхэд их ойрхон байсан ч үнэнийг хэлсэн тухай байж болно. Эсвэл хүлээн зөвшөөрөхүйц гэж зар сурталчилгаагаар сурталчилж байсан ч хэрэг дээрээ зохистой бус нь нотлогдсон киноноос (эсвэл өөр ямар нэг ариун бус газраас) гарч явах шийдвэр гаргасан тухай байж болох юм.

СУРГААЛЫН ҮНДСЭН САНААНУУД

Хожмын Үеийн Гэгээнтнүүд
Сэргээлтээр дамжуулан,

- Тэнгэрлэг Эцэг дуулгавартай хүмүүст мөнхийн алдар сууг амласныг
- Сатан “бүх хүн төрөлхтний зовлонг эрэлхийлдгийг
- Уруу таталтыг даван туулах хүч Бурханы хүүхдүүдэд байдгийг мэдсэн юм.

Зөв шийдвэр гаргасан тухайгаа эргэн харахад санаа сэтгэл тань ямар байдаг вэ? Баяртай байдаг уу? Үйлдлээ хянах сэтгэлийн тэнхээтэй байгаагаа мэдэрдэг үү? Их Эзэний өмнө итгэл үнэмшил тань өсөн нэмэгдсэнийг мэдэрдэг үү? Нүгэл хилэнцийг эсэргүүцэх чадвар тань өсөн нэмэгддэг үү? Энэ бол хүч юм; энэ бол эрх чөлөө юм!

Хэрэв та нар уруу таталтыг тууштай эсэргүүцвэл, эсэргүүцэж байгаа зүйлийн мөн чанар өөрчлөгддөггүй, харин түүнийг эсэргүүцэх та нарын хүч чадал өсөн нэмэгддэг.³ Энэ тохиолдолд та тулгарсан ямар ч уруу таталтыг даван туулж чадна (1 Коринт 10:13-ыг үзнэ үү).

Та нар бурханлаг гарал үүслээ мэднэ. Та нар бурханлаг хувь тавилангаа мэднэ. Би та нарыг зуурдын зорилгоор *амьдрахад бус* харин үүрд мөнхийн зорилгуудын төлөө “өөрийнхөө доторх бурханлаг байдалд тэнцэхээр” амьдрахад урьж байна.⁴

Та нар бол гайхалтай сайхан залуучууд. Бурханы хаант улсын болон нийгмийн ирээдүйн удирдагчид та нар энэхүү эцэс төгсгөлгүй тулалдаанд ялагдах ёсгүй. Та нар тэнгэр дэх дайнд ялсан юм; газар дээрх дайнд ялж чадна. Цаг зуурдын зорилгоор бус, харин үүрд мөнхийн зорилгоор амьдар.

Зарлигуудыг биелүүлэхэд та нарын хүч чармайлт чухал болохыг анхаарагтун, учир нь селестиел хаант улсын хамгийн дээд зэрэглэлд Бурханы оршихуйд буцаж очих нь та нарын шагнал юм. ■

2007 оны гуравдугаар сарын 20-нд Айдахо дахь Бригам Янгийн Их Сургууль-дээр онцгой цугларалт дээр хэлсэн үгнээс нь авав. Англи хэл дээрх бүрэн эхийг <http://web.byui.edu/DevotionalsAndSpeeches>-ээс үзнэ үү.

ЭШЛЭЛ

1. Bible Dictionary, “Devil.”
2. “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” *Лиакхона*, 2010 оны 11-р сар, 129-ийг үзнэ үү.
3. *Teachings of Presidents of the Church: Heber J. Grant* (2002), 35.
4. Гордон Б.Хинкли, “Each a Better Person,” *Лиакхона*, 2002 оны 11-р сар, 99.



АНХНЫ ҮЙЛДЭЛ, ДАВИД ЛИНН © ИУ, СҮМИЙН ТҮҮХИЙН МУЗЕЙН ЗӨВШӨӨРЛӨӨР НИЙТЛЭВ

Агуу итгэлийн туршлага

Мэллиса Зентено
Сүмийн сэтгүүлүүд

Эцэг эх хоёр нь салахад Клайр (нэрийг өөрчлөв) зургаан настай байжээ. Тэр түүнээс хойш олон гэр бүл салж, гишүүд нь донтох, Сүмд идэвхгүй болох, санаа сэтгэлээр унах явдалтай тэмцэлдэх болсныг гэрчилжээ. Клайр уйтгар гунигт автагдаж, гэр бүлд итгэх итгэлээ алдсан ажээ.

“Би гэрлэх хувь тавилангүй хүн юм байна” гэж тэр өөртөө хэлдэг байсан. “Миний ирээдүй ч бас л ийм байх болов уу гэсэн айдсаа би дотроо нуудаг байлаа” гэж тэр ярилаа.

Клайр гэр бүлийн ач холбогдлын талаар гутрангүй үзэлтэй байснаас гадна тэр ганцаарддаг байжээ. Тэр өсвөр насны охин байхдаа нэг өдөр цөхөрсөндөө Тэнгэрлэг Эцэг үнэхээр байдаг эсэхийг мэдэхээр залбирчээ. Би үйлж ярихаа болиход цээжинд шатах мэт халуу оргиж, амар амгалангийн хүчтэй мэдрэмж тэр даруй мэдрэгдлээ. “Тэнгэрлэг Эцэг байдгийг бас намайг үргэлж хайрладаг бөгөөд сорилт бэрхшээлүүдээр дамжуулан надад тусалдгийг би мэдсэн” гэж тэр ярилаа.

Клайрын хүлээн авсан хариу Бурханд болон гэр бүлийн талаарх Түүний зарлигуудад итгэх итгэл болон гэрчлэл түүнд бий болоход нь сүнслэгээр нөлөөлжээ. Тэр зөвхөн залбирахаа үргэлжлүүлсэн төдийгүй бас судруудаа уншиж, семинарт яван, зарлигуудыг сахидаг болжээ.

Одоо Клайр гэрлэсэн бөгөөд сорилт бэршээлийг итгэлээр даван туулахад суралцаж байна. “Нөхөр бид хоёр гэрчлэлээ, түүний дотор бидний Тэнгэрлэг Эцэг, бидний Аврагч хоёр амьд гэдэг гэрчлэлээ үргэлж хөгжүүлж байхаар шийдсэн учраас бат бөх гэр бүлийг бий болгон төлөвшүүлэх нь боломжтой эсэхэд би санаа зовдоггүй болсон бөгөөд сайн мэдээ бол үгүйсгэх

аргагүй үнэн гэдгийг санадаг билээ.”

Клайр энгийн бөгөөд чин сэтгэлийн залбирлаараа Бурханд итгэх итгэлээ төлөвшүүлсэн ажээ. Харин бид Тэнгэрлэг Эцэгт итгэх итгэлээ төлөвшүүлэхийн тулд өөр юу хийж болох вэ? Дэлхий даяарх залуу хүн бүр сорилт бэрхшээлтэй тулгардаг бөгөөд Их Эзэнд итгэх итгэлээ хэрхэн хөгжүүлж, Түүний хүсэл, Түүний арга зам, Түүний цаг хугацаанд хэрхэн найдаж сурсан тухайгаа хуваалцаж байна.

Үргэлж талархалтай бай

Германы Хессегийн Стефани Эгли адислалуудаа тунгаан бодсон нь Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөө болон Түүний цаг хугацаанд итгэдэг болоход нь тусалсан ажээ.

Стефани нэгэн сайн найзтай харилцаатай болсон ч энэ харилцаа бүтэлгүй болсны дараах адислалуудынхаа тухай бичиж эхэлжээ. “Бид хоёр болзоогүй ч гэсэн бидний энэ харилцаа илүү дотно болж хөгжинө гэдэгт би үргэлж найддаг байсан. Тэр надад найз охинтой гэж хэлэхэд миний найдвар нурсан юм.”

Зүрх сэтгэл нь шархалсан Стефани *Лиакхонад* нийтлэгдсэн нэг өгүүллийг уншаад тайтгарчээ. Хэрхэн адислагдсанаа, бүр ганц бие байгаа нь ч гэсэн адислал болох тухайгаа бичье гэж түүнд бодогдсон аж.

Зөвхөн гэрлэх боломж олдоогүй учраас л адислалууд аваагүй гэж бодож болохгүйг тэр ойлгоход түүний хийсэн жагсаалт нь тусалсан гэнэ. Их Эзэн түүнийг бага сургуулийн багш болж, хүүхдүүдтэй ажиллах боломж олгон адисалсныг Стефани ойлгов. Тэр ерөнхий чуулганд очиж, Өсвөр үеийнхэнд зориулсан онцгой хөтөлбөрийн зөвлөхийн хувиар

оролцсон ажээ. Тэр өөрийн оролцсон ганц бие залуучуудын чуулгануудаар дамжуулан хэдэн дотны найзтай болсон байлаа.

Гэвч хамгийн том адислал нь түүний хэлснээр, өөд болохоос нь өмнө эмээтэйгээ хэсэг хугацаанд хамт байсан явдал ажээ. Эмээ нь хол амьдардаг байсан учраас түүнд, дүү нарт нь бас үеэлүүд нь түүн дээр очиж, түүнийг асарч халамжлах боломжгүй байжээ.

Стефани адислалуудаа баримтжуулснаас хойш таван жил өнгөрөв. Тэр Ариун сүмд гэрлэх боломж олдох цагаа хүлээсээр байлаа. “Би мөнхийн ханьтайгаа учрах цагаа мэдэхгүй байсан ч тэр цаг ирэх болно гэдэгт итгэлтэй байна. Тэр цаг иртэл, суралцаж өсч хөгжихөд надад тусалсан туршлагуудаа үргэлжлүүлсээр байх болно гэдгээ би мэдэж байна” гэж тэр ярилаа. Тэнгэрлэг Эцэг түүнийг элбэг дэлбэгээр адисалсан бөгөөд хэрэв тэр итгэлтэй байх юм бол Тэр цаашид ч түүнийг адисалсаар байх болно гэдгийг тэр мэддэг байсан.

Бурханы үгийг өдөр бүр унш

АНУ-ын Колорадогийн Даниел Мартуссело гэр бүл салахаа эцэслэн шийдсэн бөгөөд шинэ нөхцөл байдалд амар амгаланг мэдрэх нь хэцүү байсан ажээ. Тэр дахин гэрлээгүйгээр барахгүй ажилгүй болж, бас шинээр эцэг болсон гэнэ. Ийм явдал яагаад, тэр тусмаа шударга байхыг тэрээр үргэлж хичээсээр байхад түүнд тохиолдсоныг ойлгосонгүй.

Даниел ганцаардаж, сэтгэл санаагаар унасан үедээ судруудад ханджээ. “Өнгөрсөн үед судрууд уншаад мэдэрсэн тайтгарлаа эргэн саналаа, иймээс би өдөр бүр судар уншихад анхаарлаа төвлөрүүлсэн” гэж тэр



ЭДГЭЭРИЙГ САНАГТУН, ДАВИД ЛИНН ХУУЛГАРЛАЖ БОЛОХҮЙ

ярилаа. Өдөр бүр судар судлахад цаг гаргана гэдэг нь телевиз, интернет зэрэг бусад зүйлд зориулах цагийг багасгана гэсэн үг. Харин энэ нь золиослол байгаагүй юм гэж тэр хэллээ. “Би судар унших үедээ тайтгарал болон удирдамж хүлээн авдаг байсан. Бусад зүйлс ач холбогдлоороо хоёрдугаарт ордог байлаа. Би нэг судар уншиж дуусаад л нөгөөг залгаж уншаад байдаггүй, хариултуудыг хайж, зорилготой уншдаг байлаа.”

Хүн болгонд асуудал бэрхшээл тулгардгийг Даниел судруудаас мэдээд тайтгарчээ. “Бошиглогчид болон бусад хүмүүс зөв шударга байсан атал тэдэнд мөн л хүнд

сорилтууд тулгардаг байсан шүү дээ. Тэдний туршлагыг уншсан нь амьдралын аль нэг үед бид бүгдэд зовлон зүдгүүр тохиолддог ч гэсэн бид тэрхүү зовлон зүдгүүрийг үзсэнээрээ Христэд улам илүү ойртдог” гэж тэр хэллээ.

Түүнээс гадна, өдөр бүр судар уншсан нь түүний ачаа дарамтыг нимгэлсэн. Учир нь Аврагчийг өдөр тутмын амьдралдаа оролцуулах нэг арга нь болжээ. “Миний уншсан шүлгүүдээр дамжуулан Бурхан надтай ярихад, юмс илүү сайн болж, Түүний тусламжтайгаар энэ туршлагаас ямар нэг сайн зүйл гарах болно гэдэгт би итгэдэг байлаа.”

Бурханы зүйлсийг бүхний түрүүнд тавь

Тайваний По Наен Каошиюнг найз бүсгүй Мей Вад гэрлэх санал тавьсаныхаа дараа, “Би өмнө нь өөр хүмүүстэй болздог байсан. Наад зах нь гурван удаа болзсон. Нэг хүнтэй нэлээд дотно харилцаатай байсан ч энэ холбоо дараа нь тасарсан. Эдгээр туршлага мөнхийн харилцаа руу хөтөлж болох урт удаан хугацааны харилцаа байдаг гэдэгт итгэх миний итгэлийг ганхуулсан” хэмээн хэлснээсээ тэр айсан ажээ.

По Наен Мей Ватай гэрлэх талаар залбирсны дараа амар амгаланг

мэдэрсэн ч хариу хүлээж авна гэдэгтээ эргэлзэж байв. Тэр Ариун Сүнснээс ирсэн баталгааг мэдэрсэн үү? Эсвэл сэтгэл хөдлөл нь түүнийг төөрөгдүүлсэн хэрэг үү? Түүний сүй тавилт Ариун сүм рүү хөтлөх болов уу? Эсвэл энэ харилцаа бүтэлгүй болох болов уу?

Энэ үед По Наен институтын хичээл дээр сонссон, Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсоны (1899–1994) дараах үгсийг санажээ: “Бид Бурханыг амьдралынхаа бүхий л зүйлсээс дээгүүр тавих ёстой. . . . Бид Бурханыг нэгдүгээрт тавьсан үед бусад бүх зүйл зохих байрандаа орох буюу бидний амьдралаас гээгдэж алга болдог.”¹

Энэ зөвлөгөө По Наены амьдралд маш чухал шийдвэр гаргахад нөлөөлжээ. “Би амьдралдаа Бурханы зүйлсийг нэгдүгээрт тавьж, Түүнд чин үнэнч, итгэлтэй байсан үед буруу зүйлс алга болж, сайн зүйлс халааг нь авдгийг мэдсэн” хэмээн тэр ярилаа. Тэр Бурханыг болон Мей Ватай харилцах харилцаагаа нэгдүгээрт тавьсанаар Тэнгэрлэг

Эцэг үүнд нь тусалжээ. Итгэлээр жигүүрлэсэн По Наен Мей Ватай Хонг Конгийн Ариун сүмд гэрлэсэн байна. “Би Их Эзэнд итгэл найдвараа тавьснаар маш ихээр адислагдсан” гэж тэр хэллээ.

Түүний хүслийг биелүүлэхийг эрэлхийл

Тэнгэрлэг Эцэгт итгэх итгэлийг төлөвшүүлэх өөр нэг арга зам бол Түүний хүслийг биелүүлэх явдал мөн. Испаний Таррагонагийн Марта Фернандез Реболлос жишгүүдээ баримтлахыг сонгосноор Тэнгэрлэг Эцэгт итгэж сурсан юм.

Түүний болздог залуу Сүмийн гишүүн биш байсан бөгөөд Сүмд нэгдэх сонирхолгүй байсан гэнэ. “Эрэгтэй хүнтэй зөвхөн энэ амьдралд л гэрлэж болно гэсэн олон учир шалтгаан, ийм бодол санаа мөнхийн гэрлэлтийн талаар миний заалгасан зүйлтэй зөрчилдөж эхлэн, энэхүү төөрөгдөл, сэтгэлийн эмзэглэл намайг олон сар шаналгаж, бүр нулимс урсган уйлахад хүргэсэн юм” гэж тэр ярилаа.

Марта шийдвэр гаргах гэж хичээн, өрөөндөө ороод патриархын адислалаасаа удирдамж хайлаа. Хэрэв тэрээр зөвийг сонговол, түүнд юу амлагдсаныг уншжээ. Тэр юу хийх ёстойгоо мэдээд гэнэт уйлсан гэнэ. “Өмнө дурдсан зөрчлийн үр дагавар надад цаашид асуудал удсангүй. Ирээдүйд надад юу тулгарахыг би мэдэхгүй байсан ч, Их Эзэний талд байсан цагт сайн зүйлс тохиох болно гэдэгт огтхон ч эргэлзэхгүй итгэлтэй байлаа. Бид сонор соргог байж, Ариун Сүнсний өдөөлтүүдийг дагавал зөв шударга байдлын үр жимс ‘өмнө нь [түүний] амссан бүхнээс дээгүүр тэргүүн амтат’ (1 Нифай 8:11) болохыг би мэдсэн билээ.”

Сургаалт Үгс 3:5–6-гаас бид:

“Бүх зүрхээрээ ЭЗЭНД итгэ. Өөрийн ойлголтод бүү түшиглэ.

Өөрийн бүх замаараа Түүнийг таньж мэд. Тэрээр чиний замыг шулуун болгоно” хэмээн уншдаг билээ.

Бурханд болон Түүний төлөвлөгөөнүүдэд итгэх итгэлийг төлөвшүүлэх нь үргэлж амар хялбар байдаггүй. Бид бүгдэд сорилт бэрхшээлүүд тулгардаг. Тойрог буюу салбарт тань болзохоор тохиромжтой хүн байхгүй байж болох юм. Гэрлэсэн ч хүүхэд төрөхгүй байж мэднэ. Магадгүй гэр бүл салах асуудал танд тулгарч мэднэ. Эсвэл өнгөрсөн үеийн туршлага тань таныг болгоомжлоход хүргэж байж магадгүй. Их Эзэн таны тэмцлийг мэддэг бөгөөд таныг Өөртөө итгэдэг байхыг хүсдэг. Та Тэнгэрлэг Эцэгт итгэж сурвал амар амгалан ба удирдамж танд ирэх болно. ■

ЭШЛЭЛ

1. Эзра Тафт Бенсон, “The Great Commandment—Love the Lord,” *Ensign*, 1988 оны 5-р сар, 4.

БУРХАНД ИТГЭХ ТАНЫ ИТГЭЛ ХҮЧИРХЭГ, БАТ БӨХ БАЙХ ЁСТОЙ



“Энэ амьдрал бол агуу итгэл Есүс Христэд итгэх итгэл, Түүний сургаалуудад итгэх итгэл, энэ амьдралд болон мөнхийн оршихуйд зорилготойгоор, дээдийн дээд аз жаргалд хүрэхийн төлөө эдгээр сургаалуудыг дуулгавартай дагахын тулд Ариун Сүнсээр удирдагдах өөрийн чадварт итгэх итгэлийн сорилт мөн. Итгэх гэдэг нь эхлэлээс төгсгөлийг хүртэл мэдэхгүйгээр хүслээрээ дуулгавартай дагах гэсэн утгатай юм (Сургаалт Үгс 3:5–7-г үзнэ үү). Үр жимс гаргахын тулд, Их Эзэнд итгэх итгэл тань хувийн бодол санаа, туршлагадаа итгэх итгэлээс тань илүү хүчтэй, илүү урт удаан хугацаатай байх ёстой. . . .

“Та нар Түүнд найдвар тавьж, Түүнд итгэх итгэлээ ашиглавал Тэрээр та нарт туслах болно.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Ричард Г. Скотт, “Trust in the Lord,” *Лиакхона*, 1996 оны 1-р сар, 15.

“Энэ нөхцөлд бидний
хийх ёстой зөв зүйл юу вэ?
Бидний хэлэх ёстой зөв
үг юу вэ?”





Арванхоёр
Төлөөлөгчийн Чуулгын
Ахлагч
Жеффери Р.Холланд

ИТГЭЛ ҮНЭМШИЛ БА ӨРӨВЧ СЭТГЭЛ

Хүмүүс болон нөхцөл байдлуудад бид хэрхэн хариулдаг маань бидний шашны сүсэг бишрэлийн болон сайн мэдээний амлалтанд итгэл төгс байдгийн бүхэл цар хүрээний тусгал болох ёстой.

Би нэлээд дээр ганц бие залуучуудын нэг гадасны онцгой цугларалт дээр үг хэлэхээр уригдсан юм. Намайг гадасны төвийн ар талын хаалгаар орох үед 30 гаруй насны нэг эмэгтэй барилга руу орлоо. Цуглааны байр руу олон хүмүүс шахцалдан орж байсан ч тэр эмэгтэйг ажиглахгүй өнгөрөх аргагүй байлаа. Тэр эмэгтэй биен дээрээ хоёр шивээстэй, чихний болон хамрын ээмэгтэй, байж болох бүх өнгө холилдсон ч, ихэнхдээ цагаан эрдэнэ шиш шиг арзгар үстэй, дэндүү богино банзал, хэтэрхий богино цамц өмссөн байв.

Энэ эмэгтэй итгэлийнхээ төлөө тэмцэж яваа өөр сүмийн нэгэн үү, эсвэл Их Эзэний удирдамжаар хэн нэг нь түүнийг илүү сайн замд оруулахын тулд, эсвэл амьдралд нь хэрэгтэй байгаа амар амгаланг болон сайн мэдээний удирдамжийг олж авахад нь түүнд туслахын тулд энэхүү онцгой цугларалтад авчирсан юм болов уу? Эсвэл гишүүддээ байх ёстой итгэл найдвар, жишгүүдийг урамшуулан дэмждэг Сүмээс хэсэг хугацаанд хөндийрсөн ч, бүрмөсөн идэвхгүй болчихоогүй, тэр оройн үйл ажиллагаанд оролцох хүсэлдээ хөтлөгдөн ирсэн гишүүн юм болов уу?

Хүн тэр залуу эмэгтэйд ямар ч байдлаар хандаж болох ч гэсэн харин бид түүнд өөрсдийн итгэл бишрэл хийгээд сайн мэдээнд итгэх үнэнч итгэлдээ нийцүүлэн, боломжтой бүх хэлбэр, боломжтой бүхий л үйлдлээр түүнтэй хэлхээ холбоотой байх нь мөнхийн дүрэм юм. Тиймээс, ямар ч нөхцөлд бидний хариу үйлдэл байдлыг дордуулах биш, харин дээрдүүлдэг байх ёстой. Бид түүнийг одоо байгаагаас нь илүү ихээр гомдоох буруу арга замаар түүнд хандах буюу тийм байдлаар хариу үйлдэл үзүүлж болохгүй. Энэ нь бид өөрийн санаа бодолгүй,

өөрийн жишгүүдгүй байна гэсэн үг биш, бас “юуг хийх ёстой,” “юуг хийхгүй байх ёстойг” бидэнд зарлиг болгосон Бурханы тушаалуудыг хайхрахгүй байна гэсэн үг биш, харин бид өөрсдийн жишгүүдээр амьдарч, “юуг хийх ёстой,” “юуг хийхгүй байх ёстойг” заасан зарлигуудыг болон Аврагчийн амьдарч, хамгаалж байсан арга замыг зөв шударга байдлаар, чадлынхаа дээд хэмжээгээр сахиж, хамгаалах ёстой гэсэн үг юм. Тэрбээр нөхцөл байдлыг дээрдүүлэх юмсыг үнэнийг заахаас эхлэн нүгэлтнүүдийг уучлах, Ариун сүмийг цэвэршүүлэх гээд хийх ёстой зүйлийг л үргэлж хийдэг байсан. Ийм зүйлсийг хэрхэн зөв арга замаар хийхийг мэднэ гэдэг агуу бэлэг!

Иймээс, ер бусаар хувцаслаж, үсээ ер бусаар зассан бидний шинэ танил сайхь эмэгтэйн хувьд тэр бол Бурханы мөнхийн үнэ цэнэтэй охин гэдгийг санахаас эхлэх нь туйлын чухал. Бид түүнийг дэлхий дээрх хэн нэгний охин мөн түүнчлэн өөр нөхцөлд бол миний охин ч байж болно гэдгийг санахаас эхлэх учиртай. Тэр эмэгтэй Сүмийн үйл ажиллагаанаас зайлсхийсэнгүй, харин түүнд хүрч ирсэнд нь талархахаас бид эхлэх хэрэгтэй. Товчоор өгүүлбэл, бид энэ нөхцөлд *өөрсдийнхөө* хийж чадах хамгийн сайн зүйлийг *түүнд* хамгийн сайнаараа байхад нь туслах хүслээр хийхийг хичээх ёстой. Энэ нөхцөлд бидний хийх ёстой зөв зүйл юу вэ? Бидний хэлэх ёстой зөв үг юу вэ? гэдгийг мэдэхийн тулд бид чимээгүй залбирах хэрэгтэй. Чухам юу түүний байдлыг болон түүнийг өөрийг нь илүү сайн болгоход *хамгийн чухал вэ?* Эдгээр асуултуудыг асууж, энэ тохиолдолд Аврагчийн хийх байсан зүйлийг хийхийг хичээх нь, “Гаднах төрхөөр нь бүү шүү. Харин үнэн зөв шүүлтээр


шүү” (Иохан 7:24) гэсэн Түүний үгсэд нийцнэ гэж би боддог.

Би үүнийг хэлснээрээ, ямар нэг байдлаар зарлигуудыг сахихаа больсон хэн нэгнийг сүмд буцаж ирэхэд нь туслахын хамт замаасаа гажаагүй Христийн шавь нарын төлөө бас Хоньчны хүслийн дагуу бид агуу үүрэг хариуцлага хүлээх ёстойг та бүгдэд сануулж байна. Хонины хороо байдаг бөгөөд бид бүгд энэ хороон дотроо байх ёстой бөгөөд энд байгаа үед бидэнд аюулгүй байдал хийгээд адислалууд ирдгийг хэлэх нь илүүц юм. Залуу ах, эгч нар минь, энэ Сүм нийгмийн санаа бодолд тохируулах буюу улс төрийн хувьд хүлээн зөвшөөрч болохуйц бусад аливаа шалтгаанаар бодлогоо дагахад хялбар болгон хэзээ ч өөрчлөхгүй. Энэ бол зовлон зүдгүүрт өртсөн буюу нийгмээр шоовдорлогдсон хүнийг дэмжиж өргөх суурийг бидэнд өгдөг бат найдвартай илчлэгдсэн үнэн юм. Бидний өрөвч нинжин сэтгэл ба хайр бол Христэд итгэгч бидний зан төлвийн үндсэн шинж, бидэнд тавигддаг шаардлага бөгөөд үүнийг зарлигуудад найр тавин бууж өгч байгаа явдал гэж тайлбарлах *ёсгүй*. Алдарт Жорж МакДональд ийм нөхцөл байдалд нэг удаа, “бид бүгдээрээ [итгэдэг] хэмээн хэлэх үүрэггүй, гэхдээ бид [итгэдэггүй] [юм шиг] харагдах ёсгүй” хэмээн хэлжээ.¹

Бид хэзээ шүүх ёстой вэ

Энэ талаар, бид ямар ч зүйлийг шүүх ёсгүй, бид ямар ч тохиололд үнэ цэнэтэй шүүмжлэл хэлэх ёсгүй гэсэн буруу ойлголт ялангуяа залуу хүмүүсийн дунд байдаг. Бид үүгээр бие биедээ туслах хэрэгтэй. Учир нь Аврагч үүнийг тодорхой болгосноор бид зарим тохиолдолд шүүх *ёстой*, “Ариун юмыг нохдод бүү өг. Өөрсдийн сувдыг гахайны өмнө бүү хая” (Матай 7:6) хэмээн Түүний хэлсэнчлэн бид шүүх үүрэгтэй юм. Энэ нь надад шүүж байгаа мэт сонсогдож байна. Үүний хүлээн зөвшөөрч болшгүй хувилбар нь бууж өгдөг, дадал заншил нь өөрчлөгдөн хувирдаг, жишгүүдийг зөрчих нь хэрээс хэтэрсэн дэлхий эдүгээ мөнхийн үнэн, онцгой ариун зүйл гэж юу ч байхгүй, тиймээс, эдгээр асуудлууд бусад ямар ч асуудлуудаас чухал биш хэмээн тунхаглаж байна. Харин Есүс Христийн сайн мэдээнд энэ нь үнэн биш юм.

Бид энэхүү үйл явцыг үнэлэн дүгнэхдээ бусдыг зэмлэх зорилго тавьсангүй, харин бид өөрсдийн шүүлтэн дээр үндэслэн, тэгэхдээ бидний шүүлтүүд зөв гэдэгт итгэн өдөр тутмын шийдвэрүүдийг гаргадаг байхыг бид уриалж байна. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Даллин Х.Өүкс ийм маягийн шийдвэрүүдийг “түр хугацааны шийдвэр” хэмээн нэрлэсэн юм. Бид ийм шийдвэрүүдийг өөрсдийнхөө болон өрөөл бусдын аюулгүй байдлын төлөө олонтоо гаргадаг бөгөөд үүнийг тэрээр зөвхөн бүхнийг мэддэг Бурханы гаргадаг



Бид зарим нөхцөлд шүүх ёстой. Бид өөрсдийнхөө болон өрөөл бусдын аюулгүй байдлын төлөө “түр хугацаагаар шүүгчид” байх ёстой.

“эцсийн шийдвэрийн” эсрэг тал хэмээн нэрлэсэн юм.² (Дээр эш татсан сударт Аврагч эдгээрийг “зөв шүүлт” бөгөөд энэ нь *их* өөр зүйл, энэ бол өөрийгөө зөвтгөх шүүлт биш хэмээн хэлсэн билээ.)

Жишээ нь, бага насны хүүхдээ их хөдөлгөөнтэй гудамж руу гарч гүйхийг хориглодог эцэг эхийг хэн ч буруутгахгүй. Тэгвэл арай ахмад насанд нь хүүхдүүдээ орой хэдэн цагт гэртээ ирэх ёстойг нь эсвэл хэдэн насандаа болзоонд явах ёстойг нь анхаарч, мансууруулах бодис, порнограф болон бэлгийн харилцааны нүглээс хүүхдүүдээ хол байлгахад санаа тавьдаг эцэг эхийг яагаад буруутгадаг юм бол? Үгүй ээ, бид шийдвэр гаргахдаа эрхэмлэдэг зүйлсийнхээ талаар байр сууриа

илэрхийлэн, үүнийгээ нотолдог, товчхон дүгнэж хэлбэл, бүх цаг үед, “түр хугацааны шүүлт” хийдэг, эсвээс адаглаж л бид ийм байх ёстой.

“Тэдэнд өөрсдийнх нь сонгох эрх байхгүй гэж үү?”

Залуу хүмүүс бүх тохиолдолд байдаг байр суурь буюу Сүмийн баримталдаг бодлогын талаар, “Тийм ээ, бид биеэ хэрхэн авч явахыг мэднэ, гэвч бид өөрсдийн жишгүүдийг бусад хүмүүсээр хүлээн зөвшөөрүүлж, тэд эдгээр жишгүүдийг дагах ёстой гэж бид яагаад үзэх ёстой юм бэ? Тэдэнд өөрсдийн сонгох эрх байхгүй гэж үү? Бид өөрсдийн итгэл үнэмшлийг бусдад албадан тулгадаг, тэд ч бас бидний үйлддэгтэй адил арга замаар үйлдэх ёстой гэж шаарддаг, өөрсдийгөө дөвийлгөн, бусдыг өөчилдөг юм биш үү?” хэмээн гайхан асууж болно. Та эдгээр нөхцөлүүдэд зарим зарчмуудыг яагаад хамгаалдаг, заримыг нь яагаад *хаана ч тохиолдсон* эсэргүүцдэгийг тайлбарлах шаардлага гарна, учир нь энд хамаатай асуудлууд болон хуулиуд нь зөвхөн нийгэм, улс төрийн шинжтэй төдийгүй бас үүрд мөнхийн үр дагавруудтай юм. Бид өөрсдөөсөө өөр итгэлтэй хүмүүсийг гомдоохыг хүсдэггүйн сацуу Бурханыг гомдоохгүй байхад бүр илүү анхаардаг билээ.

Энэ нь өсвөр насны хүүхэд дараах үгсийг хэлэхтэй адил юм, “Би машин барьж чадна. Би улаан гэрэл дээр зогсох ёстойгоо мэднэ. Харин бид бусад хүн бүр улаан гэрэл дээр зогсох ёстой гэж шаарддаг бил үү? Эсвэл тэднийг улаан гэрэл дээр зогсоохыг хичээдэг бил үү?” Тэгвэл яагаад гэдгийг та тайлбарлах хэрэгтэй. Тийм ээ, бид *бүх* хүмүүс улаан гэрэл дээр зогсох ёстой гэдэгт найддаг. Харин зөрчил гаргасан, гэм нүгэл үйлдсэн

болон бидний итгэлээс өөрөөр итгэдэг хүмүүсийг та нар шүүмжлэлгүйгээр эсвэл дорд үзэлгүйгээр үүнийг хийх ёстой. Тийм ээ, тэд өөрсдийн ёс суртахууныг сонгох эрхтэй. Гэвч зарим хүмүүс дуулгаваргүй байхаар сонгох аюул хаа сайгүй байх болно гэдэгт хэзээ ч эргэлзэх ёсгүй.

Залуу ах, эгч нар минь ээ, энэ дэлхийд олон өөр итгэл бишрэл бий, бүх хүмүүс ёс суртахууны сонгох эрхтэй ч, Бурхан эдгээр асуудлуудаар бидэнтэй харилцдаггүй гэж үзэх, олон түмний санаа бодолд нийцүүлэх нь зарлигуудаас илүү чухал хэмээн үйлдэх эрх хэнд ч байхгүй.

Бид энэхүү нарийн замаар алхдагаа, Бурханы тунхагласан болон бидэнд өгсөн хуулиудад ёс суртахууны хэм хэмжээгээ нийцүүлдгээ харуулахаас илүү чухал чадвар, илүү агуу зарчимч байдлыг би мэдэхгүй. Гэвч үүнийг өрөвч нинжин сэтгэл, ойлголт хийгээд агуу хайр энэрлээр хийх хэрэгтэй. Гэм нүгэл ба гэм нүгэлтний хоорондох ялгааг төгс ялган салгаж хийхэд хэцүү зүйлийн талаар ярилц! Би хийхэд хэцүү тэр ч бүү хэл заримдаа тайлбарлахад хэцүү зарим зүйлийг мэднэ. Гэвч бид чухам тэр зүйлийг л хайраар хийхийг хичээх ёстой. ■

2012 оны 9-р сарын 12-нд Сүмийн Боловсролын Системийн онцгой цугларалтан дээр хэлсэн үгнээс хялбаршуулан авав. “Израил, Израил, Бурхан дуудаж байна” гэсэн нэртэй үгийн англи хэлээрх бүрэн эхийг cesdevotionals.lds.org-аас үзнэ үү.

ЭШЛЭЛ

1. Жорж МакДональд, *The Unspoken Sermons* (2011), 264.
2. Даллин Х.Өүкс, “Judge Not and Judging,” *Ensign*, 1999 оны 8-р сар, 6–13.

“Би улаан гэрэл дээр зогсох ёстойг мэднэ. Харин бид бусад хүмүүсийг улаан гэрэл дээр зогсох ёстой гэж шаарддаг бил үү? Эсвэл тэднийг улаан гэрэл дээр зогсоохыг хичээдэг гэж үү?”





Давид Диксон
Сүмийн сэтгүүлүүд

ӨӨРИЙГӨӨ УУЧЛАХУЙ

Бид наманчилж,
Их Эзэн биднийг
өршөөсөн гэдгийг
мэдрэх үедээ өөрс-
дийгөө уучлах нь
яагаад заримдаа
ийм их хэцүү
байдаг вэ?

Нэг удаа нэг алхмаар сайжрах нь

Өнөө үед амьдардаг олон хүмүүсийн хувьд цахилгаан гэрэлгүйгээр амьдарна гэдгийг төсөөлөхөд бэрх юм. Унтраалга дээр дармагц харанхуй өрөөнд гэрэл цэлсхийн асдаг. Энгийн ажлуудыг хийхийн тулд үүр цайхыг хүлээх буюу лааны сүүмгэр гэрэлд хийдэг байсан үе тийм ч эрт үед тооцогддоггүй. Зохион бүтээхэд маш хэцүү байсан цахилгаан гэрлийн ачаар эдүгээ тэдгээр ажлуудыг маш амархан хийж байна.

Америкийн зохион бүтээгч Томас Альва Эдисон (1847–1931) удаан хугацаагаар асч, гэрэл өгч чадах чийдэнгийн утсыг (чийдэнгийн шилний маш нарийхан төмөр утас) гаргаж авахын тулд хэдэн жил хөдөлмөрлөж, 1000 гаруй материалыг туршиж үзжээ. Үргэлж өөдрөг үзэлтэй байдаг Эдисон чийдэнгийн утсанд тохирохгүй материал бүрийг туршсанаар тохирох материал олоход нэг алхам дөхдөг байжээ. Тэгээд тохирох материалыг олсноор дэхий тэр чигээрээ өөрчлөгдсөн юм.

Дотоод сэтгэлээ шинжихүй

Тамирчид, сэтгэгчид, зураачид ба алдаанаасаа хэрхэн суралцвал зохихыг мэдсэн бусад хүмүүсийн тухай сүнслэг нөлөө бүхий үй түмэн түүх байдаг. Оролд, оролд, бас дахин оролд, тэгвэл амжилт олно гэсэн түүхийн өрнөлийг сонсох нь хэзээ ч уйтгартай байдаггүй. Харин тэрхүү түүхийн баатар нь бид өөрсдөө байдаг юм.

Биднээс олонх нь хүн зарлигуудыг сахих нь өөрийгөө тасралтгүй төгөлдөржүүлэх шаардлага гэж үздэг. Энэ нь төслийн анхны үзэл баримтлалд шаардлагатай зохицуулалт хийхгүйгээр сая долларын үнэтэй зохион бүтээлт хийхийг

хүсэн хүлээх эсвэл аварга шалгаруулах том тэмцээнд бэлтгэх тоглолтуудад ганц ч хожигдолгүйгээр ялалт байгуулна гэж итгэхтэй адил юм. Бид нүгэл үйлдэж, төгөлдөржилтөд хүрэхгүй байгаа бол энэ нь өөрийгөө уучилдаггүй, хичээл зүтгэл гарган чармайдаггүйтэй олонтоо холбоотой юм.

Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх, Ерөнхийлөгч Диетер Ф.Угдорф ийн сургажээ: “Их Эзэн биднээс бүх хүмүүсийг, түүний дотор өөрсдийгөө уучлахыг шаарддаг. Заримдаа дэлхий дээрх бүх хүмүүсээс уучлах нь хамгийн хэцүү нэгэн нь, бас магадгүй уучлах нь хамгийн хэрэгтэй байгаа тэр хүн нь, өнгөрсөн үеэ эргэж харвал бид өөрсдөө байж болно.”¹

Өөрчлөгдсөн бодгаль

Харин бид хэрхэн үүнийг хийж чадах вэ? Мормоны Номын бошиглогч Аммоны амьдралыг судалбал энэ тухай ойлголт авч болно.

Леменчүүдийн дунд хийсэн Аммоны номлолын туршлага тэдний хувьд сүнслэг урам хайрласан гайхамшиг байлаа. Хааны сүргийг хамгаалахаас эхлээд Хаан Лемонайд номлож, бүхэл үндэстэнд сайн

мэдээг авчрахад тусалсан нь Аммоны амьдрал ба үйлчлэл сүнслэг нөлөө бүхий судрын агуу түүхүүдийн нэг болж үлдсэн юм.

Леменчүүдэд хүч эрх мэдлээр номлосон, итгэлээр дүүрэн Аммон үргэлж зөв шударга байгаагүй. Тэр ноцтой алдаа гаргасан юм. Мозаегийн хөвгүүдийн нэг Аммон нэгэн үе “сүмийг устгахыг, мөн Их Эзэний хүмүүсийг буруу замаар удирдахыг эрэлхийлэн, Бурханы зарлигуудыг эсэргүүцдэг” (Мозая 27:10) хүмүүсийн дунд тоологддог байлаа.

Аммон өөрийн ах нар болон бага Алматай хамтран Бурханы ажлыг тасалдуулахыг хичээж байсан учир Их Эзэний тэнгэр элч тэдэн дээр хүрч ирэн, тэднийг наманчлалд дуудаж, “тэдний дээр нь зогсож байсан газрыг доргиход хүргэсэн аянгын дуу лугаа адил дуу хоолойгоор ярьсан юм” (Мозая 27:11).

Аммон ноцтой гэм нүгэл үйлдсэн бөгөөд үүнийхээ төлөө наманчлах шаардлагатай байсан нь тодорхой юм. Тиймээс тэр наманчилсан билээ. Харин тэр өөрийгөө уучлаагүй бол юу болох байсан бол? Хэрэв тэр номлолд явах нь түүний хувьд оройтсон гээд номлолд яваагүй бол юу болох байсан бол? Хэрэв тэр номлолд яваагүй бол леменчүүдийн дунд олсон амжилтынхаа талаар олон жилийн дараа ах дүүстэйгээ баяр баяслыг эдэлж чадахгүй байх байсан биз ээ. “Эдүгээ болгоогтун, бид урагш харж мөн хөдөлмөрийнхөө үр жимсийг харж чадна; мөн тэдгээр нь цөөхөн гэж үү?” хэмээн Аммон ах нараасаа асуужээ. “Би та нарт хэлнэ, Үгүй, тэдгээр нь олон; тийм ээ, мөн бид тэдний чинхүү сэтгэлийг харж чадна, ах дүүстээ хандсан, мөн түүнчлэн бидэнд хандсан тэдний хайрын учир болой”





УНАЛТААС ЭРГҮҮЛСЭН НЬ

Далын Ахлагч

Шэйн М.Вуэн

Цагаатгал бидний

амьдралыг уналтаас хэрхэн эргүүлж,
ариусгасан тухай заажээ. [lds.org/
pages/mormon-messages#reclaimed](https://lds.org/pages/mormon-messages#reclaimed)-ээс
“Reclaimed” дүрс бичлэгийг үзнэ үү.

(Алма 26:31). Тэдний номлолын хүчин чармайлтын ачаар мянга мянган хүмүүс үнэнд ирсэн юм.

Урам хугарахын аюул

Сүмийн удирдагчдын ийм тодорхой зөвлөгөө, судрын олон жишээ байхад бидний зарим нь аврал тэдний хувьд нэгэнт өнгөрсөн зүйл, Цагаатгал тэдэнд хүртээлгүй гэж боддог. Бид бүр чин сэтгэлээсээ залбираад ч өөрийнхөө гэм буруугийн хүнд ачаа дарамтаас ангижирч чадахгүй. Зарим нь бүр хичээхээ ч больж мэднэ.

Эцсийн эцэст, хэрэв та дахиад унах юм бол яах гэж унасан газраасаа өөрийгөө татаж босгох юм бэ? Наанадаж л, дайсан танд ингэж бодуулах байсан. Ийм бодол санаа нь сүнслэг байдал, сэтгэл санааны хувьд хор уршигтай төдийгүй угаасаа буруу юм.

Аврагчийн Цагаатгал хязгааргүй бөгөөд бүх хүмүүст


боломжтойг судрууд бидэнд заадаг. “Нааш ир, Хамт хэлэлцье” гэж ЭЗЭН айлдаж байна. “Та нарын нүглүүд час улаан мэт боловч цас шиг

цагаан болно. Тэдгээр нь хүрэн улаан боловч ноос шиг болох болно” (Исаиа 1:18). Бид амжилт олж чадна. Бид дахин хичээж чадна. Түүнчлэн бид замын дагуу алхам бүртээ Их Эзэнээс тусламж авч чадна.

Хэзээ ч оройддоггүй

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Жеффри Р.Холланд бидэнд өөрийгөө голж чамлахгүй байх талаар тодорхой зөвлөгөө өгсөн юм. “Хэчнээн ч олон боломжийг би алдаа вэ? Хэчнээн ч олон алдаа гаргаа вэ? Авьяас чадвар ч гэж надад алга хэмээн та бодлоо ч гэсэн, гэр орон, гэр бүл, Бурханаас хэчнээн ч хол явлаа гэсэн та бурханлаг хайраас холуур тойрон гарч чадахгүйг би гэрчилж байна. Цацран гэрэлтэх Христийн Цагаатгалын хязгааргүй гэрлээс гадна, доод талд нь үлдэх гэдэг таны хувьд боломжгүй зүйл.”²

Ахлагч Холланд Бурханы нинжин сэтгэлд төгс итгэлтэй байхыг бидэнд ийн заасан юм: “Итгэлийн томьёо нь хүлээцтэй байж, хүч чармайлтаа үргэлжлүүлэн, өнгөрсөн үед тохиолдсон зовлон зүдгүүрүүд бодитой байсан уу эсвэл санаанаасаа зохиосон зүйл байсан уу гэдгийг анхааралтай бодож үзвэл тэдгээр нь эцсийн өгөөмөр шагналдаа уусан замрах болно.”³



ХАР ТЭМДГИЙГ Ч АРИЛГАЖ БОЛНО

Дани Дунавей Рован

Бидний алдаа дутагдлын ул мөр арилшгүй биш юм. Цэвэр ариун гартай байх нь амаргүй ч гэсэн ингэх хэрэгтэй.

Найдвараар жигүүрлэн

Гэм нүгэлд хайхрамжгүй хандахгүй байхад наманчлал чухал юм. Өршөөл бодитой зүйл. Аврагчийн Цагаатгал амьдралаа гэм нүгэлгүйгээр дахин эхлэх боломжийг бидэнд олгодог билээ. Аммон өршөөлийг олсон шиг бид ч бас уучлалыг олж чадна.

Бид гэрэлт ирээдүйдээ итгэлтэй байж болно. “Ариун Сүнсний хүчээр та нар найдвараар бялхсан байхын тулд найдварын Бурхан та нарыг итгэл дотор бүх баяр баясгалан болон амар тайвнаар дүүргэх болтугай” (Ром 15:13) хэмээн Төлөөлөгч Паул заасан билээ.

Бид бүгд наманчлалын бэлгийн ачаар өөртөө дахин итгэлтэй болж чадна. ■

Эшлэл

1. Диетер Ф. Угдорф, “Өршөөнгүй хүмүүс өршөөл энэрлийг хүлээн авна,” *Лиакхона*, 2012 оны 5-р сар, 75.
2. Жеффри Р. Холланд, “Талбайд хөдөлмөрлөгсөд,” *Лиакхона*, 2012 оны 5-р сар, 33.
3. Жеффри Р. Холланд, “Талбайд хөдөлмөрлөгсөд,” 32.

Би ахлах сургууль төгссөнөөсөө хойш долоо хоногийн дараа намар нь коллежид орохоосоо өмнө улсынхаа нөгөө талд амьдардаг эгчийндээ очиж зуныг тэндээ өнгөрүүлэхээр явж билээ.

Би хэдэн найзтай болсноос ихэнх нь коллежид сурдаг байлаа. Бас арай ахмад найз нар ч байсан. Нэг хагас сайн өдрийн орой миний шинэ найз нараас хоёр нь орон нутгийн нэг клубт тоглодог хөгжмийн сайн хамтлагийн тоглолтыг үзнэ үү гээд намайг авахаар ирлээ.

Биднийг машинаа зогсоолд тавих үед миний санаа бага зэрэг зовсон ч тэр үдэш надад тийм эвгүй зүйл тохиолдоно гэж бодсонгүй. Биднийг клубт ороход лангууны ард зогсож байсан хүн миний жолооны үнэмлэхийг шалгаад юу ч хэлэлгүйгээр, арилдаггүй бэхтэй хар үзгээр миний хоёр гарын хуруунуудын үен дээр тэмдэг тавьчихав.

Би гайхсандаа доошоо харлаа. Тэр хүн намайг баарнаас архи худалдаж авах насанд хүрээгүйг нотлохын тулд ийнхүү тэмдэг тавьсан ажээ.

Тэр даруй миний дотор эвгүй оргиод явчихав. Хүмүүс архи ууж, тамхи татаж байлаа.

Тэр дороо гараад явчих зориг дутсандаа би харамссанаа хэлэх ёстой. 30 орчим минутын дараа найз нарын маань нэг надаас бие зүгээр үү гэж асуув. Чанга хөгжим, тамхины утаанаас болж толгой өвдөөд байна гэж би түүнд хэллээ. Тэр намайг гэрт хүргэж өгье гэхэд би дуртай зөвшөөрлөө.

Би эгчийндээ ирээд угаалгын өрөө рүү харайлган орж, арилдаггүй хар үзгээр тавьсан тэмдгүүдийг

арилгах гэж гарынхаа арьсыг шалбарч, өвдтөл нь үрлээ. Маргааш нь ийм гартай ариун ёслол түгээх гэж үү гэж бодоод гараа цэвэрлэхийг цөхрөлтгүй оролдсон ч, миний зөөлхөн, ягаан арьсан дээр хоёр хар зураас үлдлээ.

Унтахаасаа өмнө би залбирч, клубээс тэр даруй гарч явах зориг дутсаныхаа төлөө, тийм газарт огт орохгүй байх зориг дутсаныхаа төлөө уучлал гуйлаа. Би өөрийгөө иймэрхүү эвгүй байдалд дахиад хэзээ ч оруулахгүй гэж Тэнгэрлэг Эцэгт амласан.

Маргааш өглөө нь би хар тэмдгийн үлдсэн ихэнх хэсгийг арилгаж чадсан бөгөөд ариун ёслол түгээх үед миний гар бараг бүрэн цэвэрхэн болсон байлаа. Нүгэл хар тэмдэгтэй хэрхэн адилхан болохыг би тэр үед ойлгосон. Нүглийг арилгах нь хүч чармайлт шаардах бөгөөд сэтгэл эмзэглэм хэцүү байж болох ч хэрэв бид наманчилбал Цагаатгалаар дамжуулан амьдрал дахь хар тэмдгүүдээс цэвэршиж чадна. ■

Энэхүү өгүүллийн зохиогч АНУ-ын Ютад амьдардаг.





ҮНЭНЧ ШУДАРГА БАЙДАЛ

*Христийн шавь хүний
хувьд зан төлвийн эдгээр
чанарууд таныг чухам хэн
бэ? гэдгийг илэрхийлдэг.*

Далын
Ахлагч Бага
Кристоффел
Голден



Америк хөл бөмбөгийн коллежийн аварга шалгаруулах тэмцээний үеэр Жозеф Б.Вертлин шийдвэрлэх тоглолтын үед “баримтлах дүрмийг” тогтоосон ажээ.

“Өрсөлдөгч багаасаа илүү оноо авахын тулд би өөртөө ирсэн бөмбөгийг талбайн голд хүргэхээр өрсөлдөгч багийн тоглогчдын шугамыг чиглэн хар хурдаараа гүйх шаардлагатай болов. Гоолын шугам ойрхон байгааг мэдсэн ч, чухам хэр зэрэг ойрхон байгааг би мэдэхгүй байв. Гоолын шугам 5 см хол байлаа.

“Би тэр мөчид бөмбөгийг шидэхээр уруу татагдав. Үнэхээр тэгж болох байв. . . . Гэвч ‘Жозеф, үр дагавар нь ямар байх нь хамаагүй,

зөв зүйлийг л хийж бай. Зөв зүйлийг хийвэл бүх юмс сайн болно’ гэж ээжийнхээ байнга хэлдэг үгийг саналаа.

“Би өрсөлдөгч багаасаа илүү оноо авахыг туйлын их хүсч байлаа. Гэвч би найз нарынхаа нүдэнд баатар болохоос илүүтээр ээжийнхээ нүдэнд баатар болохыг хүссэн. Тиймээс би гоолын шугамаас хоёр см зайнд бөмбөгийг орхисон юм” хэмээн тэр ярьжээ.¹ Ахлагч Вертлин хожим нь (1917–2008) Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүнээр үйлчилж байв.

Зөв зүйлийг хийх нь

Ахлагч Вертлиний шийдвэр нь ямар ч нөхцөлд зарчимч байдлаасаа

ухардаггүй хүний онцгой сайхан жишээ юм. Үнэнч шударга байдал нь бидний зан төлвийн шалгуур болдог бөгөөд ямар ч нөхцөлд эсвээс бусад хүмүүс юу гэж бодох бол гэдгийг үл харгалзан үргэлж зөв зүйл хийх буюу хэлэхийг хүнээс шаарддаг.

Залуучуудын бат бөх байдлын төлөө товхимол дахь жишгүүдийн нэг нь үнэнч шударга байдал юм. Хожмын Үеийн Гэгээнтэн, Христийн дагалдагчид та нараас “өөртөө, бусдад болон Бурханд бүх цаг үед чин шударга хандахыг хүсэн хүлээдэг билээ. Шударга байна гэдэг нь ямар нэгэн байдлаар худлаа хэлэх, хулгай хийх, хууран мэхлэхгүй байна гэсэн үг юм. . . .

Зарчимч байдал нь шударга зан чанартай нягт холбоотой юм. Зарчимч байна гэдэг нь үр дагавар нь ямар байхаас үл хамааран үргэлж зөв зүйлийг бодож, зөв зүйлийг хийх ёстой гэсэн үг юм. Та зарчимч байснаар хэн ч хараагүй үед өөрийн итгэл болон жишгүүдийн дагуу амьдрах хүсэлтэй байх болно.”²

Шавь болох нь

Энэхүү мөнх бус сорилтын амьдрал дахь бидний зорилго бол “Христийн цагаатгалаар дамжин гэгээнтэн” (Мозая 3:19) болох явдал мөн. Гэгээнтэн болох нь Христийн жинхэнэ шавь болохоос өөр зүйл биш. Энэ бол таны бодож байгаагаас илүү хэцүү зүйл биш. Магадгүй та хэрхэн жинхэнэ гэгээнтэн болохыг аль хэдийнээ мэдсэн ч байж болно. Гэвч, үүнд хүч чармайлт шаардлагатай, заримдаа энэ нь биднээс маш шаргуу ажиллахыг шаарддаг. Гэвч ийнхүү шаргуу ажиллах боломжтой юм.

Мормоны Номонд, “Учир нь болгоогтун, Христийн Сүнс хүн бүрт тэрээр сайныг хилэнц-тээс ялган мэдэж болохын

тулд өгөгдсөн байдаг, иймийн тул, би та нарт дүгнэх аргыг үзүүлбэ; учир нь Христэд итгүүлэхээр ятгахыг, мөн сайныг хийхийг урьдаг юм болгон нь, Христийн хүч болон бэлгээр илгээгдсэн байдаг; иймийн тул та нар энэ нь Бурханаас гэдгийг төгс мэдлэгээр мэдэж болно” (Моронай 7:16) хэмээн заасан байдаг.

Та Христийн шавийн хувьд энэ тохиолдолд “Есүс юу хийх байсан бол?” гэсэн асуултыг өөрөөсөө асууснаар хэрхэн ярих, хэрхэн үйлдэхээ мэдэж болно. Ийм асуултын дараа төрсөн мэдрэмжийн дагуу үйлдсэнээр таны үйлдэл зөв гэсэн гэрчлэлийг хүлээн авах болно. Гэвч зарим үед та шударга үйлдлийнхээ үр дагавар буюу адислалуудыг харахын тулд нэлээд удаан хүлээх хэрэгтэй болж мэднэ.

Төгс шударга байх нь

Залуучуудын бат бөх байдлын төлөө товхимол: “Шударга бус байдал нь та нарын болон бусдын сэтгэл санааг сэвтээдэг. Та худлаа ярьж, хулгай хийж, хууран мэхлэх аваас өөрсдийнхөө сүнсийг мөн бусадтай харилцах харьцаагаа гэмтээдэг. Шударга байх нь та нарт шинэ боломжуудыг нээж, Ариун Сүнсээр удирдагдах чадварыг тань өсгөх болно.”³

Өдөр тутмын залбирал, судар судлах болон амьд бошиглогчдын сургаалуудыг амьдралд хэрэгжүүлэх нь шударга зан төлөв ба зарчимч байдлыг бидэнд төлөвшүүлдэг.

Тууштай зарчимч байдал ба төгс шударга зан төлвийн жинхэнэ шалгуур нь таны юу хийж, юу хэлж байгааг хэн ч хараагүй үе дэх таны үйлдэл, үг хэл, бодол санаа юм. Бид Их Эзэн Есүс Христийн үнэнч шавь нарын хувьд Аврагчийн зааснаас доогуур байж болохгүй. Юутай ч зүйрлүүлшгүй үнэ цэнэтэй Ариун Сүнсний бэлэг бидэнд байдаг билээ. “Туслагч буюу Миний нэрээр Эцэгийн минь илгээх Ариун Сүнс та нарт бүх зүйлийг заах бөгөөд Миний та нарт хэлсэн бүгдийг сануулах болно” (Иохан 14:26) хэмээн Аврагч заасан юм.

Бидний Аврагч өдөр тутмын залбирал, судар судлах болон амьд бошиглогчид, төлөөлөгчдийн хэлсэн үгийг уншихаас ирдэг агуу хүч чадлыг бас бидэнд өгсөн юм. Өдөр тутмын эдгээр чухал хэвшил нь бидэнд үнэнч шударга байдлыг төлөвшүүлдэг. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүн, Христийн шавь таны шударга зан төлөв бол таны зарчимч байдлын хийгээд таны үнэхээр хэн бэ гэдгийн илэрхийлэл мөн. ■

Эшлэл

1. Жозеф Б.Вертлин, “Амьдралаас авсан сургаамжууд,” *Лиакхона*, 2007 оны 5-р сар, 46.
2. *Залуучуудын бат бөх байдлын төлөө* (товхимол, 2011), 19.
3. *Залуучуудын бат бөх байдлын төлөө*, 19.





ШУДАРГААР БУЦААЖ ӨГСӨН НЬ

Би бүр санамсаргүйгээр ч гэсэн хулгай
хийхийг тэвчдэггүй байсан.

Валери Бест

Үдээс хойш оройхон дуусдаг хичээлийн дараа би гэртээ харих замдаа, улам ширүүсэн орж байгаа бороо зогсохыг хүлээн, эртний эд зүйлсийн жижиг дэлгүүрт зогсож байлаа. Дэлгүүрт байсан цорын ганц хүн нь би байсан бөгөөд худалдагч эмэгтэй миний авах гэсэн чийдэнгийн шилийг миний нүдэн дээр барин харуулж байв.

Түүнийг дэлгүүрт барьдаг цүнхээ онгойлгоход, лангуун дээр гялалзсан өнгөтэй бугуйвчуудыг дэлгэн тавьсныг би ажиглалаа. Тэр эмэгтэйд чийдэнг цүнхэндээ хийх зуур би нэг бугуйвчинд гараа хүргэв. Эмэгтэй үзмэрүүдээ сойзоор арчих үед бугуйвчнуудын бараг хагас нь шалан дээр шажигнан уналаа. Тэр үл мэдэг цухалдангуй харснаа нэг хүнтэй утсаар ярьж, надтай наймаагаа дуусгахад би нэг гартаа шүхрээ, нөгөө гартаа чийдэнгийн шилээ хийсэн цүнхээ барьсаар дэлгүүрээс гарав.

Гэртээ ирээд гутлаа тайлж, хөгжим жаахан тоглолоо. Чийдэнгийн шилээ гаргаж иртэл цүнхний ёроолд нэг юм харагдав. Нэг улаан хүрэн өнгөтэй бугуйвч байх нь тэр. Энэ бугуйвч үзмэрүүд унахад миний цүнхэнд унасан байх нь. Би энэ хоромд инээмсэглэн: *“Тэгээд Валери Лаурел ангид саяхан үзсэн хичээлийнхээ тухай бодов”* хэмээн Залуу эмэгтэйчүүдийн хуучин гарын авлага дахь нэгэн түүхэнд гардагтай би адилхан байна даа гэж бодов.

Би бугуйвчийг орон дээрээ чулуудчихаад, чийдэнгийн шилээ

цахилгаанд залгав. Чийдэн асч бүүдгэр саарал өдрийг гэгээтэй болгов. Би цонхоор гадагш харлаа. Бороо улам ширүүсч, газар дээрх цас хайлан, лаг шавар бий болгож байлаа.

Бугуйвчийг харлаа. Элгэн хүрэн өнгөтэй юм. Би бугуйндаа хийж үзлээ. Үнийн шошгон дээр нь 20\$ гэсэн байв. Мэдээж хэрэг, би бугуйвчийг буцааж өгнө. Буцааж өгөхгүй юм шүү гэсэн бодол надад огт байгаагүй. Бугуйвчийг тайлж аваад өрөөстэй бөөн номнуудын дээр тавилаа. Номнуудыг би өөр газарт тавих бодолтой байсан юм. Би аяга халуун шоколад хийхээр өөр өрөөнд орлоо.

Тэгээд буцаж ирэв.

Би эдгээр номнуудыг цэгцлэх гэсээр хэчнээн ч хугацаа өнгөрөв дөө? Тэгсэн уджээ. Энэ бугуйвчийг буцааж өгөх хүртэл эндээ хэчнээн удаан байх бол?

Би бугуйвчийг буцааж өгөх бодолтой байсан. Гэвч хэзээ үүнийг буцааж өгөх вэ? Бугуйвчийг буцааж өгөхийг хойшлуулах тусам үүнийг эргүүлж өгөх нь эвгүй байх биш үү? Энэ тухай мартаж болно гэж үү?

Би түр зуур эргэлзэв. Дахиад цонхоор гадагшаа харлаа. Хөл яасан сайхан дулаацаа вэ гэж бодсоноо бас амттай халуун шоколадныхаа тухай бодов.

Тэгээд бугуйвчийг аваад, гутлаа өмсөж, гадагшаа гарлаа.

Намайг дэлгүүр дээр хүрч ирэхэд худалдагч эмэгтэй нэг хүнд юм худалдаж авахад нь тусалж байв.



Би зогсоод хүлээлээ. Түүнийг дуусахад би хүрэмнийхээ халааснаас бугуйвчийг гаргаж ирээд бугуйвч хэрхэн миний цүнхэнд орчихсоныг тайлбарлав. Тэр нэлээд гайхсан янзтай хараад, түр зуур тээнэгэлзсэ- нээ баярлалаа гэв. Ингээд бүх зүйл дуусах нь тэр. Тэр эмэгтэй намайг шударга байсны төлөө шагнасангүй. Баярлалаа гэж хэлэхдээ ч сэтгэл нь

хөдөлсөнгүй. Үүнийг нь харсан өөр хүн ч байсангүй.

Би гэр рүүгээ явж байхдаа өөрий- гөө шударга хүн гэж үргэлж боддог байсан тухайгаа бодлоо. Энэ бол бусад хүмүүст байгаасай гэж миний боддог, эрхэмлэн үнэлдэг зан чанар юм. Гэвч жинхэнэ хайр энэрэл лүгээ адил жинхэнэ ёсоор шударга байна гэдэг нь гагцхүү үйлдлээр харагддаг

зан чанар юм. Хэдийгээр миний бодол санаа зөв шударга ч гэсэн би борооны гутлаа тайлж, бодлоо үйлдлээр хэрэгжүүлсэн тэр үед л зөвхөн шударга хүн болсон юм.

Би хүрэмнийхээ доторх нүцгэн бугуйгаа мэдрээд инээмсэглэн явав. ■

Энэхүү өгүүллийн зохиогч АНУ-ын Нью-Йоркт амьдардаг.

ГЭРЭЭНҮҮД ДЭХ ХҮЧ



Гэрээ гэдэг үгийг сонсоход санаанд чинь юу орж ирдэг вэ? Хэрэв та, гэрээ бол “Бурхантай хийсэн хоёр талын амлалт мөн” гэж ойлговол зөв болно.

Гэвч Тэнгэрлэг Эцэгтэй бидний хийсэн гэрээ бол мөн л маш чухал зүйл. Энэхүү ариун гэрээнд хүч чадал, аюулгүй байдал, амар амгалан оршдог билээ. Та амьдралдаа хийсэн болон хийх гэрээнүүдээ эргэцүүлэн бодох цаг гаргаж, өөрийн хүлээсэн үүргийг биелүүлбэл, өөрөөр бодож сэтгэж, өөрөөр амьдрах болно. Гэрээнүүд нь таны үйл ажиллагаанд болон сонголтууд хийхэд тань сүнслэгээр нөлөөлөх болно.

Гэрээнүүд өсвөр үеийнхний амьдралд хэрхэн өөрчлөлт гаргасныг хэдэн жишээн дээр авч үзье.



“Гэрээ таныг нарийн бөгөөд давчуу зам дээр байлгаж, амьдралаа сайжруулан, сайн мэдээг гүнзгий ойлгоход тань туслах болно.”

Маркус А., нас 17, Юта, АНУ

“Тэнгэрлэг Эцэгтэй байгуулсан миний гэрээнүүд сүнслэг байдлын хувьд өсч хөгжих, бат бөх итгэлтэй гишүүн байх боломжийг надад олгосон юм. Би ямар нэг зүйл хийх болгондоо Тэнгэрлэг Эцэгтэй байгуулсан гэрээнүүдээ санаж, баптисм хүртэх болон санваар авах үедээ Түүнд өгсөн амлалтуудаа биелүүлж байгаа бил үү гэдгийг өөрөөсөө асуудаг. Тэнгэрлэг Эцэгтэйгээ хийсэн миний гэрээнүүд сайн мэдээнд бат бөх итгэлтэй

байх болон нэгэн цагт Түүнд эргэж очиход надад туслах болно.”

Эфран В., нас 14, Шинэ Зеланд



“Би баптисм хүртэхдээ өмнө нь хэзээ ч мэдэрч байгаагүй тийм их аз жаргалыг мэдэрсэн. Учир нь энэ бол миний анхны гэрээ байлаа. Дараа нь мөн ийм их аз жаргалтай мэдрэмж санваар авахад надад төрсөн. Би Бурхантай гэрээ байгуулснаа ойлгоод нүүр дүүрэн инээмсэглэж билээ. Хүүхдүүд манай Сүмийн тухай шоолон ярихыг сонссон үед би тэрхүү аз жаргалтай мэдрэмжийг болон хүмүүстэй биш, харин Бурхантай гэрээ хийснээ санадаг.”

Брадфорд А., нас 16, Аризона, АНУ

“Гэрээнүүд хийх нь бидэнд болон гэр бүлд маань үй олон адислалыг авчирдаг. Жишээ нь, баптисм хүртэх нь бидэнд өөрчлөгдөх, илүү сайн хүн болох чадварыг авчирдаг. Тэнгэрлэг Эцэгтэй хийсэн бидний гэрээнүүд сайн мэдээнд итгэлтэй хэвээр үлдэхэд бидэнд хэрэгтэй итгэлийг төлөвшүүлдэг билээ.”

Наоми А., нас 15, Гвадалахара, Мексик



“Би өнгөрсөн зун нас барагсдын өмнөөс баптисм хийлгэхээр Ариун сүмд олон удаа орсон. Ариун сүмд орж, зөв зүйлийг хийх замаар гэрээнүүдээ

сахиснаар би адислагдсан. Би сургууль төгсөх шалгалтуудаа үнэхээр санаа зовж байлаа. Ариун сүмд орсон нь юм бүхэнд сайнаар нөлөөлсөн. Гэрээнүүдээ сахисан нь миний амьдралыг хөнгөн, илүү аз жаргалтай болгодог билээ.”

МкКенна М., нас 18, Калифорни, АНУ

“Би дикон болоод ариун ёслол түгээсэн анхны өдрөө сэтгэл их догдолж, сандарч билээ. Тэгээд баптисм хийлгэсэн өдрөө эргэн санатал Ариун Сүнснийг мэдэрсэн. Би



НЯМ ГАРАГИЙН ХИЧЭЭЛҮҮД

Энэ сарын сэдэв:
**Ёслолууд ба
гэрээнүүд**

**Гэрээ бол амлалт
бөгөөд бүхэлд нь авч
үзвэл түүнээс ч илүү
чухал зүйл юм.**

ХАМТРАН ЯРИЛЦАЦГААЯ

Та нар санваартны чуулгууд, Залуу эмэгтэйчүүдийн болон Ням гарагийн ангийн хичээлээр долдугаар сарын туршид ёслолууд болон гэрээнүүдийн тухай судлах болно. Өөрийн хийсэн болон хойшид хийнэ гэдэгт итгэлтэй байгаа гэрээнүүдийн жагсаалтыг хий. Хэрхэн амьдрах талаар өөрийн чинь хүсдэг зүйлийн талаар энэ жагсаалт юу өгүүлж байна вэ? Бодол санаагаа гэртээ, сүм дээр болон мэдээллийн хэрэгслээр дамжуулан гэрчлэх замаар бусдад хуваалцахыг бод.



БУРХАНЛАГ ГЭРЭЭНҮҮД ХРИСТЭД ИТГЭГЧДИЙГ ХҮЧИРХЭГ- ЖҮҮЛДЭГ

“Хүлээн авах боломжтой санваарын бүх ёслолуудад тэнцэхээр зохистой байж, эдгээр ёслолуудыг хүлээж аван, гэрээгээр хүлээсэн амлалтуудаа итгэлтэйгээр сахихыг би та бүхнээс хичээнгүйлэн хүсч байна. Зовлон зүдгүүр тохиолдсон үед гэрээнүүд чинь чиний аминд орох болно. Бүр илүү дуулгавартай бай. Тэгээд өөртөө хэрэгтэй байгаа зүйлийг өчүүхэн ч эргэлзэлгүйгээр, итгэлээр асуувал Бурхан хариулах болно. Тэрээр чамд тусална.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Д.Тодд Кристофферсон, “Гэрээнүүдийн хүч,” *Лиакхона*, 2009 оны 5-р сар, 22.



тэр даруй тайвширч, ариун ёслолоо амжилттай түгээсэн.”

**Сет А., нас 12,
Мехико хот, Мексик**



“Би гэрээнүүдээ сахисны ачаар олон адислал хүлээн авсан. Баптисмын гэрээнүүдийн улмаас Ариун Сүнс надад зөв шийдвэр гаргахад тусалдаг. Чамайг санваар авсан үед гэрээ чинь бусдад тусалж, тэдэнд үйлчлэх үүргийг чамд ноогдуулдаг. Үйлчлэл хийснээр итгэл чинь улам өсч хөгжих болно.”

Эрик Н., нас 15, Альберта, Канад

“Хэрэв чи хүссэн бүхнээ хийх юм бол, Бурхан Өөрийн амлалтыг биелүүлнэ гэж хүлээх хэрэггүй. Тэрээр чиний чадварыг мэддэг учраас чамаас илүү их зүйлийг хүсэн хүлээдэг. Энэ нь намайг үнэхээр өндөр түвшинд байлгадаг билээ.”

Холий Х., нас 15, Колорадо, АНУ

ХАМГИЙН САЙХАН

ГЭР БҮЛИЙН ҮДШҮҮД

М

АНХААР



СҮНСЛЭГ АВАРГА БААТРУУД

Энэ жил гайхалтай аварга баатрууд даваа гарагийн орой бүр танай гэрт зочлон очих болно! Аварга баатар болгон нь ер бусын хүчтэй, гэр бүлийн нэг гишүүнтэй адилхан байх бөгөөд гэр бүлийн гишүүд бидний бие биетэйгээ харилцах харилцааг сайжруулахад биднийг урамшуулан дэмжсэн чухал гэрчлэл буюу хүчирхэгжүүлэгч хичээлийг заах болно.

Жишээ нь, Мэдээллийн хэрэгслийн мэргэжилтэн (МХМ) нэг долоо хоног бидэнд зохисгүй кино, телевизийн үзүүлбэр, сэтгүүлүүдээс бид нүдээ хэрхэн хамгаалах талаар бидэнд заасан. Өөр нэг долоо хоногт Чийрэгжилт Хатагтай, бид биеийн тамирын дасгал тогтмол хийснээр онцгой хүч чадлыг хэрхэн хөгжүүлэхийг тайлбарлалаа. Даруухан *зөгий* лүгээ адил хувцасласан Чимээгүй Бай гэдэг нэртэй аварга баатар, бидэнд сүм дээр болон гэр орондоо хэрхэн тоглож, чимээ шуугиан гаргахгүй, хүндэтгэлтэй байхыг бидэнд заасан. Үг Охин бид бие биедээ хэрхэн ахиухан магтаалын үгс хэлж байхыг тайлбарлав. Талархагч Охин, Өөрсдөө Хийцгээ баатар, Судрын Эрдэмтэн, Эелдэг Үгт Залуу Хатагтай, Номлогч Хүн болон бусад аварга баатрууд манай гэр бүлийн үдшийн хичээлүүдэд оролцох болно.

Манай гэр бүлийн гишүүд аварга баатар болж гэр бүлдээ ямар асуудал байгаа талаар гүнзгий бөгөөд анхааралтайгаар тунгаан бодсонд би талархалтай байна. Бид бүгдээрээ гэр бүлийн үдшээ тэсч ядан хүлээдэг болсон. Аварга баатар

болгоныг айлчлан ирэхэд бид цагийг гайхалтай сайхан өнгөрүүлдэг. Бид гэр бүлийн үдэш бүрээр гэр бүл дэх асуудлыг олон талаас нь эргэцүүлэн боддог болсонд, бие биедээ илүү үр өгөөжтэйгөөр заахад Тэнгэрлэг Эцэг бидэнд сүнслэгээр нөлөөлдөг болсонд би баяртай байдаг. Аварга баатруудын тухай дурсамж бидний зүрх сэтгэлд үүрд орших болно. ■ Виктор В., АНУ

АХЫН МИНЬ ГЭРЧЛЭЛ

Эж минь өдөр бүр 3 цагаас 11 цаг хүртэл ажил хийдэг. Тэр хэдий даваа гарагийн орой гэртээ байж чаддаггүй ч ах бид хоёр хоёулаа л гэр бүлийн үдшээ хийж байхаар шийдлээ. Ах минь найман жилийн турш сүмд идэвхгүй байсан ч институтд явж нэгэн даваа гарагийн орой нэг мессеж хуваалцахаар шийдэв. Тэр Мормоны Номын түүхээс сүнслэг бодлоо хуваалцсан нь миний урьд өмнө огт бодож байгаагүй зүйл байлаа. Би дөрвөн жил семинарт явж Хувийн хөгжил дэвшлийн хөтөлбөр дээр ажилласан байсан. Миний мэдэрсэн сүнс бол би гэртээ зохистой санваарын аттагчтай байх цаг ирнэ гэдэгт итгэн найдаж байсан юм шиг санагдлаа.

Тэнгэрлэг Эцэг надад гэр бүлийн үдшээр дамжуулан долоо хоног бүр гэр бүлийг минь хүчирхэгжүүлэх боломж өгсөнд нь би талархалтай байна. Би Есүс Христийн сайн мэдээнд хайртай бөгөөд ахтайгаа хамт энэ даруухан гэр бүлийн үдшийг хийсэндээ баяртай байна. ■ Исадора А., Бразил

ХАРАНХҮЙД ГЭГЭЭРСЭН НЬ

Цахилгаан эрчим хүч тасарсан Цүеэр болсон тэр нэгэн гэр бүлийн үдшээ би хэзээ ч мартахгүй. Бид харанхуйд юу ч уншиж чадсангүй. Тиймээс бид гэр бүлийн үдшээ хийх нь ч өнгөрөв бололтой гэж би бодсон.

“Харанхуйд *Лиакхона* сэтгүүлээс захиас уншиж чадахгүй эсвэл дуулын номноос дуу дуулж чадахгүй болохоор бид яаж гэр бүлийн үдэш хийх юм бэ?” гэж би дотроо бодож билээ.

Аз болоход эгч маань биднийг аварлаа. Бид цээжээр мэддэг дуулуудаа дуулж, өмнөх ням гарагт сурсан зүйлсээсээ хуваалцах тун дажгүй санааг эгч гаргасан юм. Бид бүгдээрээ нэг нэг зарчмыг хуваалцаж, бие биенээсээ суралцсан. Миний бодлоор, хамтран суралцах нь гэр бүлийн үдшийн зорилго юм. Гэрэлгүй байсан ч гэсэн бид гэр бүлийн үдэш хийж байх зарлигийг биелүүлсэнд Их Эзэн баяртай байсан гэдгийг би баттай мэдэж байлаа.

Их Эзэн биднийг Өөрийнхөө оршихуйд ганцаархнаа эргэж очихыг хүсдэггүйг би мэднэ. Тэрээр биднийг гэр бүлтэйгээ хамт буцаж очоосой хэмээн хүсдэг бөгөөд үүний төлөө боломжтой бүхнийг, түүний дотор гэр бүлийн үдшийг долоо хоног бүр хийдэг байхыг биднээс хүсэн хүлээдэг билээ. ■

Хайрика С., Бразил

Гэр бүлийн үдэш нь сүнслэг байдлыг хэрхэн өргөн дэмжсэн, хөгжилтэй үйл явдал байдгийг эдгээр





АРИУН СҮМИЙН ДЭРГЭД ӨНГӨРҮҮЛСЭН ХЭДЭН ЗУН

Манай гэр бүл зун бүр амралтаараа Ариун сүм рүү явдаг байснаас бидэнд агуу адислалууд ирсэн юм.

Давид Исаксен

Би Норвегид өссөн. Хамгийн ойрын Ариун сүм бол Шведийн Стокольмын Ариун сүм бөгөөд тийшээгээ машинаар 8-10 цаг явж хүрнэ. Ариун сүм явах аливаа аялалд нямбай төлөвлөлт, бэлтгэл хэрэгтэй байдгийг хэлэх хэрэггүй биз ээ. Манай гадас жил бүр өсвөр үеийнхэнд зориулсан Ариун сүмийн аяллыг хоёр удаа төлөвлөдөг. Хэд хэдэн тойрог нийлэн, нэг автобус түрээсэлж, долоо хоногийн амралтын өдрүүдээрээ Ариун сүм явдаг. Бусад өсвөр насныхантай хамт явах нь хөгжилтэй байдаг ч, би нэгэн цагт гэрийнхэнтэйгээ хамт Ариун сүм рүү явахыг хүсдэг байлаа.

Тиймээс бид нэг жил зуны амралтынхаа үеэр Шведийн Стокольмын Ариун сүм явахаар шийдэв. Энэ аялал бидэнд маш сайхан санагдсан учраас бид зун бүр амралтаараа Ариун сүм явдаг болсон юм. Бид Ариун сүмд ойрхон задгай газарт буудалладаг байв. Бид Норвегиос Ариун сүмд орохоор ирсэн бусад гэр бүлүүдтэй нэг бүлэг болж, баптисм хийлгэхийн тулд өглөө болгон эрт босдог байлаа. Бид дараа нь хөл бөмбөг тоглож, буудалласан газартаа усанд сэлэхээр явдаг байлаа.

Тэр хэдэн зун надад ариун дурсамж үлдээсэн юм. Бид сар болгон явахаар Ариун сүмд тийм ойрхон

амьдардаггүй байсан ч, Ариун сүм явах бүр нь бидэнд онцгой үйл явдал болдог байлаа. Машинаар явах нь урт хугацаа шаарддаг, ядаргаатай байсан ч Их Эзэн бидний хийсэн золиослолын хариуд биднийг адисалсан юм. Ариун сүмд миний хуримтлуулсан сүнслэг туршлага Ариун сүм болон үүний адислалуудыг эрхэмлэн дээдлэх мэдрэмжийг хөгжүүлэхэд надад тусалсан юм. Ариун сүмийн адислалууд бас манай гэр бүлийг улам нягтруулан ойр дотно болгосон юм.

Миний үзэл бодолд түр зуур зөрчил бий болсон багахан хугацаанд болсон нэг үйл явдлыг би санадаг. Аав, ээж хоёр минь өдий төдий дутагдалтай юм шиг санагдаг болсноос тэд надад хэрхэн амьдрах талаар зөвлөгөө өгөх эрхгүй юм шиг бодогддог байж билээ. Би хэдийгээр Ариун сүмд орохоор зохистой амьдардаг байсан ч, аав гэр бүлийн тэргүүний үүргээ хэрхэн биелүүлж байгаад эргэлзэдэг байв. Гэвч бид баптисм ба гишүүний баталгаа хийлгэхээр Ариун сүмд хамт очсон үед би маш сайхан сүнсийг мэдэрсэн. Аав минь нас барсан хүмүүсийн өмнөөс намайг гишүүнээр батлахаар миний толгой дээр гараа тавьсан үед тэр үнэхээр санваарын эрх мэдлээр үйлдэж байгааг би Сүнсээр мэдэрсэн. Аав минь хэдийгээр

төгс байгаагүй ч, сайн эцэг байсныг, би түүний хүү болж төрснөөрөө адислагдсаныг энэ нь надад ойлгуулсан юм. Би буруу бодол санаагаа наманчлах хэрэгтэйгээ ойлгож, аавынхаа анхааруулга зөвлөгөөнөөс мэргэн ухаан ба хайрыг мэдэрсэн билээ.

Ариун сүмийн дэргэд өнгөрүүлсэн тэр хэдэн зунаас хойш олон жил өнгөрсөн ч тэр зун цаг ой дуртгалд минь тод томруун хэвээр байдаг билээ. Мормоны Ус Алмагийн хүмүүсийн хувьд: “Тэтэлгэгчийнхээ мэдлэгт ирсэн тэдний нүдэнд тэдгээр нь хэчнээн үзэсгэлэнтэй [байсантай адил]” (Мозая 18:30) Ариун сүм дэлхий дээрх үнэхээр үзэсгэлэнтэй газруудын нэг юм. ■

Энэхүү өгүүллийн зохиогч АНУ-ын Ютад амьдардаг.

АРИУН СҮМИЙН АДИСЛАЛУУД

Та нар Ариун сүмд явснаараа ямар адислалууд хүлээн авсан бэ? Санал бодлоо гэр бүлийн аль нэг гишүүнтэйгээ хуваалцах буюу тэмдэглэлдээ бич.


Гэр бүлийн үдшийн дугуй



Гэр бүлийн үдшийг төлөвлөхөд туслахын тулд чи ажил үүрэг хуваарилах дугуй хийж болно. Эдгээр дугуй дүрсийг хатуу цаасан дээр тогтоон төмөр хавчаарын голд бэхлэл. Гэр бүлийн гишүүн бүрийн нэрийг ирмэгний гадна талд бич. Долоо хоног бүрийн ажил үүргийг өөрчлөхийн тулд дугуйг эргүүл.



Ирмэгний гадна талд гэр бүлийн гишүүдийнхээ нэрийг бич.



ОХИНЫГ, АВРААРАЙ!

Хейди С.Свинтон

Монсоны гэр бүл зун болгон Прово гол дээрх зуслангийн байшиндаа хоёр сарыг өнгөрүүлдэг байжээ. Томми Монсон түргэн урсгалтай энэ голд сэлж сурсан ажээ. Томми 13 орчим настай байхдаа нэгэн дулаахан өдөр хийлдэг том хөвөгч хоолой олж аваад дээр нь сууж голыг уруудан хөвсөн гэнэ.

Тэр өдөр голын эрэг дээр олон хүмүүс зугаалгаар ирж, аяны зуушаа идэн, тоглож байлаа. Томми голын хамгийн түргэн урсгалтай хэсгээр хөвж явтал, “Охиныг авраарай! Түүнийг авраарай!” гэж сандран хашгирахыг сонсчээ. Нэг жаахан охин усны эргүүлэг рүү уначихсан аж. Эрэг дээр байсан хүмүүсээс нэг нь ч усанд сэлж чаддаггүй байсан учир охиныг аврахаар ус руу орох хүн гарсангүй.

Тэр үед Томми ойрхон ирсэн болохоор охины толгой шовсхийн усан дор орж үзэгдэхгүй болохыг харжээ. Томми гараа сунгаж, охиныг үснээс нь шүүрч

аваад хөвөгч хоолойныхоо хажуу тал дээр түүнийг өргөн гаргасан ажээ. Тэгээд Томми голын эрэг рүү сэлүүрдэж эхлэв. Хамгийн түрүүнд гэрийхэн нь охиныг тэвэрч аваад, уйлан, үнсэж байлаа. Тэд дараа нь Томмийг чанга тэврэн үнслээ. Олон хүмүүс түүнийг ширтэн харж байснаас тэр ичин, хөвөгч хоолойгоор гэр рүүгээ хурдхан эргэв.

Томмиг голоор хөвж явахад нэгэн сайхан халуун мэдрэмж түүнд төрлөө. Тэр хүний амь аварснаа ойлгожээ. “Охиныг авраарай! Түүнийг авраарай!” гэж хашгирах дууг Тэнгэрлэг Эцэг сонссон байлаа. Яг хэрэгтэй цагт тэнд хөвж очих боломжийг Тэрээр Томмид олгосон ажээ. Тэр өдөр түүнд төрсөн сайхан мэдрэмж бол бидний Тэнгэрлэг Эцэг Бурхан бид бүгдийг нэг бүрчлэн таньдаг бөгөөд бусдыг аврахад нь Түүнд туслах боломжийг бидэнд олгодгийг Томми тэр өдөр мэдсэн ажээ. ■



Үүргээ биелүүл

Томми 11-тэй байхдаа ангийнхнаа гудамж хөндлөн гарахад нь туслах тусгай үүрэгтэй байжээ. Доорх зургийг хар. Томми үүргээ биелүүлэхэд ашигладаг байсан хоёр зүйлийг та нар олж чадах уу?



Аюулгүй тойрог

Томмиг Прово голд сэлж сурах үед хэрэгтэй үед түүнд туслахын тулд гэрийнхнээс нь нэг хүн үргэлж ойрхон байдаг байжээ. Та нар мөн Томми шиг байж, Аюулгүй тойрог тоглоомоор тоглож болно.

Шаардлагатай зүйлс:

Дөрөв буюу түүнээс дээш тоглогчид
Задгай газар

Яаж тоглох вэ:

Тойрог болж зогсоод гар гараасаа барь. Нэг тоглогч тойргийн голд зогсоно. Тойргийн голд зогсох тоглогчийн нүдийг боосон байх бөгөөд тэр явахыг хүссэн бүх чиглэлээр алгуурхан явна. Тойрог болон зогсож байгаа тоглогчид бие биенийхээ гараас барьсаар байх боловч тойргийн гол дахь тоглогчид хүрэх ёсгүй. Голд ээлжээр орж тоглоно.



ЕРӨНХИЙЛӨГЧ МОНСОНЫ ХЭЛСЭН ҮГСЭЭС

"Өөрийгөө бусдын төлөө зориулах бидний боломж хязгааргүй олон юм. . . . Баярлуулах ёстой хүмүүс байдаг. Хэлэх хэрэгтэй элэгсэг дотно үгс байдаг. Бусдад зориулсан бэлэг гэж байдаг. Хэрэгжүүлэх ёстой үйл хэрэг, аврах ёстой хүмүүс байдаг."

"Христийн Мэндэлсний Баярт зориулсан Тэргүүн Зөвлөлийн Захиас бичиг"-ээс, *Ensign*, 2001 оны 2-р сар, 73.

Гэр бүл бол Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний нэг хэсэг

Хүүхдийн Хэсгийн энэ сарын сэдвийн тухай илүү ихийг мэдэхийн тулд та энэхүү хичээл болон үйл ажиллагааг ашиглаж болно.

Амаликая гэдэг ёс бус хүний тухай Мормоны Номонд өгүүлдэг. Тэр Сүмийг устгаж, нифайчуудыг захирах хаан нь болохыг хүсч байлаа.

Ахмад Моронай бол Нифайн их цэргийн хүчтэй бөгөөд шударга удирдагч байлаа. Ахмад Моронай хүмүүст гэр бүл болон итгэлээ хамгаалах нь хэчнээн чухал болохыг сануулахыг хүсчээ. Тиймээс тэр хувцсаа урж, туг хийгээд туган дээрээ дараах үгсийг бичжээ:

“Бурханы минь, мөн бидний шашин шүтлэгийн, мөн бидний эрх чөлөөний, мөн бидний энх ам-галангийн эхнэр, мөн хүүхдүүдийн

минь тухай санамж болгоё.”


Тэр хийсэн тугаа “эрх чөлөөний туг” гэж нэрлэн савааны үзүүрт бэхэлжээ. Тэгээд тэр хүмүүс эрх чөлөөтэй байж, Бурханыг шүтэн биширч Түүний адислалуудыг хүлээн авсан хэвээр байхын тулд өвдөг сөгдөн залбирчээ (Алма 46:3–18-ыг үзнэ үү).

Өнөөдөр бидний гэр бүл, бидний итгэл хэчнээн чухал болохыг бидэнд сануулдаг зүйл бий. Энэ бол “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг” юм. Уг тунхгаас энд хэдэн үгийг эш татъя:

“Гэр бүл нь Түүний хүүхдүүдийн мөнхийн хувь заяаны төлөөх Бүтээгчийн төлөвлөгөөний төвд байдаг. . . . Гэр бүл Бурханаас заяагддаг.” ■

Гэр бүлээрээ ярилцах санаанууд

Та “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг”-ийг гэрийнхэнтэйгээ хамт уншиж болно. Та бас гэр бүлээ хүчирхэгжүүлэх арга замуудыг гэрийнхэнтэйгээ хамтран ярилцаад, ярилцсан арга замуудаасаа нэгийг нь сонгож түүн дээр төлөвлөгөө гарган ажиллаж болно.





Дуу ба судар

- "Families Can Be Together Forever (Гэр бүлүүд үүрд хамт байж чадна)," *Children's Songbook*, 188
- Алма 46:3–18

Гэр бүлийн тугийн үйл ажиллагаа

Цаас юм уу даавуу ашиглан гэр бүлийг тань төлөөлөх туг хий. Гэр бүлдээ онцгой чухал зүйлсийг зурахад самбарын үзэг юм уу будгийн харандаа ашигла.

Гэр бүлийн гишүүд тань Есүс Христ, Тэнгэрлэг Эцэг хоёрт итгэх итгэлийнхээ тухай эсвэл гэр бүл байснаас ирдэг адислалуудынхаа тухай бодоход нь туслах судрын эшлэл буюу үгсийг туган дээрээ бич.

Миссурид тохиолдсон хүнд сорилтууд

Женнифер Мадди

Сүмийн түүхэн дэх нэг чухал газрыг бидэнтэй хамт судална уу!

Огайогийн Көртландаас Миссурийн Индепенденс рүү хийсэн аялал Иосеф Смитийн хувьд урт удаан, хүнд бэрх байлаа. Тэр морин тэргээр, завиар, эцэст нь өртөөний сүйх тэргээр явжээ. Сүүлчийн 402 километр газрыг явган явсан гээд бод л доо! Гэвч Их Эзэн түүнд Сионыг байгуулахын тулд Миссури рүү яв гэж хэлсэн учраас Иосеф Смит дуулгавартай дагасан юм.

Сүмийн бусад гишүүд Миссурид 1831 онд ирж эхэлсэн юм. Тэд газар

хагалж, орон гэрээ барин, тариа тарьж, ургацаа хураан авчээ.

Сүмийн улам олон гишүүд Миссурийн Индепенденсэд ирэхэд тэнд өмнө нь амьдарч байсан зарим хүмүүс тэдэнд сэжиглэнгүй хандаж, уурлах болжээ. Танхайрагч бүлгүүд Гэгээнтнүүдийн гэр орныг дайрч, тэднийг тэндээс явахыг шаардах болжээ. ■



Индепенденс дэх зочдын төвийн энэхүү үзмэр Гэгээнтнүүд жижигхэн дүнзэн байшингууддаа зав чөлөөгүй ажиллаж байсныг харуулж байна.





Виллям В. Фелпс Индепенденст хэвлэх цех байгуулж, сонин гаргадаг байжээ. Тэр бас Их Эзэнээс Бошиглогч Иосеф Смитэд өгсөн зарим илчлэлтийг агуулсан Зарлигуудын Номын хэсгийг хэвлэжээ. Эдүгээ илчлэлтүүд Сургаал ба Гэрээнд байдаг.




ЛИБЕРТИ ШОРОН

1838 оны өвөл Иосеф Смит Сүмийн өөр таван удирдагчийн хамт хилс хэргийн учир баривчлагдаж, Либерти шоронд хоригджээ. Уг шорон харанхуй, бохир, маш хүйтэн байснаас гадна хоригдлуудад дулаан хөнжил байсангүй, тэднийг сайн хооллодоггүй байв. Либерти шорон зузаан чулуун ханатай байв. Дээд өрөөнд шоронгийн хуяг болон түүний гэр бүл амьдардаг бол доод өрөө нь хоригдлуудын "гяндан" байв. Зөвхөн доод давхар л орох, гарах ганцхан хаалгатай байжээ.

Бошиглогчийг шоронд байхад Их Эзэн түүнд хандан, "Хүний хийж чадах юмнаас бүү эмээ, учир нь Бурхан чамтай үүрд мөн мөнхөд хамт байх болно" (С ба Г 122:9) гэжээ.

Сүм уг шоронгийн зарим хэсгийг дахин барьж, зарим чулууг сэргээн, дэргэд нь зочдын төв барьсан билээ. Бурханы бошиглогч шоронд байхдаа тайтгаруулагч олон илчлэлт хүлээн авсан газрыг үзэхээр өнөөдөр олон зочид ирж байна.


БИДНИЙ ХУУДАС



Мексикийн 3 настай Рикардо О. үйлчлэх дуртай ажээ. Тэр хагас сайн өдөр бүр бяцхан эмэгтэй дүү Олеатайгаа хамт салбарынхаа ариун ёслолын цуглаан болдог байрыг шүүрдэж цэвэрлэхэд аав, ээж хоёртоо тусалдаг гэнэ. Тэр зөвхөн сүм дээр төдийгүй гэртээ үргэлж инээмсэглэн үйлчилдэг ажээ.




Лои П., нас 7, Камбож



Би сүмдээ бас Хүүхдийн Хэсгийн хичээлд явах дуртай. Бид одоо уншиж сурч байгаа. Мормоны Номын түүхүүдэд би дуртай. Би бяцхан эмэгтэй дүүтэйгээ хамт ээждээ туслах дуртай. Бид хоёр *Лиахонагийн* хүүхдүүдэд зориулсан хэсгийг унших дуртай. Дүү бид хоёр Ерөнхийлөгч Монсон, Монсон эгч хоёрын төлөө залбирдаг.

Алисон А., нас 6, Хуана А., нас 3, Аргентин




Уэст Инди, Ямайкагийн Мандевилл дүүргийн Жанкшен салбарын Хүүхдийн Хэсгийн хүүхдүүд Аврагчийн тухай мэдэж, баптисм хийлгэн, Ариун сүмд орохоор бэлтгэж, Түүний үлгэр жишээг дагахыг хичээж байна.



Нгуен Л., нас 7, Камбож



Бразилын 4 настай Мария К., ариун ёслолын цуглаан дээр үг хэлсэн ажээ. Тэр Итгэлийн Тунхагийн 13-ыг ганц ч үг гээлгүй цээжээр хэлэхэд бүх хүмүүс гайхсан гэнэ. Мария чин сэтгэлээсээ залбирч, Есүс Христийн тухай гэрчилдэг гэж Хүүхдийн Хэсгийнх нь ерөнхийлөгч ярилаа.



Ренато ба түүний гэр бүл түүний баптисм дээр

Манай Хүүхдийн Хэсэг нэг өдөр Бразилын Сан Пауло Ариун сүм дээр очиж үзсэн. Би тийм гоё цэцэрлэгийг хэзээ ч үзээгүй. Бид Ариун сүмд хийсэн гэрээнүүдээрээ дамжуулан гэр бүлтэйгээ үүрд хамт амьдарч чадна. Ариун сүмийн ерөнхийлөгч хүлээлгийн өрөөнд бидэнд хандан үг хэлсэн. Тэр өрөөнд бид олон гоё зураг үзсэн. Надад үнэхээр сайхан санагдсан. Ээж үүнийг Ариун Сүнс надад миний мэдсэн зүйлс үнэн гэдгийг гэрчилж байгаа нь тэр гэж ярьсан. Би Ариун сүм бол Их Эзэний өргөө гэдэг гэрчлэлтэй болсон.

Ренато Б., нас 8, Бразил



Ариун сүмийг гаднаас нь харахад маш гоё. Эргэн тойрондоо олон гоё цэцэгтэй. Гэвч би гэр бүлтэйгээ лацдан холбуулахаар дотор нь ороод Ариун сүм дотроо гадна талаасаа илүү гоё болохыг харсан.

Николас М., нас 5, Колумб



Арванхоёр Төлөө-
лөгчийн Чуулгын
Ахлагч
Давид А.Беднар

Гэр бүлийн түүхийн ажил яагаад маш чухал байдаг вэ?

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүд
бол Есүс Христийн онцгой гэрчүүд юм.

Бошиглогч Иосеф Смит, “Энэ дэлхий дээрх бидний хамгийн агуу үүрэг хариуцлага бол . . . нас барагсдаа анхаарал тавих явдал мөн” хэмээн тунхагласан юм.¹

Гэр бүлийн түүх бол аврал ба өргөмжлөлийн ажлын нэн чухал хэсэг мөн.

Өвөг дээдсээ эрэн сурвалжилж, тэдний өмнөөс авралын ёслолуудыг хийлгэх нь бидэнд гэрээгээр өгөгдсөн ариун үүрэг хариуцлага юм.

Би Сүмийн өсвөр үеийнхнийг Елиагийн Сүнсний тухай болон үүнтэй холбоотой үйл явдлуудыг мэдэхэд урьж байна.²

Өвөг дээдсээ судалж мэдэн, төрөл төрөгсдийнхөө өмнөөс Ариун сүмд төлөөлөн гүйцэтгэх ёслолууд хийлгэхэд өөрсдийгөө бэлтгэхэд би та бүхнийг уриалж байна.

Та нар энэхүү урилгад итгэлээр хариулбал, зүрх сэтгэл тань эцгүүд рүүгээ эргэх болно.

Өвөг дээдсээ хайрлах хайр, талархал тань өсөн нэмэгдэх болно.

Та нар өсвөр насандаа хийгээд амьдралынхаа туршид хамгаалагдах болно.

Та нарын гэрчлэл болон Аврагчид хөрвөх хөрвөлт тань гүн гүнзгий, бат бөх болно. ■

“Хүүхдүүдийн зүрх сэтгэл эргэх болно,” Лиахона, 2011 оны 11-р сар, 24–27-гоос хялбаршуулан авав.

ЭШЛЭЛ

1. Сүмийн Ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит (2007), 475.
2. Сургаал ба Гэрээ 2:1–2-ыг үзнэ үү.





ХИВСНИЙ ТУҮХ

Хивсэнд хэчнээн түүх шингэс- нийг хэн мэдэх билээ?

Кей Тимпсон

Бодит түүхээс сэдэвлэв

“Хүүхдүүд бид хайртай өвөг дээдсээ эрж олон, тэднийг мөнхжүүлж чадна” (“Truth from Elijah,” Children’s Songbook, 90–91).

Кати гудамжны адаг дахь том царс модыг чиглэн явган хүний замаар явж байлаа. Тэр энэ хөгшин царс модоор баримжаалан Нана эмээгийн гэрийг маш амархан олдог ажээ.

Нана эмээ ердийнхөөрөө зочны өрөөнд тод өнгийн утаснуудаар сүлжээс хийн чимээгүй сууж байлаа. Нанагийн гэрийн гялалзсан модон шалыг Нана эмээгийн өөрийнх нь нэхсэн гоёмсог хивснүүд чимжээ.

Кати тэднийд орж ирээд “Сайн уу, эмээ?” гэж мэндэллээ. Тэр хоёр удалгүй “дээр үеийн” хэмээн Нана эмээгийн нэрлэсэн юмсын тухай ярьж гарна. Тэд бас хар цагаан баахан гэрэл зураг үзэж сонирхоно. Ялангуяа Кати өөрийг нь бага байсан үеийн хүмүүсийн хувцас, үс засалтын маягийг ихэд сонирхон үзнэ.

“Юм бүхэн их өөр байж дээ. Бид машин, телевизор, гар утасгүй байсан юм шүү дээ” хэмээн Нана эмээ санаа алдан хэллээ.

Дуртай газраараа хаагуур ч хамаагүй явж болдог байсныг Кати бүр төсөөлж ч чадахгүй байлаа. “Эмээ, та нар цагийг хөгжилтэй өнгөрөөхийн тулд юу хийдэг байсан бэ?” гэж Кати асуулаа.

“Бид хамтдаа дуулдаг байсан. Бид орой болохоор төгөлдөр хуур тойрч суугаад дуртай дуунуудаа дуулдаг байлаа. Заримдаа бүр хоолойгоо сөөтөл дуулдаг байсан

гээч! Тийм л хөгжилтэй цаг байсан юм даа.”

Нана эмээ өнгөрсөн үеийг эргүүлэн авчирч, дахин харах гэсэн шиг цонхоор гадагш ширтлээ.

Кати Нана эмээгийн өвөр дээрх дэлгээстэй хивсэнд тулж суугаад Нана эмээ хивсийг гараараа хэрхэн нэхэхийг анхааралтай ажиглаж байлаа.

“Чамайг өөрийнхөө гараар нэхсэн хивстэй болохыг хэчнээн их хүсдэг бол оо гэж би дандаа боддог шүү” гэж Нана эмээ үгээ цувруулан удаан гэгч нь хэлэв.

Кати үсрэн босч, алгаа ташиж гарлаа.

“Хэлээд яахав, Нана эмээ! Хоёулаа өнөөдөр эхлэх үү?”

Нана эмээ хи хи гэж инээснээ, “Сайн байна. Гэвч чамд эхлээд хийх юм байна. Гэртээ хариад хуучин хувцаснууд байвал аваад ир. Түүнээс чинь бид утас гаргаж авна” гэлээ.

Тэр Кати руу бөхийж, нүд нь гялалзан, ямар нэгэн нууц зүйл ярьж байгаа юм шиг намуухан дуугаар ярина.

“Энэ чинь л хивсийг гоё болгож байгаа юм шүү дээ. Хуучин хувцсаар хийдэг учраас хивс чамд амьдралын чинь түүхийг ярьж өгнө. Нэхээс бүр нь өөрийн чинь тухай номны бүлэгтэй адил юм. Чи хуучин хувцасны утас бүрийг хараад тэр хувцсыг хаана өмсөж байснаа, түүнийг өмсөөд юу хийж байснаа санаж байх болно.”

Кати нүдээ том болгон Нана эмээгийн нэхэж байгаа хивс рүү заагаад

“Та энэ хивсэнд орсон бүх хувцсаа санадаг уу?” гэж асуув.

Нана эмээ инээмсэглээд, “Тийм ээ, тэгэлгүй яахав! Улаан утсаар

нэхсэн энэ хэсгийг чамайг төрөх үед өмсөж байсан даашинзнаасаа авсан юм. Би төрөх газарт очоод чамайг ойроос сайн харах гэж хамраа цонхны шилэнд наан харж байснаа санаж байна. Чи тэгэхэд үрчийсэн жаахан улаан юм байж билээ” гэв.

Нана эмээг хивсний түүхээс цааш нь ярихад Кати, Нана эмээ хоёр чанга инээлдэж байлаа. Тэр орой Кати гэртээ ирмэгцээ хивс нэхэхэд ашиглаж болох хуучин хувцсуудыг ээжтэйгээ хамт ялгалаа.

Кати маргааш нь ялгасан хувцсуудаа Нана эмээгийн гэрт аваачлаа. Нана эмээ даавууг хэрхэн урт нарийхан хэсгүүд болгон хайчлаад дараа нь сүлжээс болгож, сүлжээсүүдээ нийлүүлэн хивс нэхэхийг үзүүлжээ.

Кати хичээлийнхээ дараа өдөр бүр Нана эмээгийн гэрт хивс нэхэхээр очдог байлаа.

Нэхэж байгаа хивс нь бага багаар томорсоор байв. Кати өдөр хоног өнгөрөх тусам Нана эмээгийн түүхүүдийг цээжээр мэддэг болов. Нэлээд хутацаа өнгөрсний дараа Кати Нана эмээд олон түүх ярьж өгдөг болжээ.

Кати нэг өдөр өмсөх дуртай байсан жийнснээсээ гаргаж авсан утсаар хивсэндээ цэнхэр өнгөтэй хэсгийг оруулаад, өнгө алагласан нэхээсийг гарынхаа алгаар илж үзлээ.

Нана эмээ түүний хивсийг харж байснаа дээш өндийж, “Хивс чинь дуусах дөхжээ!” гэв.

“Арай болоогүй” гэж Кати хэлээд инээмсэглэв. Тэр Нана эмээгээс хивс нэхэж сурахаа энэ удаад дуусгахыг огт бодоогүй ажээ. ■

ГЭР БҮЛИЙН ТҮҮХЭЭСЭЭ ХУВААЛЦ

Н анагийн хийсэн эрээн хивс Катитай түүхүүдийг хуваалцахад тусалсан ажээ (хуудас 66–67-г үзнэ үү). Танай гэр бүлийн гишүүд түүхүүдийг бие биентэйгээ хуваалцахад тусалж болох нэг тоглоомын тухай өгүүлье!

Шаардлагатай зүйлс:

- Хэдэн жижиг, тод өнгөтэй зүйлс. Эдгээр юмс дор хаяж зургаан өөр өнгөтэй байх ёстой. Товчнууд, будсан жижиг чулуу, эсвэл өнгөтэй лаа байж болно.
- Эдгээр зүйлсийг цүнхэнд хий.

Тэгээд:

1. Энэ хуудасны төгсгөл дэх хүснэгтийг жижиг зүйл бүрийн өнгөөр будаж бөглө.
2. Гэр бүлийн гишүүдийг тойрог болгон суулга. Жижиг зүйлс цүнхэнд хий.

3. Цүнхийг тойрог болон суусан гэр бүлийн гишүүдэд дамжуулан өг. Тэд ээлж ээлжээр цүнхэн дотроос нэг зүйл аваад цүнхийг дараагийн хүнд дамжуулна. Цүнхэн дотроос авсан өнгөтэй тохирч байгаа зүйлд хариулна. Цүнхэн дотор нэг ч юм үлдэхгүй болтол тоглоомыг үргэлжлүүл.

ГЭР БҮЛИЙН ТҮҮХ ХУВААЛЦАХ ХҮСНЭГТ

Өнгө бүрээр хүмүүсийн хуваалцсан өөр өөр түүхүүдийг санаж байна уу?

Өнгө:

Хуваалцах зүйл:

	Хамгийн сайн найзынхаа тухай бидэнд ярина уу.
	Зоригтой байх шаардлага хэзээ танд тулгарч байсан бэ?
	Өөрийнхөө хийсэн муухай эсвэл ичмээр ямар нэгэн тохиолдлын тухай бидэнд ярьж өгнө үү.
	Сударт гардаг түүхүүдээс алинд нь чи дуртай вэ? Яагаад?
	Өөрт чинь сонирхолтой байсан сургуулийн ямар нэгэн төслийн тухай бидэнд ярьж өгнө үү.
	Хэрэв чи ямар нэг амьтан болж хувирвал, ямар амьтан болох байсан бэ? Яагаад?

Сайн байна уу, Би Эл Салвадорын Эрика байна



Миний нэр Эрика З., би Эл Салвадорын Сан Салвадор хотод амьдардаг, би Ариун сүмийн ёслолуудад хүмүүсийн нэрсийг бэлтгэх дуртай.

Манай салбарын Нийгмийн Халамжийн Бүлгийн эгч нар надаас FamilySearch програмыг ашиглан нэрс индексжүүлж чадах уу гэж асуусан. Би туслахыг хүссэн юм. Ээж бас надад туслахыг хүсэв. Тиймээс бид хамтдаа нэрсийг индексжүүлж сурч эхэлсэн юм.

Энэ ажлыг анх эхэлж байхад есөн нэр индексжүүлэхэд бүтэн өдөр зориулж билээ. Харин шаргуу ажиллаж, байнга дадлага хийсний үр дүнд би одоо өдөрт 300 нэр индексжүүлж чаддаг болсон.

Би гэрийн даалгавраа хийснийхээ дараа заримдаа нэрсийн индекс дээр хэдэн цаг зарцуулдаг. Миний хувьд нэрсийг индексжүүлэх нь тоглох юм уу зурагт үзэхтэй адил зугаатай байдаг. Харин энэ нь илүү чухал зорилгыг хэрэгжүүлэхэд тусалдаг.



Тэнгэрлэг Эцэг сүнсний дэлхийд байгаа Сальвадорын 2000 гаруй өвөг дээдсийн нэрсийг Ариун сүмийн ёслолуудад бэлтгэх боломж олгож намайг адисалсныг би мэднэ.

Есүс шавь нараа дуудсан нь

Марко Мае
Лук 5:1-11-ээс.

Симон, Андрей нар ах
дүү хоёр загасчин байлаа.
Нэг орой Симон, Андрей
хоёр шөнөжингөө
загасчлаад ганц ч загас
барьж чадсангүй.




Есүс Симоны завин дээр сууж байв:
Тэрээр ах дүү хоёрт загасныхаа торыг
тэнгист дахиад нэг тавиад үз гэжээ.
Тэд тороо татан гаргаж иртэл, тороор
нь дүүрэн загас баригдсан байлаа!






Симон, Андрей хоёр найз Иаков, Иохан нараа дуудаж, тэдний хоосон завийг загасаар дүүргэж өгөхөд туслаач гэжээ. Хоёр завийг пиг дүүргэхээр тийм олон загас баригдсан байлаа! Есүс тэдэнд, хэрэв тэд Түүнийг дагах юм бол зүгээр нэг загас барихаас илүү чухал ажилтай болж хүмүүсийн загасчид болно гэж хэлжээ.

Симон, Андрей, Иаков, Иохан нар юм бүхнээ, түүний дотор завиа орхиж, Есүсийн шавь нар болсон юм. Тэд Есүсийг дагаж, Түүний сайн мэдээг хүн бүрт заахад тусалсан билээ.



Бид тороороо загас барьдаг загасчинтай адилхан хүмүүст сайн
үлгэр дууриал үзүүлж, Есүсийн тухай тэдэнд зааснаар тэднийг сайн
мэдээнд авчрахад тусалж чадна. Бид ч бас хүмүүсийн загасчин
байж чадна шүү дээ! ■





ЕСҮС ШАВЬ НАРАА ДУУДСАН НЬ

“Есүс Симонд хандан, Бүү ай! Үүнээс хойш чи хүмүүсийг загасчлах болно гэв.

“Тэгээд тэд . . . бүхнийг орхин, Түүнийг дагалаа” (Лук 5:10-11).

СҮМИЙН МЭДЭЭ

Сүмийн мэдээ болон үйл ажиллагаануудын тухай news.lds.org -аас үзнэ үү.

Номлолын шинэ ерөнхийлөгчид үйлчлэхээр дуудагдав

Сүм энэ сараас өөрсдийн томилогдсон бүсүүдэд үйлчлэлээ эхлүүлэх дараах номлолын шинэ ерөнхийлөгчдийг дуудлаа.

НОМЛОЛ	ШИНЭ ЕРӨНХИЙЛӨГЧ
Алабамагийн Бөрмингам	Ричард Д.Хэнкс
Анголын Луанда	Дэнни Л.Мэррилл
Аргентины Буэнос Айрэс Хойд	Дэвид С.Эир
Аргентины Буэнос Айрэс Өмнөд	Ларри Л.Тургүүд
Аргентины Комодоро Ривадавиа	Марк Ф.Рожэрс
Аргентины Кордоба	Рубен В.Аллиауд
Аргентины Посадас	Лий Р. ЛаПиэррэ
Аризонагийн Гилберт	К.Брэтт Наттресс
Аризонагийн Меса	Куйрк Л.Жэнкинс
Аризонагийн Скоттсдэил	Карл Р.Свийний
Аризонагийн Тэмпи	Жэймс Л.Түүнэ
Армены Ерэван	Ж.Стивэн Карлсон
Австралийн Бризбэн	Лон И.Хэндэрсон
Австралийн Мэлбурн	Кори Х.Максвэлл
Австралийн Сидней Хойд	Филипп Ф.Ховес
Австралийн Сидней Өмнөд	Ларри Ж.Лүү
Боливийн Ла Паз	Жюлиан А.Паласио
Боливийн Санта Круз	Жэйсон А.Виллард
Боливийн Санта Круз Хойд	Ричард К.Замбрано
Ботсваны Габарон	Мэррилл А.Вилсон
Бразилийн Куритиба	Андэрсон М.Монтэйро
Бразилийн Куритиба Өмнөд	Леонэл Р.Фэрнандэс
Бразилийн Форталеза Зүүн номлол	Карлос Фуско
Бразилийн Гоианиа	Дэвид Кучэки
Бразилийн Хоао Пэссоа	Изаиас П.Ногуэира
Бразилийн Хуиз дэ Фор	Лучиано Каскарди
Бразилийн Лондрин	К.Албэрто дэ Гэнэро
Бразилийн Натал	Сауло Соарэс
Бразилийн Пирасикаба	Кэннэди Ф.Кануто
Бразилийн Рибэйрао Прэто	Мауро Т.Брам
Бразилийн Санта Мариа	Адалтон П.Паррэла
Бразилийн Сантос	Кэлсо Б.Кабрал

НОМЛОЛ	ШИНЭ ЕРӨНХИЙЛӨГЧ
Бразилийн Сао Пауло Баруун номлол	Хосэ Луиз Дэл Гуэрсо
Калифорны Бэйкэрсфийлд	Жэймс М.Вилсон
Калифорны Карлсбад	Хаал С.Кэндрик
Калифорны Уйрвин	Вон Д.Оргилл
Калифорны Лонг Бийч	Раин М.Түү
Калифорны Лос Анжелес	Дэвид Н.Вэйдман
Калифорны Ранчо Кукамонга	Брус И.Хоббс
Калифорны Рэдландс	Даниэл Ж.Ван Котт
Канадын Эдмонтон	Ларри Г.Манион
Канадын Монреал	Виктор П.Патрик
Чилийн Антофагаста	Крэг Л.Далтон
Чилийн Консепсион	Кэнт Ж.Аррингтон
Чилийн Ранкагуа	Томас Р.Воорн
Чилийн Сантиаго Өмнөд	Дэвид Л.Күк
Чилийн Сантиаго Баруун номлол	Хосе А.Баррэйрос
Колумбын Барранкуила	Кэнт Р.Суйрл
Колорадогийн Денвер Өмнөд	Ж.Блэйк Мурдок
Колорадогийн Форт Коллинс	Кэлли В.Браун
Чех/Словак	Жэймс В.МаКонки III
Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улсын Киншаса	В.Браис Күк
Экваторын Гуаякүил Өмнөд	Максимо К.Торрэс
Экваторын Гуаякүил Баруун номлол	Жорж Дэннис
Экваторын Кито Хойд	Браин А.Ричардсон
Сальвадорын Сан Сальвадор Зүүн номлол	Дэвид Л.Глэизир
Сальвадорын Сан Сальвадор Баруун/Бэлиз	Кэи Д.Хинтз
Английн Лийдс	Грайм Пилкингтон
Флоридагийн Жаксонвилл	Паул В.Крэг
Флоридагийн Орландо	Маикл Ж.Бэрри
Флоридагийн Таллахасси	Брэдди Ж.Смит
Флоридагийн Тампа	Марк Д.Күсик
Жоржиа Мэкон	Брэнт Т.Коттл
Ганы Аккра Баруун номлол	Норман К.Хилл
Гватемалын Кобан	Жон Ф.Куртисс
Гватемалын Рэталулэу	Жонни Ф.Рүиз

НОМЛОЛ	ШИНЭ ЕРӨНХИЙЛӨГЧ
Хавайн Хонолулу	Стифэн Р.Ворнэр
Гондурасын Сан Пэдро Сула Зүүн номлол	Норман С.Клэин
Гондурасын Сан Пэдро Сула Баруун номлол	Жэймс М.Дэстэр
Айдахогийн Боиси	Жон Виндер
Айдахогийн Нампа	Стюарт Б.Каннон
Айдахогийн Твин Фоллс	Глэн Р.Көртис
Иллиной Чикаго	Паул С.Вүүдбери
Иллиной Чикаго Баруун номлол	Жэрри Д.Фэнн
Энэтхэгийн Бангалор	Дэвид М.Бэррэтт
Индианагийн Индианаполис	Стивэн К.Клийвланд
Индонезийн Жакарта	Кристофер Л.Доналд
Аиова Дэ Моин	Жон Р.Жэнсэн
Италийн Милан	Брус Л.Дибб
Италийн Ром	Маикл Ваддүпс
Ямайкагийн Кингстон	Кэвин Г.Браун
Японы Нагоя	Казүхико Ямашита
Японы Токио Өмнөд	Такаши Вада
Канзасын Вичита	Маикл Л.Бэлл
Кенийн Наироби	Гэри К.Хикэн
Солонгосын Дэжон	Ёнг-Ин С.Шин
Солонгосын Сөүл Өмнөд	Маршалл Р.Моррис
Либерийн Монровиа	Рожэр Л.Көркам
Маршаллын арлуудын Мажуро	Томас Л.Вэир
Мексикийн Агуаскалиентэс	Хуан Вилларил
Мексикийн Канкун	Дэйл Б.Куйркама Бага
Мексикийн Чихуахуа	Улисес Чавез
Мексикийн Сиудад Хуарэс	Родолфо Дэртбэс
Мексикийн Сиудад Обрэжин	Маурисио Мунивэ
Мексикийн Кулиакан	Хэсүс Вэлэс
Мексикийн Мэрида	Сэржио А.Гарсиа
Мексикийн Мехико Сити Чалко	Жэралд Д.Крикмор
Мексикийн Мехико Сити Зүүн номлол	Сэржио М.Аная
Мексикийн Мехико Сити Баруун хойд номлол	Брэд Х.Холл
Мексикийн Мехико Сити Баруун номлол	Жорж Ф.Ваитхэд

НОМЛОЛ	ШИНЭ ЕРӨНХИЙЛӨГЧ
Мексикийн Монтерри Зүүн номлол	Ларри К.Бөрд
Мексикийн Пачука	Андрю И.Эгбөрт
Мексикийн Күэрэтаро	Хавиэр Л.Мехорада
Мексикийн Рэйноса	Абэлардо Моралэс
Мексикийн Салтилло	Л.Фэрнандо Родригэс
Мексикийн Виллахэрмоса	Израйль Г.Моралэс
Мичиганы Дитроит	Нолан Д.Гэрбэр
Миссурийн Сэинт Лүис	Томас В.Морган
Монголын Улаанбаатар	Жозэф П.Бэнсон
Невадагийн Лас Ве- гас Баруун номлол	Маикл Б.Аландэр
Нью Хаймпширын Манчэстэр	Филип М.Стөүкэр
Нью Мэксикогийн Албакуйрки	Стивэн Ж.Миллэр
Нью Йоркийн Рочэстэр	Артур Р.Франсис
Шинэ Зеландын Хамилтон	Чарлз А.Радд
Никарагуагийн Манагуа Хойд	Монсон Колладо
Никарагуагийн Манагуа Өмнөд	Браин Г.Рассэл
Нигерийн Бэнин Сити	Акингбэид А.Ожо
Нигерийн Энугу	Фрийбоди А.Мэнса
Нигерийн Лагос	Ричард К.Ахаджи
Охайогийн Синсиннати	Жон П.Портэр
Оклахомагийн Оклахома Сити	Стюарт Р.Вокэнхорст
Оригоны Сэлэм	Маикл Р.Самүэлиан
Панамын Панама Сити	Көртис Кармак
Папуа Шинэ Гвиней Лэй	Марк П.Петеру
Парагвайн Асунсион Хойд	Гарн Х.МакМуллин
Пенсилваниагийн Филадельфия	Т.Гэри Андэрсон
Перугийн Арэкуипа	Ричард Зобрист
Перугийн Куско	Робэрт К.Харбэртсон
Перугийн Хуанкаёо	Дэвид Я.Хэндэрсон
Перугийн Икүитос	Алэхандро Гомэс
Перугийн Лима Хойд	Жон Р.Эриксон
Перугийн Лима Баруун номлол	Блэйк Д.Арчиболд
Перугийн Тружилло	Д.Көрт Марлэр
Филиппиний Багуио	Энтони Жон Баллэдос
Филиппиний Бутуан	Пастор Б.Торрэс
Филиппиний Кагаян дэ Оро	Албэрто К.Булсэко
Филиппиний Кааяян	Жорж Р.Ральф
Филиппиний Катив	Дуглас К.Таи

НОМЛОЛ	ШИНЭ ЕРӨНХИЙЛӨГЧ
Филиппиний Сэбү Зүүн номлол	Ричард Л.Таннэр
Филиппиний Илоило	Жэими Р.Акино
Филиппиний Лэгаспи	Жовенсио А.Гуанзон
Филиппиний Нага	Л.Барри Рийдэр
Филиппиний Күзон Сити	Карлос Ревилло
Филиппиний Урданэта	Виллиам Ж.Монахан
Польшийн Варшав	Стивэн К.Эдгрэн
Пуэрто Рикогийн Сан Хуан	П.Нокс Смарт III
Оросын Москва	Гарри И.Бордэрс
Оросын Самара	Маикл Л.Щваб
Оросын Екатеринбург	Вал Ж.Крисчэнсэн
Сьерра Леонегийн Фритаун	Дэвид Б.Остлэр
Өмнөд Африкийн Дурбан	Жон А.Закрисон
Тайваний Тайчунг	Курт Л.Бликэнстаф
Техасын Форт Верт	Родни А.Эимс
Техасын МакАллэн	Фэрнандо Малуэнда
Техасын Сан Антонио	Жэимс И.Слоотэр
Тонга Нуку’алофа	Лэитони М.Тупоу
Угандагийн Кампала	Робэрт Ф.Чатфийлд
Украины Львов	Даниэл И.Латтин
Уругвайн Монтэвидео Баруун номлол	Томас А.Смит
Ютагийн Солт Лэйк Сити	Стифэн В.Хансэн
Ютагийн Солт Лэйк Сити Зүүн номлол	Жон К.Эбэрхарт
Ютагийн Солт Лэйк Сити Өмнөд номлол	Робэрт И.Чэмбэрс
Ютагийн Сэинт Жорж	Жон Р.Сэнтэр
Венесуэлийн Валэнсиа	Гүиллэрмо И.Гуардиа
Виржиниагийн Чэсапийк	Алан Ж.Бэкэр
Виржиниагийн Ричмонд	И.Брэдли Вилсон
Вашингтон ДС Хойд	Петр С.Күк
Вашингтоны Эвэрэт	Марк Бонам
Вашингтоны Фэдэрал Вэй	Робэрт И.Ийтон
Вашингтоны Кэннэвик	Бойд С.Вэир
Вашингтоны Сиаттл	Ёон Хван Чой
Вашингтоны Ванкүүвэр	Дэрлин К.Тэйлор
Висконсины Милвокий	Рэймонд А.Катлер
Замбийн Лусака	Лэйф Ж.Эриксон

Ахлагч Күк Зааны ясан эргийн арлын гишүүд болон сонирхогчдод хандан үг хэлэв

Бичсэн Р. Скотт Ллойд

Сүмийн мэдээ

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Квинтин А.Күк 2013 оны 2-р сард Зааны Ясан Эрэг улсын Абиджан хотод (Айвори арал) аялав. Айчлалынхаа үеэр тэр санваарын удирдагчдын чуулганд тэргүүлэн оролцож, гишүүд болон сонирхогчдод зориулсан онцгой цуглааныг явуулж, засгийн газрын томоохон албаны хүмүүстэй уулзав.

Ахлагч Күкийг Далын Ерөнхийлөгчийн зөвлөлийн Ахлагч Л. Витни Клэйтон; Далын гишүүн Африкийн Баруун бүсийн Ерөнхийлөгч Ахлагч Жон Б.Диксон; болон Африкийн Баруун бүсийн Ерөнхийлөгчийн зөвлөлийн нэгдүгээр зөвлөх Ахлагч Жозэф В.Ситати нар дагалдан явлаа.

Санваарын удирдагчдын чуулган болон гишүүд ба сонирхогчдын цуглаанд 619 сонирхогчдыг оруулаад нийт 9693 гишүүд оролцлоо. Олон гишүүд цуглаанд оролцохын тулд агуу золиослол хийв. Зааны Ясан Эрэг улсын Абиджан Номлолын Мигүи салбарын Виржини Оулаи Тонго эгчийн гэр бүл Төлөөлөгчийг очиж харахын тулд мөнгөө цуглуулжээ. “Бид 12 цаг аялсан ч би жаргалтай байна” гэж тэр хэлэв.

Чуулганд оролцсон олон хүн Сүнснийг маш ихээр мэдэрч, баяссанаа онцлон ярьж байна. Кокоди гадасны Докү тойргийн бишоп Леон Коуадио хэлэхдээ, “Бидний дунд Аврагчийн маань онцгой үйлчлэгч байсан гэдгийг би мэдэж байна” гэлээ.

Зааны Ясан Эрэг улс дахь сүмийн гишүүнчлэл 1984 онд байсан ганц гэр бүлээс өнөөдөр таван гадас, нэг дүүрэг болтлоо өссөн юм.

Сүүлийн хэдэн жил Зааны Ясан Эрэгийн гэгээнтнүүдийн итгэлтэй байдал, тэдний гэр бүлийн түүх болон ариун сүмийн ажилд бодьтойгоор харагдаж байна. Зааны Ясан Эрэг улсын таван гадаснаас гурав нь 2012 онд ариун сүмийн ёслолууд хийлгэх



Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Квинтин Л.Күк 2-р сард Зааны Ясан Эрэг улсын Абиджанд цугласан мянга мянган хүмүүст хандан үг хэллээ.

гэр бүлийн нэрс явуулсан насанд хүрэгчдийн эзлэх хувиараа сүмийн хэмжээнд эхний 25-д орсон юм. Сүмийн бүх гадаснуудаас Кокоди гадас нь нэг дор эсвэл өөр бусад үед ариун сүмийн ажилд зориулан нэрс илгээсэн насанд хүрэгчдийн тоогоороо хамгийн их хувийг эзэлжээ.

Өсвөр үеийнхэн мөн энэ ажилд идэвхтэй оролцож байна. Хэдийгээр тэдний хэн нь ч хувийн компьютер, интернеттэй холбогдох боломжгүй ч гэсэн ажлаа хийхийн тулд гадасны гэр бүлийн түүхийн төв рүү явах хэрэгтэй болдог бөгөөд өсвөр үеийнхний индексжүүлэх ажил хийж байгаа тоон үзүүлэлт сүмийн дунджаас хоёр дахин, бүр түүнээс ч өндөр байна.

Гэр бүлийн түүхийн ажил нь сайн мэдээний дагуу амьдрахын чухал хэсэг гэдгийг гишүүд заалгаж ирсэн байна. Тэд Ганийн Аккра Ариун сүм рүү хол замд явах автобусандаа суух хүртлээ гэр бүлийн нэрсийг бэлэн болгохын төлөө шаргуу ажилладаг ба ердийн тогтсон цөөнийг бус харин маш олон нэрс цуглуулаад авч явдаг.

Ахлагч Күк ба Ахлагч Клэйтон нар Гэгээнтнүүдийг Их Эзэн Есүс Христэд итгэх итгэлээ өсгөх, гэр бүлүүдээ хүчирхэгжүүлэх, бусадтай сайн мэдээ идэвхтэй хуваалцах мөн гэр бүлийн түүх ба ариун сүмийн ажлыг үргэлжлүүлэн хийхээр чармайх зэрэг үндсэн дөрвөн чухал зүйлийн төлөө тэмүүлэхийг уриалсан. ■

Франсис Ж.Монсон таалал төгсөв

Би Франсисийг анх харсан өдрөө л зөв хүнээ олсноо мэдсэн юм” хэмээн Ерөнхийлөгч Томас С.Монсон өөрсдийн анх үерхсэн тухайгаа дурсан ярьжээ.¹ Тийн хэлсэн нь Франсис Бэвэрли Жонсон Монсоны амьдралынхаа турш нөхрийнхөө хамт хийсэн үйлчлэл болон түүнд түшиг тулгуур болж байснаар дахин дахин батлагдсан юм.

2013 оны 5-р сарын 17-ны өдөр Монсон эгч 85 насандаа амар амгалан таалал төгслөө. Ийнхүү түүний мөнх бус амьдрал эцэслэв.

Хэзээ ч бусдын анхаарлыг өөртөө татдаггүй байсан Монсон эгч, Ерөнхийлөгч Монсоныг өндөр настай, өвчтэй хүмүүсийг эргэн очиход нь үргэлж дагалдан явдаг байлаа. Тэрээр нөхрөө залуухан байхдаа бишпоор дуудагдах үед түүний эрч хүчний ундарга байсан бөгөөд 1959-өөс 1962 онд Канадын Номлолыг тэргүүлэхэд нөхрийнхөө хамт үйлчилсэн юм. Түүний хайрт “Томми”-г Ерөнхий эрх мэдэлтнээр дуудагдах, мөн Арванхоёрын Чуулга, Тэргүүн Зөвлөлд болон Сүмийн Ерөнхийлөгчөөр үйлчлэх үед тэрээр хамт тууштай үйлчилсээр байсан билээ.

“Эцгийг минь эрхэмлэн хайрлаж, түүнд өгөгдсөн авьяас билгийг олж харан, түүнийгээ хөгжүүлэхэд нь дэмжин туслахдаа тэр сэтгэл хангалуун байдаг байлаа” гэж охин Анн Монсон Дибб өгүүлжээ.²

Франсис нь 1927 оны 10-р сарын 27-ны өдөр Франц И.Жонсон болон Хилдэр Бүүт Жонсон нарын охин болон мэндэлжээ. Тэрээр 1948 оны 10-р сарын 7-нд Томас С.Монсонтой Солт Лэйкийн ариун сүмд гэрлэсэн. Тэрээр Нийгмийн Халамж болон Хүүхдийн хэсгийн дуудлагуудад үйлчилж байсан ба авьяаслаг хөгжимчин, хошин мэдрэмж сайтай нэгэн байсан бөгөөд эхнэр, ээж, эмээ, элэнц эх байхдаа хамгаас илүү дуртай байв.

Дибб эгч, ээжийнхээ талаар дурсан ярихдаа “Тэр ямар ч үед намайг сонсож, бас миний оронд байсан бол юу хийх байсан талаараа товчхон хэдэн үг хэлэх чухал хүн маань байлаа. . . . Түүний тууштай үлгэр дууриалал . . . миний амьдралд хамгийн ихээр нөлөөлсөн юм. Түүний юунд итгэж, юу хийх, бусдыг юу хийгээсэй гэж бодож байгаад ямар ч эргэлзээ төрдөггүй байлаа.



Ерөнхийлөгч болон Монсон эгч 2010 оны 4 сарын ерөнхий чуулганы хуралдааны дараа

Хожмын Үеийн Гэгээнтэн, Христийн шашинтны хувьд та бид ямар байх ёстойг тэр харуулсан юм”³ гэжээ.

“Миний Сүмийн үүрэг хариуцлагын талаар Франсис нэг ч удаа гомдоллож байсныг би огт санадаггүй” хэмээн Ерөнхийлөгч Монсон өгүүлсэн аж. Тэрээр эхнэрийнхээ талаар “төлөв даруу, маш их хүчирхэг итгэлтэй эмэгтэй” хэмээн хэлжээ.⁴ ■

Эшлэл

1. Томас С.Монсон, “Элбэг дэлбэгээр адислагдах нь” *Лиакхона*, 2008 оны 5-р сар, 111.
2. Анн М.Дибб, “Франсис Ж.Монсон, Ерөнхийлөгч Томас С.Монсоны эхнэр таалал төгсөв” (2013 оны 5-р сарын 17), mormonnewsroom.org.
3. Анн М.Дибб, “Франсис Монсон: Охин Анн Монсон Диббийн нүдээр” (Mormon Times видео бичлэг, 2013 оны 5-р сарын 12), ksl.com.
4. Томас С. Монсон, Жэффри Р.Холландын эш татсанаар “Ерөнхийлөгч Томас С.Монсон: Эзний хөлийн мөрөөр,” *Лиакхона*, хавсралт, 2008 оны 6-р сар, 8.

КАРИБЫН БҮС БА СҮМИЙН МЭДЭЭ-НИЙ ГЭРЭЛ ЗУРАГ



Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Нийл Л.Андэрсэн Гаитид сүм байгуулагдсаны 30 жилийн ойн баярын дурсгалын самбарын хөшиг нээх ёслолыг тэргүүлэн оролцлоо.

Гаити сүм байгуулагдсаны 30 жилийн ойгоо тэмдэглэж байна

Гучин жилийн өмнө тухайн үед Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн байсан Ерөнхийлөгч Томас С.Монсон Гаитид зочилж, сэргээгдсэн сайн мэдээг номлолын төлөө уг газар нутгийг онцгойлон адисласан юм.

Саяхан Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Нийл Л.Андэрсэн ойн арга хэмжээнд оролцохоор Гаитид зочиллоо. Ахлагч Андэрсэн сүм Гаитид үүсэн байгуулагдсаныг үргэлжид санагдуулах дурсгалын самбарын хөшиг нээх ёслолыг тэргүүлэн оролцлоо. Баярын ёслолыг үзэхээр цугласан гишүүд уг арга хэмжээнд зориулан урьдчилан бэлтгэсэн Ерөнхийлөгч Монсоны захиасыг телевизээр үзлээ.

Сүм 2012 онд байгалийн гамшигт өртсөн 100 гаруй газруудад тусламж үзүүлэв

Жил бүр Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм дэлхий даяар байгалийн гамшиг, дайн, өлсгөлөнд өртсөн хүмүүст тусламжийн гараа сунгадаг. 2012 оны турш сүм 52 улс оронд тохиолдсон 104 удаагийн байгалийн гамшигт өртсөн хүмүүст зуун мянган тонн хоол хүнс, цэвэр ус, хувцас, эмнэлгийн хэрэгсэл, ариун цэврийн хайрцаг болон бусад хэрэгцээт зүйлсээр хангажээ. Мөн түүнчлэн мянга

мянган гишүүд 1,3 сая гаруй цагийн сайн дурын үйлчлэл хийсэн байна.

2012 онд тохиолдсон байгалийн гамшигт сүмийн үзүүлсэн хамгийн том тусламж бол Нэгдсэн Улсын Зүүн эрэг дэх Санди хар шуурганд өртөгсдөд үзүүлсэн тусламж байлаа. Санди хар шуурганаас гадна 2012 онд сүм Япон, Филиппин, Нэгдсэн Улсын бусад бүс нутгууд болоод Сири улсад тохиолдсон гамшгуудад тусламжийн гараа сунгасан билээ.

Гэр бүлийн мод (FamilyTree) олон нийтэд хүртээмжтэй боллоо

Сүмийн FamilySearch.org интернет сайтын удаан хүлээгдсэн шинэчлэл болох Гэр бүлийн мод (FamilyTree) нь 2013 оны 3-р сараас олон нийтэд нээлттэй боллоо. Үүнийг FamilySearch.org руу үнэгүй нэвтэрч ашиглах боломжтой.

Гэр бүлийн мод (FamilyTree) нь одоог хүртэл зөвхөн сүмийн гишүүн нэвтрэх боломжтой байсан New FamilySearch (Шинэ Гэр бүлийн түүхийн хайлт)-г орлох болно.

Одоо FamilySearch.org-ын бусад хэрэглэгчид “өөрсдөөсөө эхлэн өнгөрсөн үе удмынхныхаа дэлгэрэнгүй ургийн модыг интернетэд байгуулах бүрэн дүүрэн боломжтой болох болно” хэмээн FamilySearch маркетингийн менежер Паул М.Наута хэллээ.

Энэ нь надад илүү шаргуу хичээхэд тусалдаг

Би *Лиахонад дуртай!* Үүнийг уншихад маш сайхан байдаг. Би үүнийг коллеж руугаа авч яван, найз нартаа өгөх дуртай. Өгүүллэгүүд нь илүү сайн хүн болж, номлолын ажил хийн, зөвийг сонгоход минь тусалдаг. Сэтгүүлийг судлах үед би өдөр бүр илүү сайн хүн болж, Есүс Христийг дагахын тулд илүү хичээж байгаагаа олж хардаг.

Анастасия Напрасникова, Украин

Сүнслэг болон дэлхийн амьдралын луужин

Лиахона миний гэрчлэлийг хүчирхэгжүүлдэг. Энэ нь сүнслэг болоод дэлхийн амьдралын луужин юм. Ерөнхий Эрх Мэдэлтнүүдийн үгсийг унших нь Есүс Христэд илүү ойр болоход минь тусалдаг. Номлогчийн хувьд олон хөрвөгч гэгээнтнүүдийн гэрчлэлүүдийг унших нь намайг тайвшруулж, Эзэний талбай дахь үр бүтээлтэй ажилчин байхад минь тусалдаг.

Ахлагч Гомун, Бэнин Котоноу номлол

Залруулга

2-р сарын *Лиахона* сэтгүүлийн 27-р хуудас дээр Дима Иванов нь Оросын Владивосток хотод амьдардаг хэмээн бичсэн ч тэрээр үнэндээ Оросын Улаан-Үд хотод амьдардаг ажээ.

НАЙДВАРЫН ЗАМААР ХАМТДАА АЛХСАН МИНЬ

ЛаРин Портер Гаунт

Сүмийн сэтгүүлүүд

Намайг Найдварын замаар анх алхалж явахад Наувуд хаврын эхэн сар байлаа. Гурван урсгалтай замаар уруудан алхахад нар алтан шаргал туяа цацруулан, сүүдэр газарт ч дулаахан байлаа. Би гэрэл зурагчны хувьд аппаратынхаа хаалтыг түргэн гэгч нь цэлийтэл онгойлгоход сэтгэл татам сайхан гэрэл аппаратын дуранг дүүргэв.

Энэ замаар алхалж явсан өвөг дээдсийн минь тухай бодол зүрх сэтгэлийг минь алгуурхан эзэмдлээ. Хамгийн түрүүнд Жаред, Корнелиа нар хоёр настай бяцхан хүүгийнхээ хамт миний санаанд орж ирэв. Хүйт даасан жаврыг би мэдэрсэн ч, энэ нь өрнөд нутаг руу хийсэн хүнд хүчир аяны үед Жаред болон түүний гэр бүлд тохиолдсон хүнд сорилтын дэргэд юу ч биш юм. Корнелиа Науву, Солт Лейк хоёрын хооронд хаа нэгтэй нас баржээ. Жаред уйлан хайлж, хүүтээ өргөн тэвэрч аваад аяны замаа цааш нь хэрхэн хөөгөө бол гэдгийг би төсөөлөн бодлоо.

Тэдний тухай бодол намайг орхин одох вий гэхээс айсандаа би зогсолтгүй зураг дарсаар, нүдэнд минь нулимс цийлэгнэж, харагдах зүйлс бүрэлэж байлаа. Тэгээд би Наувуг орхин явсан Гэгээнтнүүдийн сүүлчийн бүлэгтэй, хайрт хойд ээжийнхээ хамт явсан бяцхан Сараг саналаа. Хайраар дүүрэн Тэнгэрлэг Эцэг тэднийг хоолохын тулд нэг удаа буудалд нь үй олон бөднө шувууг илгээсэн ажээ. Тиймээс тэд зүрх сэтгэл нь талархлаар дүүрэн цааш аяны замаа хөөжээ.

Сэтгэл догдлон, цээжинд минь баяр талархал багтаж ядан, бяцхан Сара хажууд минь байгаа юм шиг санагдлаа! Жаред,



Хожмын Үеийн Гэгээнтэн анхдагчид 1846

оны 2-р сард Наувугаас хөөгдсөн юм. Тэд

Сионд амар амгаланг олох болно гэсэн агуу

итгэлтэйгээр эдүгээ

Найдварын зам хэмээн

нэрлэгддэг Парлийн

гудамжаар алхлан

Миссиппи мөрнийг


гатлан өрнө зүг одсон

билээ.

Корнелиа хоёр ч бяцхан хүүгийнхээ хамт миний дэргэд байгаа юм шиг санагдлаа. Бид энэхүү найдварын замаар, үхэл хагацал, нулимсын энэхүү замаар гэрэл ба сүүдэр, одоо ба өнгөрсөн үеийн зааг дундуур хамтдаа алхалж явлаа. Тэд юуны учир ийнхүү миний сэтгэл зүрхэнд надтай хамт байгааг, Есүс Христийн сайн мэдээнээс ирдэг хайраа хуваалцахад намайг өдөөн сэрээсний учрыг би тайлбарлаж чадашгүй нь. Зүрх сэтгэлд миний гэрчлэл шатах лугаа адил төөнөж байгааг би мэдэрлээ. Учир нь гэвэл, яг ийм гэрчлэл тэдний зүрх сэтгэлд нэг үеийнхнээс дараагийн үеийнхэнд уламжлагдан, суурь нь тавигдсаар ирсэн билээ. Би баярын нулимс дуслуулан уйллаа.

Өөр хаа нэгтээ зураг авч байсан нөхөр минь удалгүй хүрч ирлээ. Би нөхөртөө тулж зогсоод өөртөө төрсөн мэдрэмжийн тухай түүнд ярилаа. Нөхөр минь Наувугийн Гэгээнтнүүдийн нэгэн адил, гэр бүлээсээ сайн мэдээнд итгэсэн анхны хүн юм. Тэр бас 150 жилийн тэртээ энэ замаар алхалж явсан хүмүүсийн нэгэн адил, хамгийн түрүүнд итгэгч байсан юм. Жаред, Корнелиа, Сара нарын гэрчлэл мянга мянган үр удмынхныхаа гэрчлэлийг хөгжүүлсэн шиг нөхөр бид хоёрын гэрчлэл эдүгээ бидний хүүхдүүдийн зүрх сэтгэлд шатах лугаа адил төөнөж буй гэрчлэлийн суурийг тавин хөгжүүлсэн юм.

Нөхөр бид хоёр гэрэл зургийнхаа тухай мартан Найдварын замын үлдсэн хэсгээр аажуухан алхлахдаа энэ замаар алхалж явсан анхдагчдын тухай чимээгүйхэн дурсан санаж билээ. ■



ИОСЕФ Ф.СМИТ

Иосеф Ф.Смит Иллинойн Наувугаас Ютагийн Солт Лейк хот руу гэр бүлийнхээ **үхэр тэргийг** жолоодож явахдаа долоо настай байлаа. 15-тай байхдаа, тэр **Хавайд** номлолд үйлчилжээ. Хожим нь тэр Сүмийн Ерөнхийлөгч байхдаа Хавайн Лаиэгийн Ариун сүм баригдсан газрыг адисалсан ажээ. Хэрэв хүмүүс Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн итгэлийг ойлгох юм бол Сүмийг хавчих нь бага байх болно гэдэгт Иосеф итгэдэг байлаа. Сүмийн итгэлийг тайлбарласан түүний сургаалын заримыг ***Gospel Doctrine (Сайн мэдээний сургаал)*** номонд түүвэрлэн оруулжээ.



Арванхоёр Төлөөлөгчийн Чуул-
гын Ахлагч М.Рассел Баллард
ийн бичжээ, “Итгэл бишрэл
Бурханы Сүнсээр бидний бодгальд
төлөвшсөн үед итгэл нь бидний
бодол санаа, үг яриа, үйлдэл бүрийг
тэнгэр өөд чиглүүлж, бидний амьд-
ралд чухал нөлөө үзүүлдэг. Бид анх-
дагчдын нэгэн адил хүч чадал ба
удирдамжийн төлөө итгэлтэйгээр
залбирдаг. Энэ нь алхам тутамдаа
итгэлээр амьдарна гэсэн үг юм. Ма-
най анхдагч өвөг дээдэс ийнхүү ит-
гэлээр амьдардаг байсан, өнөөдөр ч
бид ийм л байх ёстой.” “Анхдагчдын
итгэл ба тэсвэр хатуужил тэр үед
болон өнөөдөр,” хуудас 16-ыг үзнэ үү.

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ